

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
САЛБАРТ ХАМААРАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА
/2020 оны эхний хагас жилийн байдлаар/

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан тус салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тухайн онд тавьсан зорилт, хүрэх түвшинтэй харьцуулан хэрэгжилтийг тооцох, үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, дараагийн шатны төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНДЭСЛЭЛ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ.

Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов. Ингэхдээ Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн 2020 оны эхний хагас жилийн тайланг судлах, Монгол Улсын болон барааны экспорт, импортын статистикийн мэдээлэлтэй тулгаж шалгах, холбогдох мэргэжилтнүүдтэй уулзаж ярилцах, тодруулга авах арга хэлбэрээр хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын бодит үр дүнг хүрэх түвшинтэй харьцуулан биелэлтийг хувиар тодорхойлж үнэлгээг гаргалаа. Үүнд: “үр дүнгүй” - 0, “эрчимжүүлэх шаардлагатай” - 40, “тодорхой үр дүнд хүрсэн” - 70, “үр дүнтэй” - 100 хувь, холбогдох журмын 6.2.1.5 дахь заалтыг үндэслэн “үнэлэх боломжгүй” үнэлгээг гаргалаа.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН.

Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах нийт 173 зорилт, арга хэмжээнээс үндсэн хэрэгжүүлэгчээр 137, бусад яам, байгууллагатай хамтран хэрэгжүүлэх 12, аймаг, орон нутагт тусгайлан хэрэгжүүлэх 24 зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв. Нийт 173 зорилт, арга хэмжээнээс 23.7 (41) хувийг 2016-2020 онд, 60.1 (104) хувийг 2017-2020 оны хооронд хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах нийт 173 зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн 2020 оны эхний хагас жилийн үнэлгээний дундаж 69.7, үүнээс үндсэн хэрэгжүүлэгчээр ажилласан 137 зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээний дундаж 68.9, хамтран хэрэгжүүлэгчээр ажилласан нийт 36 зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээний дундаж 72.7 хувьтай тус тус байна.

Үнэлгээ		Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээ		
		Нийт /173/	Үндсэн /137/	Хамтран /36/
Үр дүнтэй	100%	35	28	7
Тодорхой үр дүнд хүрсэн	70%	96	73	23
Эрчимжүүлэх шаардлагатай	40%	32	28	4
Үр дүнгүй	0%	2	2	-
Үнэлэх боломжгүй	Үнэлэх боломжгүй	8	6	2
Хэрэгжилтийн дундаж		69.7%	68.9%	72.7%

Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгийн чанарын үзүүлэлт

Үнэлгээ	Нийт арга хэмжээ		Үндсэн хэрэгжүүлэгч		Хамтран хэрэгжүүлэгч	
	Тоо	эзлэх хувь	Тоо	эзлэх хувь	Тоо	эзлэх хувь
100	35	20.2	28	20.4	7	19.4
70	96	55.5	73	53.3	23	63.9
40	32	18.5	28	20.4	4	11.1
0	2	1.2	2	1.5	0	-
ҮБгүй	8	4.6	6	4.4	2	5.6
Дүн	173	100.0	137	100.0	36	100.0

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан үндсэн зорилтуудын хэрэгжилтүүдийн үнэлгээ.

№	Зорилтын нэр	АХ тоо	Дундаж үнэлгээ
1	Эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого	2	70.0
2	Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах	134	68.9
3	Нийгмийн бодлого	5	70.0
4	Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого	5	70.0
5	Засаглалын бодлого	3	70.0
6	Аймаг, орон нутгийн талаар тусгайлан оруулах заалтууд	24	73.9
Дүн		173	69.7

Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг 2018 оны эхний хагас жилийн үнэлгээтэй харьцуулахад 12.4%, 2019 оны эхний хагас жилийн үнэлгээтэй харьцуулахад 20.8% хувиар тус тус 2020 оны эхний хагас жилийн хэрэгжилт сайжирсан байна.

№	Он	2018 оны эхний хагас	2019 оны эхний хагас	2020 оны эхний хагас
1	Үнэлгээний дундаж хувь	56.5	48.1	68.9

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ.

1. Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангаар дамжуулан тайлагнаж хэвшиж байгаа нь тайлагналтын чанар, хугацаандаа тайлагнах асуудалд эерэгээр нөлөөлж байна. Мөн 2020 оны эхний улирлын байдлаар хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн нь тайлагналт, үнэлгээнд эерэгээр нөлөөллөө.

2. 2020 оны эхний хагас жилийн байдлаар нийт 173 арга хэмжээний хэрэгжилт 69.7, үндсэн хэрэгжүүлэгчээр ажилласан 137 арга хэмжээний хэрэгжилт 68.9, хамтран хэрэгжүүлэх 36 арга хэмжээний хэрэгжилт 72.7 хувьтай тус тус дүгнэгдлээ.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэрэгжилтийн дундаж үнэлгээ 20.8 хувиар сайжирсан байна.

3. Ковид - 19 цар тахалтай холбоотойгоор хэрэгжилт хангагдаагүй 6, Засгийн газрын тогтоолоор хасагдсан 2 арга хэмжээний хэрэгжилтэд "Үнэлэх боломжгүй" үнэлгээ өгөв. Нийт 2 арга хэмжээ /2.15.1, 2.56.3/ "үр дүнгүй" буюу 0 үнэлгээтэй байна.

4. Салбарт 2019 онд шинээр батлагдсан үндэсний хөтөлбөр /"Эрүүл хүнс-эрүүл Монгол хүн", "Монгол малчин", "Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөр"/-ийн хэрэгжилтийн үнэлгээ хангалтгүй байна.

5. Төлөвлөгөөнд тусгагдсан зарим хууль /"Бэлчээр хамгаалах тухай", "Худалдааны тухай", "Зөвлөх үйлчилгээний тухай", "Мал аж ахуйн хөгжлийг дэмжих тухай", "Тариалангийн даатгалын тухай", "Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай"/, үндэсний хөтөлбөр /"Мэргэжилтэй ажилтан"/ батлагдаагүй байсаар байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ.

1. Цаашдын төлөвлөлтийг хийхдээ хязгаарлагдмал нөөц, цаг хугацааны хүчин зүйлийг оновчтой тооцож байх. Төлөвлөлтийн алдаа нь хэрэгжилтийн үнэлгээнд сөргөөр нөлөөлөх гол хүчин зүйл болж байна.

2. Төрөөс баримтлах бодлогууд болон үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн үйл ажиллагааны тайланд хавсаргаж ирүүлэх, тэдгээрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх,

3. Зорилт, арга хэмжээг тайлагнахдаа суурь түвшинтэй хүрсэн түвшинг харьцуулан дүгнэх, төсвийн зарцуулалтын бодит гүйцэтгэлийг тусгах талаар онцгойлон анхаарах зэрэг болно.

ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, 2020 оны хагас жил

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2020 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ОНЦГОЙ БОДЛОГО							
1	1.17.5-аас доошгүй жил тасралтгүй үйл ажиллагаа эрхэлж, байнгын ажлын байр шинээр бий болгосон хөнгөн, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ.	2. Чиглэлийн яамд, холбогдох байгууллагуудтай хамтран уян хатан нөхцөлтэй зээлээр хөнгөн үйлдвэр, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх	2017 - 2020	Хөгжлийн банк, Төрийн банк, Капитрон банкнаас нийт 56.1 тэрбум төгрөгийг нийт 19 ААН-д олгосон.	Хамрагдсан ААНБ-ын үйл ажиллагаа тогтворжих, ажлын байр бий болох	Цар тахлын улмаас хилийн хязгаарлалт тавьсантай холбогдуулан ноолуурын үнийн уналтаас хамгаалах, үндэсний үйлдвэрүүдийг чанартай түүхий эдээр хангах, малчдын орлогыг тогтвортой байлгах, экспортыг дэмжих зорилгоор ЗГ-ын 2020 оны 101 дүгээр тогтоолоор Хөгжлийн банкны эх үүсвэрээр 300 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг ноолуур бэлтгэх зориулалтаар үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд нэг жилийн хугацаатай 3 хувийн хүүтэй олгохоор шийдвэрлэсэн. “Ноолуур бэлтгэлийн зээлийн хүүгийн хөнгөлөлтийн зардлыг санхүүжүүлэх тухай” Хөгжлийн банк, СЯ, ХХААХҮЯ хамтарч гурвалсан гэрээ байгуулсан. Тус тогтоолын хүрээнд Хөгжлийн банк, Төрийн банк, Капитрон банкнаас 19 аж ахуйн нэгж 56.1 тэрбум төгрөгийн зээл авсан байна. “ЖДҮХС-гаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын хүрээнд 2020 онд ЖДҮХС-гаас хөнгөлөлттэй зээл авах хүсэлтийг 2020.05.19-ны дотор Нийслэл, 21 аймагт нэгэн зэрэг хүлээн авч төсөл сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж байна. Төсөл хүлээн авах ажлын хүрээнд шинэчлэн батлагдсан хууль болон журмыг олон нийтэд таниулах мэдүүлэх ажлыг ЖДҮХС-гийн зүгээс улс оронд үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан цахим орчин болон утсан харилцаа холбоог ашиглан ажиллаа. ЖДҮХС-гаас 21 аймгийн ХХААГ-ын дарга болон ЖДҮ хариуцсан мэргэжилтэн, нийслэл болон 9 дүүргийн ЖДҮДТ-ийн 70 гаруй мэргэжилтэнг хамруулан ЖДҮҮХ тухай хууль болон шинэчлэн батлагдсан журмын талаарх мэдээлэл, сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан. 2020 оны төслийн материалыг цахимаар хүлээж авч байгаатай холбогдуулан цахимаар хэрхэн хүсэлтээ илгээх талаар видео шторк бэлтгэн ХХААХҮЯ болон ЖДҮХС-гийн вэб, цахим хуудаст байршуулсан. 2020 оны төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагааны I үе шат буюу иж бүрдлийг шалгах үйл ажиллагааг 2020 оны 06 сарын 25-ны дотор дуусгахаар ЖДҮХС-д 6 болон 21 аймагт ажлын хэсэг ажиллаж байна.	70%

2	1.23. "Үндэсний үйлдвэрлэл" хөтөлбөрийг хэрэгжүүлж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.	1. Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд "Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр", "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр" боловсруулж хэрэгжүүлэх	2017 - 2020	Нийт I шатанд 213,83 тэрбум төг зарцуулсан. Үүнээс: ЖДҮХС-3,5, улсын төсвөөс 20,6, Хөгжлийн банк-21,6, Орон нутаг хөгжүүлэх сан-1,2, гадны хөрөнгө оруулалтаар-162,0, хувийн хэвшил-73,0, бусад-4,2 тэрбум төгрөг	Хөтөлбөр хэрэгжих	Засгийн газрын 2018 оны 36 дугаар тогтоолоор баталсан "Үйлдвэржилт 21:100" үндэсний хөтөлбөрийн хүрээнд бүрэн ашиглалтад орсон 42 үйлдвэр, бүтээн байгуулалтын ажил хийгдэж буй 19 үйлдвэр, ЖДҮХС, Улсын төсөв, Орон нутаг хөгжүүлэх сан, гадны хөрөнгө оруулалтаар 11 үйлдвэр ашиглалтад орж, нийт 72 үйлдвэр 2018-2019 онд байгуулагдсан. Үүнээс УБ хотод 5, орон нутагт 67 үйлдвэр /2017 онд 2, 2018 онд 22, 2019 онд 48 / шинээр болон үйл ажиллагаагаа өргөжүүлж, 4000 орчим ажлын байр бий болсон байна. Хөтөлбөрийн хүрээнд ЖДҮХС-аас 3.5 тэрбум төгрөг, улсын төсвөөс 20,6 тэрбум төгрөг, Хөгжлийн банкнаас 21,6 тэрбум төгрөг, Орон нутаг хөгжүүлэх сангаас 1.2 тэрбум төгрөг, гадаадын хөрөнгө оруулалтаар 162 тэрбум төгрөг, хувийн хэвшлээс 73 тэрбум төгрөг, бусад хөрөнгө оруулалтаар 4.2 тэрбум төгрөгийн санхүүжилт тус тус хийгдсэн байна. Хөтөлбөрийн дүнд нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 2020 оны хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 12 хувь, арьс, ширэн түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 40 хувь, ноос, ноолууран түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 25.2 хувьд хүрсэн байна.	70%
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО							
3	2.1. Монгол Улсын Үйлдвэржилтийн газрын зургийг гаргаж, хүнд аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	1. Монгол Улсын Үйлдвэржилтийн газрын зургийг экосистем, хүн амын нутагшил, суурьшил, түүхий эдийн нөөц, дэд бүтцийн бодлоготой уялдуулан гаргах	2017			Үндэсний хөгжлийн газар/ҮХГ/-аас Аж үйлдвэрийн цахим мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн Монгол Улсын аж үйлдвэржилтийн хөгжил, байршлын орон зайн нэгдсэн төлөвлөлт, зураглалыг ArcGIS программ дээр боловсруулж Монгол Улсын хөдөө аж ахуйн үйлдвэр технологийн паркийн оновчтой байршлыг тодорхойлсон. Бүсчилсэн хөгжлийн бодлого боловсруулах ажлын хүрээнд Үйлдвэржилтийн хөгжил, байршлын бодлогын судалгааны ажлыг ҮХГ-ын даргын 2018 оны А-48, А-49 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулж, зөвлөх сонгон шалгаруулж, зөвлөхүүдээр гүйцэтгүүлсэн байна. Монгол Улсын Үйлдвэржилтийн газрын зургийг гаргаж, хүнд аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх ажлын хүрээнд үйлдвэржилтийн газрын зургийн төсөлд холбогдох саналыг тусгуулж, УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 8 сарын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг, Үндэсний хөгжлийн газартай хамтран ажиллаж, хөтөлбөрийн төслийг боловсруулан Засгийн газрын 2019 оны 214 дүгээр тогтоолоор Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг батлуулсан. Засгийн газрын 2018 оны 36 дугаар тогтоолоор "Үйлдвэржилт 21:100" үндэсний хөтөлбөр, ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А-07 дугаар тушаалаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус тус батлуулж, хөтөлбөрийн хүрээнд байгуулах үйлдвэрийн байршлын тойм зургийг Газар зохион	100%

					байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтран орон зайн өгөгдлийн дэд бүтцийн мэдээллийн сангийн Монгол улсын газрын зураг дээр online хэлбэрээр /цахим хаяг: https://geoportal.nsd.gov.mn/ байршуулсан.	
4	2.7. Стандартчилал, хэмжил зүйн талаархи хууль тогтоомжийг олон улсын нийтлэг зарчимд нийцүүлэн шинэчилж, “Үндэсний чанарын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.	4. Экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үндэсний стандартыг шинэчлэх хүрээнд олон улсын болон европын стандартуудыг үндэсний болгох, нутагшуулах	2017 - 2020	5 стандартыг үндэсний болгох	ХХААХҮЯ-ны 2020 оны төлөвлөгөөнд “Хөнгөн үйлдвэрлэлийн салбарт шаардлагатай стандартыг шинээр батлуулах, шинэчлэх, орчуулах ажлыг тусган, төсөвт 21,0 сая төгрөгийг батлуулсан. Олон улсад дэгдсэн шинэ коронавирус (Covid 19)-ийн халдвар дэгдсэнтэй холбогдуулан өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж төсөв хэмнэлтийн горимд шилжиж, тус ажлыг 2020 оны хоёрдугаар хагаст гүйцэтгэхээр хойшлуулсан. УОК-ын 2 дугаар сарын 10-ны өдрийн хурлаар даавуун амны хаалтын үйлдвэрлэлд анхаарч, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх талаар үүрэг өгөгдсөнтэй холбогдуулан олон улсын стандартуудыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран судалж, даавуун амны хаалтын стандартын төслийг боловсруулж, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны С/09 тушаалаар MNS6828:2020 “Даавуун амны хаалт”-ын стандартыг батлуулсан. Цаг үеийн нөхцөл байдлыг харгалзан үзэж уг стандартыг үйлдвэрлэгчдэд төлбөргүйгээр тарааж үйлдвэрлэлд өргөнөөр нэвтрүүлж байна. Арьс ширний олон улсын зөвлөл (Leather Working Group) -ийн байгаль орчны стандартыг нэвтрүүлэх урьдчилсан аудит болон сургалтуудыг НҮБ-ын ЮНИДО төслөөс Дархан Нэхий, Дархан Минж болон Улаанбаатар дахь боловсруулах үйлдвэрүүдэд зохион байгуулж, цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг сайжруулах, стандартуудыг нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлж байна. “Байгалийн ба органик гаралтай гоо сайхны бүтээгдэхүүний орц найрлага болон бүтээгдэхүүнд тавигдах шаардлага” ISO 16128 стандартыг Гоо сайхны бүтээгдэхүүний ISO/TC 217 техникийн хороогоор хэлэлцүүлж батлуулав. “Нялх балчир хүүхдийн хоол тэжээл болон тусгай зориулалтын хүнсэнд тавих шаардлага” /CAC72:81/, “Сүү, сүүн бүтээгдэхүүний тослог тодорхойлох хурдавчилсан арга” /ISO 2446:2008/ орчуулан боловсруулж СХЗТ-ийн техникийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр хүргүүлсэн.	70%
5	2.9. Үйлдвэрлэлд ашиглагддаг уур, ус, дулаан, цахилгааны тарифыг тогтвортой байлгаж,	1. Үйлдвэрлэлд ашиглагддаг уур, ус, дулаан, цахилгааны тарифыг тогтвортой байлгах, бууруулах замаар бүтээгдэхүүний	2017 - 2020	Хэрэгжилтийг хангаж ажиллах	Коронавируст халдвар /Covid-19/-ын цар тахлын үед аж ахуйн нэгжид учирч байгаа сөрөг нөлөөг саармагжуулах, санхүү эдийн засгийн тогтвортой байдлыг хангах талаар бүх талын арга хэмжээг авч ажиллах үүрэгтэй “Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан гамшгийн эрсдэлээс хамгаалах штаб”, “Түүхий эдийн үнийн уналт, хангамж, зарцуулалт, үйлдвэрлэл борлуулалт, экспорт, нэн шаардлагатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хангамжийг зохицуулах	70%

	аажмаар бууруулах бодлого баримтална.	өртгийг багасгах бодлого хэрэгжүүлэх			хяналт тавих шуурхай штаб"-ыг тус тус байгуулан ажиллаж байна. ХХААХҮЯ, Мэргэжлийн холбоодын нэгдсэн зөвлөл, Монголын Ажил олгогчдын нэгдсэн холбоотой хамтран нөхцөл байдалд судалгаа хийж, үүсч болзошгүй аюулаас урдчилан сэргийлэх, улс орны эдийн засгийг сэргээх иж бүрэн бодит арга хэмжээний саналыг ЗГХЭГ-т ХХААХҮ-ийн сайдын 2020 оны 01/1111 тоот албан бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын 2020 оны 78 дугаар тогтоолоор Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, нийгмийн даатгалын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, ажлын байрны түрээсийг тодорхой хугацаанд хөнгөлж, чөлөөлөх асуудлыг шийдвэрлэсэн. Үйлдвэрлэлд ашиглагддаг уур, ус, дулаан, цахилгаан зэрэг ашиглалтын зардлыг бууруулах арга хэмжээний хүрээнд аж ахуйн нэгж, үйлдвэр эрхлэгчдээс судалгаа авч нэгтгэн, хүсэлтийг ЗГХЭГ-т хүргүүлсэн.		
6	2.10. Малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, тээвэрлэх, боловсруулах нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.	1. Арьс шир, малын гаралтай дайвар бүтээгдэхүүн, ноос, ноолуурыг боловсруулах, зах зээлд нийлүүлэх нэмүү өртгийн сүлжээг бүрдүүлж, хөрөнгө оруулалтаар дэмжих	2017 - 2020	Нийт 56.1 тэрбум төг/Хөгжлийн банк, Төрийн банк, Капитрон банк/	Экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 5 хувиар өсөх	Ноолуурын үнийн уналтаас хамгаалах, үндэсний үйлдвэрүүдийг чанартай түүхий эдээр хангах, малчдын орлогыг тогтвортой байлгах, экспортыг дэмжих зорилгоор Засгийн газрын 2020 оны 101 дүгээр тогтоолоор Хөгжлийн банкны эх үүсвэрээр 300 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг ноолуур бэлтгэх зориулалтаар үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд нэг жилийн хугацаатай 3 хувийн хүүтэй олгохоор шийдвэрлэсэн. Тус тогтоолын хүрээнд Хөгжлийн банк, Төрийн банк, Капитрон банкнаас 2020.06.26-ны байдлаар 19 аж ахуйн нэгж 56.1 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгоод байна. ХХААХҮЯ-ны Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөрийн 4.6-д тусгагдсан "Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалтын зээлийн хүүгийн татаас" 15 тэрбум төгрөгийг олгох ажлын хүрээнд: "Дархан үйлдвэр технологийн парк"-ийн нэгж "Дархан арьс ширний цогцолбор" ХХК-тай зээлийн хүүгийн татаасыг санхүүжүүлж гэрээ байгуулж, хэрэгжүүлэх замаар тус цогцолборын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авах"-ыг даалгасан Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол батлагдсан. Уг төслийг хэрэгжүүлэгчтэй "Гэрээ байгуулах эрх олгох тухай" ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-185 дугаар тушаал батлагдсан. Төсөл хэрэгжүүлэгчтэй 200515/07/165 дугаартай бодлогын гэрээ байгуулав. Цахилгаан түгээх, дамжуулах дэд станцын барилга, дулааны шугам хоолой татах, ноос угаах, самнах үйлдвэр, арьс шир боловсруулах үйлдвэр, цэвэрлэх байгууламжийн барилгын ажлууд хийгдэж байна. 2020 онд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн эхний 3 блокны ноос боловсруулах үйлдвэрийн барилгын ажил 86%, дэд станцын угсралт 90%, барилга байгууламж 50%, бохир ус цэвэрлэх байгууламжийн ажлын цутгалт 30% хувьтай байна. Богийн арьс шир боловсруулах үйлдвэрийн газар шорооны ажил эхлээд байна.	70%

7	2.15.“Итгэлийн зээл”-ийг олгож, жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй, бичил бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлнэ.	1. “Итгэлийн зээл”-ийг олгож, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх	2017 - 2020		250 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчийг хамруулах	Сум хөгжүүлэх сангийн журмыг шинэчлэн боловсруулж төсөлд сумын иргэдэд "Итгэлийн зээл" хэлбэрээр барьцаагүй зээл олгохоор тусгалаа.	0%
8	2.18. Хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангана.	1. Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын мах, сүүний хэрэгцээг тогтвортой хангах, улирлын хамаарлыг бууруулах зорилгоор гарал үүсэл нь баталгаажсан, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан мал, сүүг үйлдвэр, цехэд нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх эдийн засгийн механизмыг бий болгох, үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, сүүний хэмжээг нэмэгдүүлэх, мах, сүүний нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах, малчдын орлогыг нэмэгдүүлэх	2018 - 2020	32,040.0	Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын хаврын махны хэрэглээний 33.3 хүртэлх хувийг үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махаар хангах, үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээ нийт сүүний 30 хувийг эзлэх	2019* оны урьдчилсан гүйцэтгэлээр үйлдвэрийн аргаар 168.1* сая.литр сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулсан бол 2018 оны мөн үетэй харьцуулахад 24.5%-ийн өссөн үзүүлэлттэй байна. 2019* онд үйлдвэрлэсэн сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2018 оны мөн үетэй харьцуулахад шингэн сүү 5.32%, тараг 1.7%, зайрмаг 4%, цөцгийн тос 43.2%, өтгөн цөцгий 7.1%, өрөм зөөхий 43.8%, бяслаг, аарц 118.5% тус тус өссөн дүнтэй байна. 2020* оны 5 дугаар сарын байдлаар үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хэмжээ 3502.1 тн байна. Бэлтгэж, нөөцөлсөн махыг хөнгөлөлттэй үнээр худалдан борлуулах ажлыг 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөс эхлүүлсэн. Нөөцийн махыг Нийслэлийн 9 дүүргийн 169 хорооны хүнсний 413 дэлгүүрээр дамжуулан хонины ястай мах 6700 төг/кг, үхрийн ястай мах 7700 төг/кг, ямааны мах 6200 төг/кг үнээр худалдаалж байна. Нөөцийн махны худалдаагаар 2020 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар нийт 7951.6 тн махыг нийлүүлээд байна. Үүнээс: үхрийн ястай мах 2038.3 тн, хонины ястай мах 5005.6 тн, ямааны ястай мах 907.3 тн.	70%
9		2. "Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл,	2017 - 2020		Үйлдвэрийн аргаар боловсруулс	Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтын төслийг дахин боловсруулах Ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А-88 дугаар тушаалаар тус яамны	70%

		худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт"-ыг батлан хэрэгжүүлэх, сурталчлах			ан мах, махан бүтээгдэхүүний хэмжээг 60 мянган тнд хүргэх	холбогдох мэргэжилтнүүд, МХЕГ, МЭЕГ, СХЗГ, ШУТИС-ын Үйлдвэрлэл технологийн сургууль, Махны холбоо, хувийн хэвшлийн төлөөллүүдийг оролцуулан байгуулсан. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтын бүтцийг олон улсад мөрдөгдөж буй адилтгах баримт бичгийг үндэслэн гаргаж, Ажлын хэсгийн гишүүдийг мэргэжлийн чиглэлийн дагуу багийн түвшинд хуваан боловсруулах, хийх ажлын чиглэлийг гарган хуваарилсан. Үүний дагуу 2020 оны 5 дугаар сарын 15-ны өдөр багуудын хийсэн ажлын явцыг хурлаар хэлэлцэж, гарсан санал, өөрчлөлт, чиглэлийг тусган дахин боловсруулж ирүүлсэн. Ирүүлсэн төслийг нэгтгэн, 2020 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн хурлаар дахин хэлэлцэв. Техникийн зохицуулалтын төслийн боловсруулалтын гүйцэтгэл 60-70 хувьтай байна. Энэ техникийн зохицуулалтын төслийг 2020 оны 6 дугаар сард багтаан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.	
10		3. Улаанбаатар хотын баруун, зүүн талд эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан, зориулалтын хөргөлттэй агуулах бүхий мах, махан бүтээгдэхүүний орчин үеийн бөөний худалдааны нэгдсэн төв байгуулахыг бодлогоор дэмжиж, мал төхөөрөх үйлдвэр болон ХАА-н биржийн үйл ажиллагаатай холбох шийдэл гарган ажиллах	2019 - 2020		Нийслэлийн баруун, зүүн талд мал эмнэлэг, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан үйлдвэрийн аргаар боловсруулсан махны бөөний худалдааны төв байгуулах	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тус төсөл Улаанбаатар хотын баруун талд буюу Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хорооны 15 га, хотын зүүн талд буюу Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны 14.5 га талбайд хэрэгжиж байна. Хоногт 7500 толгой бог, 1500 толгой бод төхөөрөх хүчин чадалтай үйлдвэр, 11000 тн агуулах, малын зах, худалдааны төв бүхий цогцолбор байгуулах тус төслийн дэд бүтэц баригдсан, бүтээн байгуулалтын ажил 60 хувьтай үргэлжилж байна. Хөгжлийн банкнаас тус төсөлд 2018 оны 2 дугаар сард 6.9 тэрбум, 2019 оны 6 дугаар сард 4.6 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 13.01 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатайгаар олгосон байна. Төслийг эрчимжүүлэх, санхүүгийн богино хугацааны хүндрэлийг арилгах зорилгоор НЗДТГ-аас болон тус компаниас ирүүлсэн албан хүсэлтүүдийг харгалзан бүтээн байгуулалтад шаардлагатай тоног төхөөрөмж, материалын гаалийн болон НӨАТ төлөх хугацааг хойшлуулах талаар санал боловсруулж яамдаас санал авч нэгтгэн ЗГХЭГ-т 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 01/4144 тоотой хүргүүлсэн. Тус тогтоолын төслийг Засгийн газрын 2019 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж дэмжсэн. Засгийн газрын тогтоолын хүрээнд дээрх төслийн бүтээн байгуулалтад шаардлагатай тоног төхөөрөмж, материалын гаалийн болон НӨАТ төлөх хугацааг хойшлуулах 4 талт гэрээг /Сангийн яам, ХХААХҮЯ, Нийслэлийн Засаг дарга, тухайн аж ахуйн нэгж/ байгуулахаар гэрээний төслийг хамтран бэлтгэж, хянуулахаар 2020 оны 5 дугаар сард Сангийн яаманд хүргүүлээд байна.	70%

11		<p>4. Сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх замаар бага насны хүүхдийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор "Үдийн цай" хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн ЕБС-ийн бага ангийн сурагчдад өдөр бүр өгөх сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээг 200 граммд хүргэх</p>	2017 - 2020		ЕБС-ийн 117 мянган хүүхэд хамрагдах	<p>ХХААХҮЯ, НҮБ-ын ХХААБ, АХБ-ны "ХАА-н нэмүү өртгийн сүлжээг дэмжих техник туслалцаа ТА 8960 MON" төсөлтэй хамтран сүүний ач холбогдол, хэрэглээний талаар ТВ, мэдээллийн хэрэгслээр сурталчлах, 21 аймгийн ХХААГ-т мэдээлэл, сурталчилгааны материал "Сүүний ач холбогдол"-ын талаар мэдээлэл хүргүүлэн ажилласан. ЕБС-ийн бага ангийн сурагчдад өдөр бүр өгөх сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээг 200 граммд хүргэх ажлыг хэрхэн зохион байгуулах талаар НҮБ-ын ХХААБ-ын суурин төлөөлөгчтэй уулзалт зохион байгуулсан ба цаашид НҮБ-ын ХХААБ-ын суурин төлөөлөгч бүх талаар дэмжин ажиллахаа илэрхийлээд байна. "Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний жагсаалт"-ыг ХХААХҮ-ийн сайдын тушаалаар батлуулах чиг үүргийн дагуу төслийг боловсруулсан. Жагсаалтын төсөлд малын шингэн сүү, үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүг хэрэглэхээр тусгасан.</p>	40%
12	<p>2.19.Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн экспортлох боломжийг бүрдүүлнэ.</p>	<p>1. Ургамлын гаралтай хүнсийг экспортлох үеийн ургамлын хорио цээрийн шаардлагын тухай протоколыг импортлогч оронтой байгуулах, экспортлох боломжийг бүрдүүлэх</p>	2017 - 2019		<p>Гурилын экспорт өмнөх оноос 15 хувиар нэмэгдэх</p>	<p>Монгол улс, БНХАУ-ын худалдаа, эдийн засаг, хамтын ажиллагааны хүрээнд Хүнсний бүтээгдэхүүний экспорт, импортын аюулгүй байдлын Дэд Сайд нарын 4 дүгээр хуралдааныг 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдөр зохион Бээжин хотноо амжилттай зохион байгуулж, уулзалтаар дараах асуудлыг хэлэлцсэн. БНХАУ-аас Монгол Улсад төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ экспортлох үеийн ургамал хорио цээрийн нөхцлийн тухай протокол"-ыг шинэчлэн байгуулах тухай талууд хэлэлцэв. Хятадын тал Монголын талын хүргүүлсэн төслийг судлан үзэж ажлын хэсгийг ирүүлсэн. БНХАУ-д улаан буудай болон хөх тарианы гурил экспортлох хүсэлт хүргүүлсэн гурил үйлдвэрлэгч 13 аж ахуйн нэгжүүдийн гурилын үйлдвэрт БНХАУ-ын эрсдэлийн хянан магадлагаа хийх ажлын хэсэгтэй хамт 2019 оны 05 дугаар сарын 29-өөс 06 дугаар сарын 11-ний өдрүүдэд ажилласан. БНХАУ-ын эрсдэлийн хянан магадлагаа хийх ажлын хэсгийн дүгнэлтийн хариуг бидэнд 8 сард ирүүлэхээ илэрхийлсэн.</p>	70%
13		<p>2. Монгол малын махны физик, химийн үзүүлэлтийн онцлог, давуу талыг шинжлэн судалж тодорхойлон, олон улсын итгэмжлэгдсэн лабораториор баталгаажуулж, махны экспортыг тогтвортой, урт хугацаанд төлөвлөн тодорхойлох, зах зээлийг өргөтгөх, шинэ зах зээлийг нээх</p>	2017 - 2020		<p>Экспортод гаргах мах, махан бүтээгдэхүүний хэмжээг 50 мянган тнд хүргэх</p>	<p>Явцын 1-р тайлангаар 1. "Бэлчээрийн монгол малын махны чанарын судалгаа" сэдэвт зөвлөх үйлчилгээний S0003/181210/07-533 тоот гэрээт ажлын явцын тайланд хийсэн дүн шинжилгээ, 2. "Бэлчээрийн монгол махны чанарын судалгаа" сэдэвт ажлын явцын 1-р тайлан, 3. Явцын 2 дугаар тайлан өгөх бэлтгэл ажлын хангахаар ажиллаж байна.</p>	70%

14		1. Баяжуулсан хүнсний тухай болон Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай хуулийн төслийг хүн амын хооллолтын хэв маяг, олон улсын чиг хандлагад нийцүүлэн боловсруулах	2017 - 2019			Баяжуулсан хүнсний тухай хуулийг Улсын Их Хурлын 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэн баталсан. Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай хуулийн төслийн Үзэл баримтлалыг батлуулсан. Батлагдсан үзэл баримтлалын дагуу хуулийн төслийг боловсруулсан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу үр нөлөөллийн шинжилгээ, зардлын тооцоог хийх ажлыг зохион байгуулж байна.	70%
15	2.20.Органик болон зохицуулах үйлчилгээтэй хүнсний эрх зүйн орчинг бүрдүүлж, энэ чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх санхүү, хөрөнгө оруулалт, татварын бодлогыг хэрэгжүүлнэ.	2. Органик хүнсний тухай хуульд заасан бүртгэл, баталгаажуулалттай холбоотой журам, аргачлал боловсруулж, батлан мөрдүүлэх	2017 - 2020		5 хүртэлх шилжилтийн үеийн ААН-тэй болох	Монгол Улсын Их хурлаас “Органик хүнсний тухай” хуулийг 2016 онд, холбогдох 4 журам, 1 аргачлал, 1 хэрэглэх бодисын жагсаалтыг 2018 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А-09, А-180 дугаар тушаалаар баталснаар Монгол улсад органик хүнс үйлдвэрлэх эрх зүйн орчин бүрдсэн. ХХААХҮЯ органик болохыг илэрхийлсэн 6 гэрчлэх тэмдгийг оюуны өмчөөр бүртгүүлж, гэрчлэх тэмдгийн 40-0019373 дугаарт бүртгүүлсэн бөгөөд ингэснээр зах зээлд худалдаалагдаж буй баталгаажуулалтад хамрагдаж, бүртгэгдсэн органик хүнсийг хэрэглэгч хялбар таних боломж бүрдсэн. Хэрэглэгч аливаа химийн бодис, пестицид хэрэглээгүй, баталгаажсан, бүртгэлтэй органик болон шилжилтийн үеийн органик хүнсний талаарх мэдээллийг органик хүнсний бүртгэл, мэдээллийн сан www.organic.gov.mn–аас авах боломжтой болсон ба 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар Монгол улсад нийтдээ 12 хамтын баталгаажуулалтын байгууллага, 1 хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллага дотоодын үйлдвэрийн 350 органик болон шилжилтийн үеийн хүнсийг баталгаажуулж, эдгээр нь хэрэглэгчдийн гарт очоод байна. Шилжилтийн үеийн болон органик 100 гаруй аж ахуйн нэгж, үйлдвэрлэгч үйл ажиллагаа явуулж байна. Органик хүнсний тухай хууль, органик хүнсний бүртгэл, баталгаажуулалттай холбоотой батлагдсан журам, аргачлал, жагсаалтыг англи хэл рүү хөрвүүлж, ОХААХОУХ-ны Органик бодлого, баталгаажуулалтын газарт хүргүүлэх зорилгоор "Зардал батлах тухай" сайдын тушаалын төслийг боловсруулсан боловч СХОГ-аас өгсөн чиглэлийн дагуу энэхүү арга хэмжээ нь тэвчиж болох зардлын ангилалд хамаарч буй тул эдгээр баримт бичгийг орчуулах ажлыг гүйцэтгэж, ажил 20%-тай байна.	100%
16	2.21. Аймаг, нийслэл, сум, суурин газруудын хэрэгцээнд тохирсон орчин үеийн дэвшилтэт технологи бүхий	1. Сүүний нөөц ашиглалтыг сайжруулж, үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээг нэмэгдүүлэх	2017 - 2020		Жилдээ 2 загвар үйлдвэр байгуулах	Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын малчдыг түшиглэн сарлагийн сүү бэлтгэх, боловсруулах загвар үйлдвэрийг "Витафит-Милк" ХХК санхүүжүүлэн 2020 оны 06 сарын 22-ны өдөр ашиглалтад оруулан, малчдаас сүү хүлээн авч боловсруулж байна. НҮБ-ын ХХААБ-ын "Монгол улсад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" төслийн хүрээнд Ховд аймгийн Чандмань суманд хоногт 400 литр сүү хүлээн авах хүчин чадалтай бага оврын үйлдвэр төр, хувийн хэвшлийн оролцоотой	100%

	бага, дунд оврын хүнсний боловсруулах жишиг загвар үйлдвэрийг байгуулахыг дэмжинэ.	зорилгоор орон нутагт сүү, сүүн бүтээгдэхүүний бага, дунд оврын загвар үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх				байгуулагдаж орон нутагт ажлын байр нэмэгдүүлж, малчдын орлогыг өсгөхөд эерэг нөлөө үзүүлэн ажиллаж байна.	
17		2. Жимс, жимсгэнэ, чацаргана, ногоогоор эрүүл мэндийг дэмжих /диабет, нүүрс усны өөрчлөлттэй хүмүүст зориулсан/- д чиглэсэн ундаа, шүүс боловсруулах шинэ технологи бүхий загвар үйлдвэр байгуулах ТЭЗҮ-ийг хийх	2018			Хүнсний эслэг ихээр агуулсан жимсний хальс, навч, хүнсний ногоо, ургамал зэрэг эх орны түүхий эдийн шинэ нөөц ашиглан эрүүл мэндийг дэмжих ундаа, шүүсний үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээгээр Ц.Цэвэнтэй ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А-251 дүгээр тушаалыг үндэслэн 2018.06.18-ны өдөр гэрээ байгуулж, ирүүлсэн ТЭЗҮ-ийг 2018.09.28-ны өдөр дүгнэж, хүлээн авсан. Тус ТЭЗҮ нь хүний эрүүл мэндийг дэмжих үйлчилгээтэй, байгаль орчинд сөрөг нөлөөгүй ундааны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, түүхий эд бэлтгэн нийлүүлэх оновчтой тогтолцоог нэвтрүүлэх, ундаан бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг олон улсын түвшинд хүргэх технологи-эдийн засгийн оновчтой шийдлийг агуулсан баримт бичиг болсон. “Эрүүл хүнс–Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн зөвлөлдөх уулзалтыг 2019.06.10-ны өдөр зохион байгуулж, энэ уулзалтын үеэр тус ТЭЗҮ-ийг олон улсын байгууллага, хөтөлбөр, төслийн байгууллагуудад танилцуулсан.	100%
18	2.22.Хүнсний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим санг бий болгоно.	1. Хүнсний болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Органик хүнсний тухай хуулиудад заасан журмын дагуу бүртгэл мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, стратегийн болон гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний тэнцэл, шим тэжээлийн хангамжийг тооцоолох аргачлал, программ боловсруулж нэгдсэн санд холбож, ашиглах	2017 - 2020		Бүртгэл, мэдээллийн цахим сангийн үйл ажиллагаа жигдрэх	Органик хүнсний бүртгэл мэдээллийн сан www.organic.gov.mn хэвийн ажиллаж байна. 2020 оны эхний хагас жилийн байдлаар баталгаажсан, бүртгэлтэй 350 бүтээгдэхүүн, хамтын баталгаажуулалтын 11 байгууллага, хөндлөнгийн баталгаажуулалтын 1 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Импортын органик бүтээгдэхүүний баталгаажуулалтын үйл ажиллагаанд захиргааны хяналт тавих ажлыг тогтмол гүйцэтгэж байна. Хагас жилийн байдлаар 75 бүтээгдэхүүний дагалдах баримт бичгийг хянаж, мэдээллийн санд бүртгэв. "Аствишн" ХХК-тай 2019 оны 06 сарын 24-ний өдөр байгуулсан "Органик хүнсний бүртгэл, мэдээллийн системд техникийн үйлчилгээ үзүүлэх" тухай 191113/08/478 дугаартай гэрээний гүйцэтгэлийг 2020 онд хангуулах тухай сайдын тушаалыг хэрэгжүүлж дараах ажлыг гүйцэтгээд байна. "Сэлэнгэ органик" ХББ, "Органик хөгжил" ХББ-ын хүсэлтийн дагуу Organic.gov.mn цахим хуудасны програм хангамжид 3 удаа өөрчлөлт оруулж, Ворлд Органик Фүүдс ХХК, "Тарва ливинг" ХХК-ий импортын органик бүтээгдэхүүнийг бүртгэхтэй холбоотой мэдээллийн санд үүссэн 2 асуудлыг зохицуулсан.	40%

19	2.23. Иргэдийн эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж, хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл, боловсруулалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын тогтолцоог бий болгож, хүнсний аюулгүй байдлыг сайжруулна.	1. Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн хөтөлбөр хэрэгжүүлэх	2017 - 2020		Хөтөлбөрийн хэрэгжилтийг 70 хувьд хүргэх	Нийслэл, 21 аймгийн Засаг даргын төлөвлөгөөнд "Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн" дэд хөтөлбөр хэрэгжүүлэх заалт туссан. Хүн амын хүнсний шим тэжээлийн боловсролыг дээшлүүлэх, зохистой хооллох дадлыг төлөвшүүлэх зорилгоор "Өглөөний цай" болон "Ээжийн сонголт-Эрүүл хүнс" хөдөлгөөний хэлэлцүүлгийг 2020.01.10-нд Төрийн ордонд зохион байгуулав. Хэлэлцүүлэгт холбогдох төрийн байгууллага болон цэцэрлэг, дунд сургуулиудын удирдлага, багш, мэргэжлийн тогооч нарын төлөөлөл 100 гаруй хүн оролцсон. Хөдөлгөөнүүдийн шторкыг гүйцэтгүүлж олон нийтэд хүргэв. Хүнсний аюулгүй байдал алдагдах үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж ХХААХҮ-ийн сайдын зөвлөлийн 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, төлөвлөгөөг ХАБҮЗ-д хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. "Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн" үндэсний хөтөлбөрийн 3.5.7-д заасны дагуу хүнсний инженерчлэл мэргэжлийн чиглэл Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн жагсаалтад багтсан. Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор "ЖДҮХС-гаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих" журмыг шинэчлэн баталсантай холбогдуулан тэргүүн ээлжинд дэмжих салбар, чиглэлийн жагсаалтад хүнсний тэргүүлэх салбар, чиглэлийг оруулах саналыг хүргүүлсэн. Мал төхөөрөх үйлдвэрлэлийг аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлөөр зохицуулах бодлогын санал, үндэслэл, тайлбарыг бэлтгэж, Зөвшөөрлийн тухай хуулийн төсөлд тусгуулахаар УИХ-ын холбогдох ажлын хэсэгт хүргүүлсэн. УБ хотын хүн амын 2020 оны хаврын улирлын хэрэгцээнд нөөцийн мах хөнгөлөлттэй үнээр худалдах ажлыг зохион байгуулж, 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт 7747.0 тн мах нийлүүлээд байна. Вьетнам улс Ковид –19-ийн халдвартай холбогдуулан цагаан будааны экспортын асуудлаар тус улсын ЭСЯ-тай уулзаж, Монгол Улсын импортыг хэвийн үргэлжүүлэх асуудлыг шийдвэрлүүлсэн.	40%
20		2. Хүнсний боловсруулах үйлдвэрт эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг хэвшүүлэх зааврыг батлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	2017 - 2020		Зохистой дадал нэвтрүүлж баталгаажуулсан хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо 15-аар нэмэгдэх	Хүнсний боловсруулах салбарт үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP/ хялбаршуулан нэвтрүүлэх зааврын төслийг боловсруулж, хэлэлцүүлгийг дотоодын хүнс үйлдвэрлэгчид, мэргэжлийн холбоодыг оролцуулан 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж гарсан саналыг нэгтгэсэн. Үйлдвэрлэлийн зохистой дадал нь Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо олон улсын стандарт нэвтрүүлэхийн урьдач нөхцөл болох бөгөөд тус олон улсын стандартыг нэвтрүүлсэн 11 үйлдвэр байна. Зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврын төслийг ХХААХҮ-ийн сайдын	70%

					зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, дэмжигдсэн. Мөн тус зааврын төслийг хамтран батлах ЭМЯ-наас дэмжсэн албан тоотыг ирүүлээд байна. Зааврын төсөлд ҮАБЗ-ийн ажлын албаны саналыг авч, ХХААХҮ-ийн болон ЭМ-ийн сайдын хамтарсан тушаалаар батлуулахад бэлэн болгосон. /Газрын дарга нараар гарын үсэг зуруулах шатанд/		
21		3. Нийтийн хоол үйлчилгээнд эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлж, зэрэглэл тогтоох	2017 - 2020		Нийтийн хоолны газруудын 50 хувь нь зэрэглэлтэй болох	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд зэрэглэл тогтоох эрх зүйн зохицуулалт бий болгох асуудлаар Захиргааны ерөнхий хуулийн дагуу ХХААХҮ-ийн сайдад эрх олгосон заалтыг Хүнсний тухай хуульд нэмэлтээр оруулах шаардлага гарсан. Иймд Хүнсний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан, холбогдох яамдаас зөвшөөрөл авч, 2020 оны 3 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар дэмжигдэн батлагдсан. Үүний дагуу 2020 оны 4 дүгээр сард холбогдох яамдын зөвшөөрөл дахин авч, УИХ-д хэлэлцүүлэхээр өргөн барьсан. Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөлд заасны дагуу "Хоолны газарт зэрэглэл тогтоох журам"-ын төслийг боловсруулан, санал авсан. "Хоолны газрын зэрэглэлийн шалгуур үзүүлэлт" стандартын төсөлд санал авахаар ажиллаж байна.	70%
22		4. "Сав баглаа боодол" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2017 - 2020		Хөтөлбөрийн хэрэгжилтийг 80 хувьд хүргэх	Сав баглаа боодол үндэсний хөтөлбөрийг 2020 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг боловсруулж байна. Хүнсний сүлжээний аливаа шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнтэй шууд хүрэлцэж, харьцдаг эд зүйлс /машин техник, тоног төхөөрөмж, зоорь, агуулах, багаж хэрэгсэл, сав, баглаа боодол, ахуйн сав суулга/-ийг үйлдвэрлэхэд ашигладаг бүх төрлийн шил, төмөр, мод, хуванцар, цаас зэрэг материал нь аюулгүй байдлын стандарт шаардлагыг хангасан бол олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн "Хүнстэй хүрэлцэхэд аюулгүй тэмдэг"-ийг хэрэглэх асуудлыг зохицуулсан стандартын төслийг СХЗГ-ын Хүнсний стандартчиллын техникийн хороогоор хэлэлцүүлж, гишүүдийн олонхийн саналаар дэмжсэн бөгөөд МХЕГ-ын саналыг тусгасны дараа гишүүдээс дахин цахимаар санал авч, батлахаар шийдвэрлэв. Хүнсний сав баглаа боодлын үйлдвэрлэлд мөрдөх аюулгүй байдлын шаардлагыг тогтоосон MNS ISO TS 22002-4:2020 Үндэсний стандартын төслийг СХЗГ-ын Хүнсний стандартчиллын техникийн хороогоор хэлэлцүүлж, гишүүдийн олонхийн саналаар дэмжсэн бөгөөд төсөлд МХЕГ-ын саналыг тусгасны дараа гишүүдээс дахин цахимаар санал авч, батлахаар шийдвэрлэв. Химийн бодисын савыг хүнсний зориулалтаар хэрэглэж буй түвшинг тогтоох судалгааг Ковид 19 халдварын цар тахалтай холбоотой цахимаар гүйцэтгэх шаардлагатай болсон ба https://kobo.humanitarianresponse.info/#/forms/aWaRPsSANPLmpEqQy	70%

					MDYsz/edit холбоосоор "Хүнсний бус зориулалтын савны хэрэглээний түвшинг тогтоох судалгааны асуумж"-ийг оруулж, судалгааны бэлтгэл хангаж байна. "Сав баглаа боодлын аюулгүй байдлын үзүүлэлтийг тодорхойлох шинжилгээний аргын лабораторийн сорилыг гүйцэтгэх" зөвлөх сонгон шалгаруулах зорилгоор ажлын даалгаврын төсөл боловсруулж, санал авахаар 4 байгууллагад хүргүүлсэн. Техникийн чадавхын шаардлага хангасан УМЭАЦТЛ-той сорил гүйцэтгэх тухай гэрээ байгуулахаар удирдлагаас санал авч байна. "Хүнсний сав баглаа боодлын үйлдвэрлэл ба зохистой хэрэглээ" гарын авлагын төслийг холбогдох байгууллагатай хамтран боловсруулж байна.	
23	5. Хүн амын хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх мэдээлэл, сурталчилгаа болон хүнсний үйлдвэрлэгчид, судалгаа шинжилгээний ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх	2017 - 2020	Жил бүр 5-аас доошгүй сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, 300-аас доошгүй хүн хамруулах	Хүн амын хүнсний шим тэжээлийн боловсролыг дээшлүүлэх, зохистой хооллох дадлыг төлөвшүүлэх зорилгоор ХХААХҮЯ-наас "Монголын эмэгтэйчүүдийн хөгжлийн манлайлал" ТББ-тай хамтран "Өглөөний цай" болон "Ээжийн сонголт – Эрүүл хүнс" хөдөлгөөний хэлэлцүүлгийг 2020 оны 1 дүгээр сарын 10-нд зохион байгуулав. Хэлэлцүүлэгт ХХААХҮ-ийн сайд Ч.Улаан, Дэд сайд Ж.Сауле, ЭМ-ийн сайд Д.Сарангэрэл тэргүүтэй холбогдох төрийн байгууллага болон цэцэрлэг, дунд сургуулийн удирдлага, багш, эцэг эх, мэргэжлийн тогооч нарын 100 гаруй хүн оролцлоо. Хэлэлцүүлэгт "Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн" үндэсний хөтөлбөр Хэрэглэгчийн боловсрол", "Өглөөний цай эрүүл мэндэд нөлөөлөх нь", "Хүн амын хүнсний хэрэглээнд шим тэжээлийн боловсролыг дээшлүүлэхийн ач холбогдол", "Гэр бүлийн хүнсний хэрэглээний сонголтыг ээжүүд гүйцэтгэдэг" сэдэвт илтгэлүүд тавигдаж, хэлэлцүүлэг өрнөв. Хэлэлцүүлгээс хэрэглэгч, үйлдвэрлэгчдэд хандсан уриалга гаргасан. ХХААХҮЯ-наас санаачлан төр, хувийн хэвшлийн холбогдох их, дээд сургуулиудын хамтын ажиллагааны механизм бий болгох санаачилгыг дэвшүүлж, тус ажлыг хэрэгжүүлэх боломж, арга замын талаарх зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлгийг 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулав. Тус арга хэмжээнд МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль, ШУТИС, ХААИС, АШУҮИС, Идэр их сургууль, Техник технологийн дээд сургууль, Технологийн дээд сургууль, Эм зүйн шинжлэх ухааны их сургуулийн төлөөлөл 20 гаруй хүн оролцож, хүнсний боловсруулах салбарын хүний нөөц, судалгаа шинжилгээ, хэрэглэгчийн боловсролд тулгамдсан асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга зам, цаашид авах арга хэмжээний талаар санал солилцож, хэлэлцүүлэг өрнүүлэв. Монгол Улсын хүнсний аж үйлдвэрийн 90 жилийн ойн бүтээлч ажлын хүрээнд салбарын хүний нөөцийн чадавхыг сайжруулах, боловсон хүчин бэлтгэх зорилгоор "Монгол хүнсчин" нийгэмлэг байгуулах үндэслэл, дүрмийн төслийг боловсруулав.	100%	

24		6. Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх суурь судалгаа хийх, журам боловсруулах, сургалт зохион байгуулах	2017 - 2018			Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх журмын төслийг шинэчлэн боловсруулсан. ХХААХҮ-ийн сайдын зөвлөлд танилцуулахаар бэлтгэж байна.	40%
25		7. Согтууруулах ундааны үйлдвэрлэл, импортын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог шинэчилж, тусгай зөвшөөрлийн хугацаа, нөхцөл, шаардлагад хяналт тавих	2017 - 2020		Олон улсын жишигт нийцсэн 3-аас доошгүй стандарт, журам боловсруулах	“Согтууруулах ундааны үйлдвэрийн төсөл сонгон шалгаруулах, үйлдвэрлэлд хяналт тавих журам”-ыг шинэчилж ХХААХҮ-ийн сайдын 2018 оны А-84 дүгээр тушаалаар, “Хүнсний болон техникийн зориулалтаар ашиглах спиртийн хуваарилалт, олголт, зарцуулалт, түүнд хяналт тавих журам”-ыг ХХААХҮ-ийн сайд, ХЗДХ-ийн сайд, Сангийн сайд, ЭМ-ийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хамтарсан тушаалаар тус тус баталсан. Журамд “Хүнсний тухай”, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуульд нийцүүлэн согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага тогтоож, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулах болон согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэгчид тавих хяналтыг нарийвчлан тусгасан. Засгийн газрын 2017 оны 46 дугаар тогтоолоор даалгасны дагуу “Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн үзэл баримтлалын төсөл боловсруулж, батлуулахаар ХЗДХЯ-нд хүргүүлсэн. Үзэл баримтлалын төслийг ХЗДХЯ-наас байгуулсан ажлын хэсгээс боловсруулсан хуулийн төсөлд тусгахаар шийдвэрлэсэн. “Согтууруулах ундаа, тамхи импортлох тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ын төсөл боловсруулж, дээр дурдсан ХЗДХЯ-ны ажлын хэсэгт хүргүүлсэн. ХЗДХЯ, ЭМЯ, ЦЕГ, ГХУСАЗЗ, МХЕГ-тай хамтран “Архидалт, гэмт явдалтай тэмцэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан. МХЕГ-тай хамтран согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, Засгийн газрын 2018 оны 86 дугаар тогтоолоор нэр бүхий 16, Засгийн газрын 2019 оны 130 дугаар тогтоолоор нэр бүхий 3, Засгийн газрын 2020 оны 06 дугаар тогтоолоор 14 аж ахуйн нэгжийн согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгосон.	100%
26	2.24. Дотоодын хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, тахиа, гахай, зөгий, загасны аж ахуй	1. Мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, шинэ технологи нэвтрүүлэх,	2017 - 2020		Мал, амьтны гаралтай хүнсний 1-2 нэр төрлийн бүтээгдэхүүн шинээр бий болох	Мал, амьтны гаралтай хүнсний шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнийг борлуулалтаар нь дэмжих бодлогын хүрээнд “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдаанд оролцсон дараах шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнийг шалгаруулж сурталчлав. Үүнд: 1. “АПУ дэйри” ХХК-ийн “Актив” тараг. 2. “Монос хүнс” ХХК-ийн “Берривит” брэндийн ааруул. 3. Говь-Алтай аймгийн “Баянтан” ХХК-ийн хатаасан аарц.	40%

	зэрэг дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн, бүтээгдэхүүний нийлүүлэлт, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах зорилгоор шинэ шугам суурилуулах, үйлдвэрлэл өргөтгөхөд зээлийн дэмжлэг үзүүлэх				Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2020 оны тэргүүлэх чиглэлд дотор мах, дайвар түүхий эд боловсруулах үйлдвэрийг оруулж, сонгон шалгаруулах ажил хийгдэж байна.	
27	2.25.Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг сайжруулах, дэвшилтэт техник, технологийн шинэчлэлийг хийх, инновацийг нэвтрүүлэх, түүнчлэн “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.	1. “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын эхний үе шатны төлөвлөгөө, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хоёр дахь үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, хэрэгжүүлэх	2017 - 2020	Усан хангамж сайжруулах ажилд: Улсын төсөв: 2942.0 сая Орон нутаг: 4022.7 сая Төсөл хөтөлбөр: 4515.7 сая Малын үзлэг ангилалт: Улсын төсөв: 430.0 сая Бэлчээрийн менежмент, оготно устгал: Улсын төсөв: 5000.0 сая Орон нутаг: 570.0 сая	“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хоёр дахь үе шатны үйл ажиллагааны болон “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын төлөвлөгөөний хэрэгжилтийг 80 хувьд хүргэх	Мал, амьтны эрүүл мэндийн тухай”, “Малын генетик нөөцийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангаж байна. Малын үржлийн ажил үйлчилгээний стратеги төлөвлөгөөг ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-15 дугаар тушаалаар батлав. ХААИС-ийн Мал эмнэлгийн сургуулийн клиникийн байр, 12 сумын мал эмнэлгийн барилгын засвар хийгдэж байна. 15 зохиомол хээлтүүлгийн техникч, 110 малын эмчийг давтан сургалтад хамруулав. 21 аймгийн 99 суманд улсын төсвийн 430.0 сая төгрөгийн хөрөнгөөр 41123 адуу, 16803 үхэр, 15540 тэмээ, 97050 хонь, 34500 ямаа, 21500 сарлагт үзлэг ангилалт хийхээс 19 аймгийн 31824 бод, 92235 бог, нийт 124059 толгой малыг хамруулж, эзэмгний кодыг “Тэргүүн сүрэг трейд” ХХК-д хүргүүлж, ялган тэмдэглэж бүртгэлжүүлж байна. Нийслэл, 21 аймгийн мал эмнэлгийн газарт дуудлагын автомашин, 330 сумын мал эмнэлгийн тасагт мотоцикл, малын эмч нарт компьютер, тоног төхөөрөмж олгов. Экспортлох мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг цахимаар олгож байна. Биокомбинат УТҮГ-ын техник, технологийг шинэчлэх ажлыг эхлүүлэв. Бэлчээрийн менежментийг сайжруулах журмыг 15 сумын ИТХ-аар батлан хэрэгжүүлж байна. Бэлчээрт хөнөөл учруулж буй үлийн цагаан оготно, царцаатай тэмцэх ажлыг 1.3 сая га талбайд, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 21 аймгийн 193 сумдад улсын төсөв, орон нутаг, төсөл хөтөлбөрийн 11.4 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 574 худаг шинээр, 182 худаг сэргээн засварлах, 126 булаг тохижуулах, 9 хөв цөөрөм, 10 худагт сэргээгдэх эрчим хүчээр ажиллах ус өргүүр суурилах ажил хийгдэж байна. Бодлогын хүрээнд “Мах, махан бүтээгдэхүүний аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ыг боловсруулав.	70%
28		2. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл болон малын тэжээл, хадлан бэлтгэлд техник, технологийн	2017 - 2020	Орон нутгийн төсөв: 428.0 сая Төсөл, хөтөлбөр: 999.1 сая Хувийн	МАН-н үйлдвэрлэлийн техникийн шинэчлэлийг 20-иос доошгүй	Монгол улсын Засгийн газраас Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын Экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр манай орны газар тариалангийн бүс нутагт 600 үнээ бүхий сүүний эрчимжсэн 5 цогцолбор ферм байгуулах төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж, төслийг 2020 оны 2 дугаар сард зарлан, 5 аж ахуйн нэгжийг эхний ээлжид сонгон шалгаруулаад байна. Сүүний үхрийн кластерийн	100%

		шинэчлэл, инновацийг нэвтрүүлэх, лизингийн үйлчилгээг хөгжүүлэх		хөрөнгө оруулалт: 3000.0 сая	хувиар, дэвшилтэт технологи, инновацийн бүтээгдэхүүн нэвтрүүлэлтийг 15 хувиар нэмэгдүүлэх	системийг 2020 оны эхний хагас жилийн байдлаар хувийн 3.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Төв аймгийн Баяндэлгэр, Эрдэнэ, Баянчандмань, Борнуур, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Хан-Уул дүүргийн Өлзийт хороололд тус тус хэрэгжүүлж, үйлдвэрлэлийн техникийн шинэчлэлийг 15 хувиар, дэвшилтэт технологи, инновацийн бүтээгдэхүүн нэвтрүүлэх үйлчилгээ 30 хувиар нэмэгдсэн байна. Малын генетик нөөцийн Үндэсний зөвлөлдөх хорооны 2020 оны 6 сарын 10-ны өдрийн хуралдаанаар “Зөгийн аж ахуйд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-ийн төслийг хэлэлцүүлж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар батлуулах дүгнэлт гаргуулав. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил /нэмэлт санхүүжилт/ төслийн хүрээнд өвс тэжээлийн агуулах саравч 11 шинээр барих, 10 засварлах ажлыг гүйцэтгэж байна.	
29	2.26. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол малчин”, “Малжуулах” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	1. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх хоёр дахь үе шатны хэрэгжилтийг зохион байгуулах	2017 - 2020		“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх хоёр дахь үе шатны төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэх	Бодлогын баримт бичгийн 2 дахь үе шатны хэрэгжүүлэх (2018-2020) арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг ХХААХҮ-ийн сайдын 2018 оны А-198 дугаар тушаалаар баталсан. Бодлогын баримт бичгийн хүрэх үр дүнгийн хэрэгжилтийн үнэлгээ 2019 оны жилийн эцсийн байдлаар 70.0 хувь, төлөвлөгөөний биелэлт дунджаар 74.1 хувийн хэрэгжилттэй гарсан. Засгийн газрын 2018 оны 400 дугаар тогтоол, хөтөлбөрийн хүрээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт 2019-2023 оны хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг ХХААХҮ-ийн сайдын 2019 оны “Төлөвлөгөө батлах тухай” А-120 дугаар тушаалаар тус тус баталсан. 2019 оны байдлаар 78.8 хувийн хэрэгжилттэй. Засгийн газрын 2020 оны 34 дүгээр тогтоолоор “Монгол малчин” үндэсний хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө (2020-2024)-г ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-169 дүгээр тушаалаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2020 оны эхний хагас жилд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, НҮБ-ын Хүүхдийн сан, Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Хүн амын сан, Олон улсын хөдөлмөрийн байгууллага хамтран НҮБ-ын Тогтвортой хөгжлийн нэгдсэн сангийн санхүүжилтээр Малчдын нийгмийн даатгалыг өргөжүүлж, цочролд бэлэн байдлыг нэмэгдүүлэх төслийг хэрэгжүүлж эхэлсэн.	40%
30		2. “Монгол малчин” хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах	2017 - 2020		“Монгол малчин” хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах	“Монгол малчин” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2020 оны 34 дүгээр тогтоолоор батлуулав. Тус хөтөлбөрт малчин, малчин өрхийн үйлдвэрлэлийн бүтээмж, нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх, орлого, ашгийг өсгөх, эдийн засгийн чадамжийг сайжруулах зорилтууд тусгагдсан. ХХААХҮ-ийн сайдын 2020 оны “Төлөвлөгөө батлах тухай”	40%

					A-169 дүгээр тушаалаар "Монгол малчин" үндэсний хөтөлбөрийн /2020-2024/ хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан.	
31		3. "Малжуулах" хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх	2017 - 2020	5000 мал худалдан авахад дэмжлэг үзүүлэх	"Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах" хөтөлбөрийн зорилтот бүлэг нь малчид тул уг хөтөлбөрийг "Монгол малчин" үндэсний хөтөлбөрт нэгтгэн боловсруулж, "Монгол малчин" үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2020 оны 34 дүгээр тогтоолоор батлуулсан. Тогтоолын 4-д "Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай" Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолын хавсралтын "Долоо" дахь хэсгийн "а"-д "10. Малжуулах хөтөлбөр, 12. Малчдыг мэдлэгжүүлэх, мэдлэгээр хангах хөтөлбөр" гэснийг хассугай" гэж орсон болно.	Үнэлэх боломжгүй
32		4. Малчид, ногоочдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэх	2017 - 2020	Хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжих	"Монгол малчин" үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2020 оны 34 дүгээр тогтоолоор батлуулав. Тус хөтөлбөрт малчин, малчин өрхийн үйлдвэрлэлийн бүтээмж, нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх, орлого, ашгийг өсгөх, эдийн засгийн чадамжийг сайжруулах зорилтууд тусгагдсан. ХХААХҮ-ийн сайдын 2020 оны "Төлөвлөгөө батлах тухай" А-169 дүгээр тушаалаар "Монгол малчин" үндэсний хөтөлбөрийг /2020-2024/ хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө баталсан. Ковид 19 цар тахалтай холбоотойгоор төмс, хүнсний ногооны дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүнсний нөөц бүрдүүлэх, хангамж сайжруулах зорилгоор Засгийн газрын 138 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхээр НҮБ-ын ХХААБ-д санал тавьснаар 100 сая төгрөгт 10 нэр төрлийн 3372,6 кг ногооны үрийг 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэг ногоочдод буцалтгүй тусламжаар олгов.	70%
33	2.27. Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, фермерийн аж ахуйг зохистой хослуулснаар мах, махан бүтээгдэхүүний экспортыг дэмжиж, жилд экспортлох хэмжээг 50 мянган тоннд хүргэж, малчин	1. Бэлчээрийн маллагаатай үхэр, хонийг махны чиглэлээр өсгөн бойжуулах, өсвөр малыг богино хугацаанд бордох технологийг боловсруулж нэвтрүүлэхэд бодлогын болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх	2017 - 2020	Бэлчээрийн маллагаатай үхэр, хонийг махны чиглэлээр өсгөн бойжуулах, өсвөр малыг богино хугацаанд бордох технологийг 5-аас доошгүй ААН-д	2020 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр Баянхонгор аймгийн Баянбулаг суманд үржүүлж буй нутгийн шилмэл 8.0 мянган хонь, Булган аймгийн Бүрэгхангай суманд үржүүлж буй мах-ноосны чиглэлийн 15.0 мянган хонь, Өмнөговь аймгийн Цогт-Овоо суманд үржүүлж буй ноолуурын чиглэлийн 6.0 мянган ямаа, Төв аймгийн Батсүмбэр суманд үржүүлж буй сүү-махны хосолмол ашиг шимт 23.0 мянган үхэр, нийт 52.0 мянган малыг үзлэг ангилалтад хамруулж, үржлийн цөм сүрэг бүрдүүлж, тухайн бүс нутагт нь ашиг шимийн чиглэлээр өсгөн үржүүлэх, өсвөр малыг богино хугацаанд бордох технологийг орон нутагт нэвтрүүлэх талаар зөвлөмж өгч, хамтран ажиллаж байна. Монгол улсын Засгийн газар Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын Экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр манай орны газар тариалангийн бүс нутагт 600 үнээ бүхий сүүний эрчимжсэн 5 цогцолбор ферм байгуулах төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж, төслийн баримт бичгийг 2020 оны 2 сард	40%

	өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.			нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх	зарлан, 5 аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, манай улсаас хамаарах үйл ажиллагааг тухай бүр зохион байгуулж байна.	
34		2. Өндөр ашиг шимтэй махны чиглэлийн үүлдрийн үхрийг эрчимжсэн технологиор өсгөж үржүүлэхэд бодлогын болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх	2017 - 2020	Эрчимжсэн аж ахуйн чиглэлээр махны чиглэлийн үүлдрийн үхэр өсгөн үржүүлж буй 10-аас доошгүй ААН-д дэмжлэг үзүүлэх	ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 04 дүгээр зөвлөмжөөр ЖДҮХС-гаас олгох нийт зээлийн 25-аас доошгүй хувийг “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд зээл олгохоор тусгасны дагуу 2020 онд ЖДҮХС-гаас зээл олгохдоо эхний ээлжид эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөртэй холбоотой төслүүдийг дэмжүүлэх саналыг Хөдөө аж ахуйг дэмжих санд албан бичгээр хүргүүлсэн. 2020 онд ЖДҮХС-д эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх чиглэлээр 200 гаруй төсөл ирүүлээд байна. Өнгөрсөн жил ЖДҮХС-гаас арвин ашиг шимтэй махны үүлдрийн үхэр өсгөж үржүүлэхээр 14 аймгийн 34 иргэн аж ахуйн нэгжид 5.9 тэрбум төгрөгийн зээл олгогдсон аж ахуйн нэгжүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, үйл ажиллагаа, үр дүнд хяналт тавин ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газраас, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын Экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 600 үнээ бүхий 6 сүүний эрчимжсэн цогцолбор ферм байгуулах төсөл хэрэгжүүлэхээр төслийн баримт бичгийг 2020 оны 2 дугаар сард зарлан 5 аж ахуйн нэгжийг эхний ээлжид сонгон шалгаруулж, манай улсаас хамаарах арга хэмжээг тухай бүр зохион байгуулж байна.	70%
35	2.28. Мал аж ахуйн мэргэжилтнийг бэлтгэх, давтан сургах, мал аж ахуйн хөгжлийн талаархи олон улсын туршлагыг судлах, нэвтрүүлэх, “Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах” хөтөлбөр хэрэгжүүлнэ.	1. Мал аж ахуйн мэргэжилтэн, туслах ажилтныг бэлтгэх, давтан сургах тогтолцоог сайжруулж, хэрэгжилтийг зохион байгуулах	2017 - 2020	МАН-н мэргэжилтэн, туслах ажилтныг бэлтгэх, давтан сургах үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах	Мал зүйч мэргэжилтний 21 аймаг, нийслэлийн мэргэжлийн албанд дутагдаж буй мэргэжилтний судалгааг тогтмол авч ХААИС-ийн Мал аж ахуй, биотехнологийн сургуульд захиалга хүргүүлэн өдрийн болон эчнээ ангид элсэн суралцах боломжоор хангаж байна. Шинээр төгсөгчдийг орон нутагт ажиллах боломж, ажлын байрны талаарх мэдээллээр хангаж, давтан сургах, мэргэшүүлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулав. Хууль тогтоомжийн хүрээнд МУСҮТ болон "Нутаг академи" ТББ-тай хамтран "Бод малын зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх" сургалтыг зохион байгуулж орон нутгаас 30 мал зүйч мэргэжилтэн суралцав. Бог болон бод малын ангилагч, шинжээч бэлтгэх сургалтыг ХААИС-ийн Мал аж ахуй, биотехнологийн сургуультай хамтран 2020 оны 9-10 сард зохион байгуулахаар захиалга авч эхлээд байна. 2019-2020 оны хичээлийн жилд мал зүйч мэргэжлээр 29 оюутан төгссөн бөгөөд төгсөгчдийн мэдээллийг харьяа орон нутгийн мэргэжлийн байгууллагад хүргүүлээ. 2020-2021 оны хичээлийн жилд мал зүйч мэргэжлээр элсэн суралцах урилга, сургалтын хөтөлбөрийн танилцуулгыг орон нутагт хүргүүлж 60-65 оюутан элсүүлэн суралцуулах зорилт тавин	100%

					ажиллаж байна. Мал зүйч, Зоо инженер, технологи мэргэжлээр 2-4 дүгээр курсэд нийт 117 оюутан, эчнээ 2.5 жилийн хөтөлбөрт 21 оюутан, 1.5 жил буюу хавсарга хөтөлбөрт 17 оюутан тус тус суралцаж байна. Мэргэшүүлэх сургалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулж, 21 аймаг, нийслэл, 331 сум, 6 дүүргийн Мал үржлийн албаны Малын бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтнүүдэд малыг бүртгэх, ялган тэмдэглэх, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, малын удам зүйн үнэлгээний програм, гойд ашиг шимт малыг үр төлийн чанараар үнэлэх, мэргэшүүлэх талаар өдөр бүр холбогдож, мэдээлэл өгч, давхардсан тоогоор 585 мэргэжилтэнг арга зүйн удирдлагаар хангаж ажиллав.	
36	2. Мал аж ахуйн хөгжлийн талаарх олон улсын туршлагыг судлах, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах	2017 - 2020		МАН-н хөгжлийн талаарх олон улсын туршлагыг судлах, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах	Малчдын нийгмийн даатгалын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, тэдний бизнесийн санаа, хоршооны үйл ажиллагааг сайжруулах, хэрэгжүүлэх, шинэ технологи, инновацийг ашиглах замаар хамрагдалтыг нэмэгдүүлж, малчин өрхийн ган зуд гэх мэт байгалийн гамшиг, цочролд бэлэн байдлыг нэмэгдүүлэх, цочролын дараах нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах чиглэлээр НҮБ-ын Тогтвортой хөгжлийн нэгдсэн сангийн санхүүжилтээр /2020-2022 он/ 2 жилийн хугацаатай төсөл хэрэгжүүлж эхэлсэн. Мал аж ахуйн тогтвортой хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Даян дэлхийн тогтвортой мал аж ахуйн хөтөлбөрийн газар болон НҮБ-ын ХХААБ-тай хамтран залуу малчдад зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулж байна. Нийслэлийн ХХААГ, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв, ХААИС-тай хамтран олон улс, салбарын чиглэлээр мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологи, бүтээгдэхүүний боловсруулалт, тэжээл бэлтгэх, боловсруулах технологи, төрөл бүрийн хүнсний ногоо тариалах технологийн сургалтыг бэлтгэн онлайн явуулж, ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчид, малчид, олон нийтэд байнга хүргэж байна.	70%
37	3. “Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	2017 - 2020		“Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	“Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах” хөтөлбөрийн зорилтот бүлэг нь малчид тул уг хөтөлбөрийг “Монгол малчин” үндэсний хөтөлбөрт нэгтгэн боловсруулж, “Монгол малчин” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2020 оны 34 дүгээр тогтоолоор батлуулсан. Тус тогтоолын 4-д “Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай” Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолын хавсралтын “Долоо” дахь хэсгийн “а”-д “10. Малжуулах хөтөлбөр, 12. Малчдыг мэдлэгжүүлэх, мэдлэгээр хангах хөтөлбөр” гэснийг хассугай” гэж орсон болно.	Үнэлэх боломжгүй

38	2.29. Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалт, даатгал, татварын уян хатан бодлогоор дэмжих, малын гаралтай түүхий эдийн үнэ ханшийн уналтаас хамгаалах, малчдад ирж байгаа хүндрэлийг багасгахад чиглэгдсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих тусгай санг өргөжүүлж, малчин өрхийн орлого, амьжиргааны баталгааг хангана.	1. Мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжих төрийн бодлогыг тодорхой болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	2017 - 2020	Хувийн хөрөнгө оруулалт: 3,000.0 сая	МАН-н салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг 20 хувиар нэмэгдүүлэх	МАН-н салбарт үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд 2020 оны эхний хагас жилийн байдлаар Хөдөө аж ахуйг дэмжих сангийн зээл олгогдож эхлээгүй байна. Сүүний үхрийн болон эрчимжсэн фермерийн аж ахуй, сүү, сүүн бүтээгдэхүүн, сүүний чиглэлийн эрчимжсэн фермерийн аж ахуй зэрэг салбаруудад нийт 3,000.0 орчим сая төгрөгийн шууд болон шууд бус хэлбэрээр хөрөнгө оруулалт хийгдэж, сүүний үхрийн кластерийн системийг Төв аймгийн Баяндэлгэр, Эрдэнэ, Баянчандмань, Борнуур, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Хан-Уул дүүргийн Өлзийт хороололд тус тус хэрэгжүүлж, эрчимжсэн мал аж ахуйн салбарт 2020 оны эхний хагас жилийн байдлаар хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 100 хувь байна.	100%
39	Мал хамгаалах санг өргөжүүлж, малын гаралтай түүхий эдийн үнэ ханшийн уналтаас хамгаалах, малчин өрхийн орлого, амьжиргааны баталгааг хангах ажлыг зохион байгуулах	2. Мал хамгаалах санг өргөжүүлж, малын гаралтай түүхий эдийн үнэ ханшийн уналтаас хамгаалах, малчин өрхийн орлого, амьжиргааны баталгааг хангах ажлыг зохион байгуулах	2017 - 2020		Мал хамгаалах санг өргөжүүлж, МАН-н үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох, урт хугацааны хөрөнгө оруулалтад дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах	Мал хамгаалах сан татан буугдсан ч ЖДҮХС өргөжин үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. 2019 онд ЖДҮХС-гийн захирлын 2019 оны А/77, А/81, А/117 дугаар тушаалуудаар сүүний чиглэлийн болон махны чиглэлийн үхэр, сарлаг үхрийн, тэмээ, хонь, тахиа, гахай, зөгий, загасны нийт 101 иргэн, аж ахуйд 10 тэрбум 528 сая 490,7 мянган төгрөгийн зээлийг 5 жилийн хугацаатай олгосон. Үр дүн нь малын гаралтай түүхий эдийн үнэ ханшийн уналтаас хамгаалах, малчин өрхийн орлого, амьжиргааны баталгааг хангасан. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын Экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр манай орны газар тариалангийн бүс нутагт 600 үнээ бүхий 6 сүүний эрчимжсэн цогцолбор ферм байгуулах төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж, төслийн баримт бичгийг 2020 оны 2 дугаар сард зарлан, 5 аж ахуйн нэгжийг эхний ээлжид сонгон шалгаруулаад байна. Цаашид энэ зээлийг Хөдөө аж ахуйг дэмжих сангаар дамжуулан олгохоор ажиллаж байна.	40%
40	Үндэсний үйлдвэрүүдэд эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг, татварын хөнгөлөлт үзүүлж түүхий эдийн	3. Малын гаралтай түүхий эдийн үнэ ханшийн уналтаас хамгаалах, үнэ зохицуулах арга хэмжээг үндэсний үйлдвэрүүдтэй хамтран хэрэгжүүлэх	2017 - 2020		Үндэсний үйлдвэрүүдэд эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг, татварын хөнгөлөлт үзүүлж түүхий эдийн	Малын гаралтай түүхий эдийн ханшийн уналтаас хамгаалах, үнэ зохицуулах арга хэмжээг үндэсний үйлдвэрүүдтэй хамтран хэрэгжүүлэх ажлын хүрээнд: 1. Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн ханш, бэлтгэлийн хэмжээг 21 аймаг, нийслэлээс 7 хоног бүр авч нэгтгэн бодлого төлөвлөлт, бусад мэдээлэлд ашиглаж мэдээллийн сан бүрдүүлж ажиллаж байна. 2. Үндэсний үйлдвэрүүдийг чанартай түүхий эдээр хангах, малчдын орлогыг нэмэгдүүлэх, ажлын байрыг бууруулахгүй байх, экспортыг дэмжих зорилгоор Мал аж ахуйн түүхий эдийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэхээр Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан батлуулав. Тогтоолын хэрэгжилтийн хүрээнд:	70%

				үнэ ханшийг тогтворжуулах	- ОХУ-ын Русская кожа ХХК-д арьс ширэн түүхий эдийг экспортлохоор бэлтгэл ажлыг хангаж байна. - "Дархан үйлдвэр технологийн парк"-ийн нэгж "Дархан арьс ширний цогцолбор" ХХК-тай зээлийн хүүгийн татаасыг санхүүжүүлэхээр бодлогын гэрээ байгуулав. 3. Ноолуурын үнийн уналтаас хамгаалах, үндэсний үйлдвэрүүдийг чанартай түүхий эдээр хангах, малчдын орлогыг тогтвортой байлгах, экспортыг дэмжих зорилгоор Засгийн газрын 2020 оны 101 дүгээр тогтоолоор Хөгжлийн банкны эх үүсвэрээр 300 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг ноолуур бэлтгэх зориулалтаар үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд нэг жилийн хугацаатай 3 хувийн хүүтэй олгохоор шийдвэрлэсэн. Тус тогтоолын хүрээнд Хөгжлийн банк, Төрийн банк, Капитрон банкнаас нийт 19 аж ахуйн нэгж 56.1 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгоод байна.	
41	2.30.Малыг бүртгэлжүүлж, малын гаралтай түүхий эд бэлтгэлийн чанар стандартыг дээшлүүлж, гарал үүслийг тодорхой болгох системийг бүрдүүлнэ.	1. Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлж, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, сүлжээний үйл ажиллагааг боловсронгуй болгон сайжруулах	2017 - 2020	Үржилд ашиглаж буй нийт хээлтүүлэгч, цөм сүргийн мал, хурдны адуу, гоц халдварт өвчнөөс эрүүл бүс нутгийн үхэр сүргийг ялган тэмдэгжүүлж, нийт мал сүргийн 70 хүртэлх хувийг бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх	Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлж, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан, сүлжээний үйл ажиллагааг сайжруулах чиглэл төлөвлөгөө гарган, орон нутгийн мэргэжлийн байгууллагад хүргүүлэв. Малын бүртгэлийн программын ашиглалтыг аймаг, сумаар хяналтад авч, үйл ажиллагааг тогтмолжуулж, оффлайн буюу мал, малын эзэн, малчин өрхийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан программ 21 аймаг, нийслэлийн 189 сум, 4 дүүрэгт 56%, онлайн буюу мал, малчин өрхийн МАА-н үйлдвэрлэлийн мэдээлэл хураангуй хэлбэрээр удирдлагын төвшинд харагдах программ нь 21 аймаг, нийслэл, 331 сум, 6 дүүрэгт 100% ажиллаж байна. Нийт 176059 толгой цөм сүргийн малын мэдээлэл нэгдсэн санд оруулав. Орон нутгаас ирүүлсэн захиалгын дагуу 9370 адууны чип, 2550 тэмээ, 17170 үхэр, 89233 хонь, 50500 ямааны эзэмэгт дахин давтагдахгүй хувийн дугаар олгов. Монгол адууны үүлдэрлэг байдалд молекул биологийн судалгаа хийх, стандартыг шинэчлэн тогтоох, хурдан морины бүртгэлийн цахим программ, мэдээллийн сан бий болгох ажлыг холбогдох хуулийн хүрээнд зохион байгуулж, нийт 1500 адуунд туршилтын чип суулгаж, цусны сорьц авах ажлын гүйцэтгэл 80 хувь буюу 1200 адуу хамруулаад байна. Өвөрхангай аймагт хэрэгжиж буй "Монгол улсын малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх системийг шинэчлэх" /STDF/PG/534/ туршилтын төслийн хүрээнд аймгийн ХХААГ, Баянгол, Гучин-Ус, Бат-Өлзий, Уянга сумдын ХАА-н тасаг, Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгж, малчдад "Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн программын туршилт"-ын талаарх сургалтыг 2020 оны 6 сарын 05-10-ны өдрүүдэд зохион байгуулж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулах ажлыг эхлүүлж, нийт 5.0 мянган толгой адуунд чип суулгаж,	40%

					20.0 мянган толгой хонь, ямааг өрхийн дугаараар ялган тэмдэглэхээс 3653 малын мэдээлэл орсон. 2019 онд 179712 толгой мал бүртгэгдэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд нийт 3.2 сая толгой буюу нийт мал сүргийн 4.5% нь хамрагдаад байна.	
42		2. Малын гаралтай түүхий эдийн стандартуудыг шинэчлэх, мөрдүүлэх, түүхий эдийн чанарыг орон нутагт хянан баталгаажуулах нөхцөлийг бүрдүүлэх, тоног төхөөрөмжийн дэмжлэгийг сумдад үзүүлэх	2017 - 2020	Малын ноос, ноолуур, сүүний чанарыг суманд хянан баталгаажуулах чадавхийг баруун бүсийн сумдад бий болгох	Малыг бүртгэлжүүлж, малын гаралтай түүхий эд бэлтгэлийн чанар стандартыг дээшлүүлж, гарал үүслийг тодорхой болгох системийг бүрдүүлэх ажлын хүрээнд: Арьс ширний бэлтгэлийн чанарын системийг боловсронгуй болгох судалгаа 2019-2021; - Малын арьс, ширийг биологийн гаралтай гэмтлээс хамгаалах, сэргийлэх арга боловсруулах 2019-2021. Тоног төхөөрөмжийн дэмжлэгийг сумдад үзүүлэх ажлын хүрээнд: - “НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллагаас (UNIDO) Европын Холбооны санхүүжилтээр хэрэгжүүлж буй Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн хүрээнд арьс ширэн түүхий эдийн чанарыг дээшлүүлэх нядалгааны үеийн гэмтлийг бууруулах зорилгоор арьс, ширэн түүхий эдийг хуулах тоног төхөөрөмжийг зохион бүтээж туршив. Ингэснээр нядалгааны үеийн гэмтлийг 100% бууруулах боломжтой нь туршилтаар батлагдав. Төслийн хүрээнд 10 ширхэг тоног төхөөрөмжийг түүхий эдийн Эмээлт зах орчмоор байрлах нядалгааны цехүүдэд нийлүүлэхээр төлөвлөв. - Ноосны гарц нэмэгдүүлэх, ноос бэлтгэгчдийн ур чадварыг сайжруулах, орлогыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн зардлыг бууруулах, ноос бэлтгэлийн чанарыг сайжруулах, бэлтгэн нийлүүлэгч-үйлдвэрлэгчдийн хооронд бизнесийн үр ашгийг нэмэгдүүлэх, орон нутагт ажлын байрыг бий болгох, Мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилтуудыг хэрэгжүүлэхээр “Хонины ноосны чанарыг сайжруулах” олон улсын сургалтыг 6 дугаар сард Дундговь аймагт зохион байгуулав. Уг сургалтад Хөвсгөл, Төв, Ховд, Сэлэнгэ, Өмнөговь, Дундговь, Сүхбаатар аймгуудын сумдын хоршооны гишүүн 40 гаруй гишүүд хамрагдаж хяргагч, ноос ангилан ялгагчаар бэлтгэгдэв. Ноос хяргах төхөөрөмжийг хоршоодод хүлээлгэн өгөв.	70%
43	2.31.Малчдыг орон сууцны хөтөлбөрт хамруулах, нийгмийн асуудлыг шийдэх арга хэмжээ авна.	1. Малчдыг орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор орон байр, дэд бүтэц, ахуйн нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	2017 - 2020	Орон сууцны хөтөлбөрт хамрагдсан малчин өрхийн тоог жил бүр 50-аар нэмэгдүүлэх	Малчдыг орон сууцны хөтөлбөрт хамруулах, нийгмийн асуудлыг шийдэх асуудлыг БХБЯ-ны холбогдох газартай хамтран судалж байна. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 5000 малчин өрхийг орон сууцжуулах асуудлыг дэвшүүлсэн. Орон сууцны санхүүжилтийн тогтолцоо, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгосноор 2019 оны байдлаар нийт 169.7 мянган малчин өрхийн 38.1 хувь инженерийн бүрэн хангамжтай орон сууцтай болсон байна. Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор “150 мянган айлын орон сууц” үндэсний хөтөлбөр баталсан. Тус хөтөлбөрийн 4.4.4-т малчдын орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөл бүрдүүлэх, тэдний нүүдэлчин	100%

		ажлыг зохион байгуулах, орон сууцны хөтөлбөрт хамруулах				ахуй нөхцөлд тохирсон, байгаль орчинд ээлтэй, ус, дулаан, эрчим хүчний хэмнэлттэй орон сууцтай болоход санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд авч хэрэгжүүлэх заалтыг тусгаж оруулав. БХБЯ-наас гаргасан малчдын аж байдлын судалгаагаар 2020 оны эхний хагас жилийн байдлаар улсын хэмжээнд Улаанбаатар хот болон аймгийн төв зэрэг суурин газарт төвлөрсөн халаалтын системд холбогдсон орон сууцтай шинээр болсон малчин өрх 8.9 мянгаар нэмэгдэж, өмнөх оны түвшингээс 5.3 хувиар өссөн байна.	
44	2.32.Мал эмнэлгийн албаны тогтолцоог олон улсын жишигт нийцүүлж, үйл ажиллагааны шуурхай, нэгдмэл байдлыг ханган, мал, амьтны гоц халдварт, халдварт зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг хяналтад авах, тэмцэх стратегийг хилийн боомтуудыг түшиглэн бүсчлэн хэрэгжүүлж, мал аж ахуйн гаралтай түүхийг эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлнэ.	1. "Малын эрүүл мэнд" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2017 - 2020		Хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А-11 дүгээр тушаалаар баталсан. 2020 онд хэрэгжүүлэхээр нийт 72 ажил тусгагдсанаас хэрэгжилтийн дундаж 58.6 хувьтай байна. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2020 онд нийт 16,8 тэрбум төгрөг төсөвлөснөөс эхний хагас жилийн байдлаар 6.2 тэрбум төгрөг зарцуулаад байна.	70%
45	шуурхай, нэгдмэл байдлыг ханган, мал, амьтны гоц халдварт, халдварт зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг хяналтад авах, тэмцэх стратегийг хилийн боомтуудыг түшиглэн бүсчлэн хэрэгжүүлж, мал аж ахуйн гаралтай түүхийг эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлнэ.	2. Малын эмийн үлдэгдлийн хяналтын хөтөлбөрийг боловсруулан, батлуулж хэрэгжилтийг зохион байгуулах, эмийн зохистой хэрэглээний тогтолцоо, хяналтыг сайжруулах	2017 - 2020		Малын эмийн сангийн зохистой дадлын шаардлага хангасан эмийн сан эм, эмнэлгийн хэрэгслийг хадгалах, олгох үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх боломж бүрдэх	Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны А/44 дүгээр тушаалаар "Мал эмнэлгийн эмийн сангийн бүтэц, үйл ажиллагаа", "Малын эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллагад тавих нийтлэг шаардлага" стандартыг боловсруулах ажлын хэсгийг ХХААХҮЯ, Мал эмнэлгийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Мал эмнэлгийн хүрээлэн, СХЗГ, МЭЭСБУЛ-ийн төлөөлөлтэйгээр байгуулсан. Ажлын хэсэг "Мал эмнэлгийн эмийн сангийн бүтэц, үйл ажиллагаа", "Малын эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллагад тавих нийтлэг шаардлага" стандартын төслийг нийт 7 удаа хэлэлцсэн. 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр ХХААХҮЯ, МХЕГ, МЭЕГ, Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангийн төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан саналыг нэгтгэн эцэслэж, МЭЕГ-ын даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн "Мал эмнэлгийн эмийн сангийн бүтэц, үйл ажиллагаа", "Малын эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллагад тавих нийтлэг шаардлага" стандартын төслийг эцэслэн СХЗГ-т хүргүүлсэн. Дээрх төслүүд нь СХЗГ-ын ХАА-н стандартчиллын техникийн хорооны 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хурлаар хэлэлцэн дэмжигдсэн. Баталгаажуулах ажил хийгдэж байна. Ингэснээр Малын эмийн сангийн зохистой дадлын шаардлага хангасан эмийн сан эм, эмнэлгийн хэрэгслийг хадгалах, олгох үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх хүрээнд эдгээр баримт бичгийн хэрэгжилт хангуулах ажлыг хийх боломж бүрдэж байна.	100%

46		3. Мал эмнэлгийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлж, үйл ажиллагааны шуурхай, нэгдмэл байдлыг хангах	2017 - 2020		Мал эмнэлгийн үйлчилгээний хүртээмж чанар нэмэгдэх	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 267 дугаар тогтоолоор аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар болон сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийг шинээр байгуулж, ХХААХҮ-ийн сайдын 2018 оны А/174 дүгээр тушаалаар аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрын бүтэц, орон тоог баталснаас хойш, 21 аймаг, Нийслэлийн Мал эмнэлгийн газар, 331 сум, 6 дүүргийн Мал эмнэлгийн тасагт 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар нийт 1200 гаруй малын эмч, мэргэжилтэн, мал эмнэлгийн 1002 үйлчилгээний /хувийн хэвшлийн/ нэгжид нийт 1500 орчим малын эмч ажиллаж байна. ХХААХҮ-ийн сайдын 2020 оны "Мал эмнэлгийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай" А/46 дугаар тушаалаар МЭЕГ-ын бүтцийг шинэчлэн баталсан. МЭЕГ, аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрын нийт албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 96, 97, 98 дугаар тогтоолоор баталсан. 2020 онд орон нутгийн чадавхыг дээшлүүлэх хүрээнд 21 аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газарт автомашин, орон нутгийн хяналтын цэг, 2 дүүргийг автомашин, 200 сумыг компьютер, 330 сумыг мотоцикл, ширээ сандлаар хангаснаар ажиллах нөхцөл бүрдэж, мал эмнэлгийн үйл ажиллагаа шуурхай байдал, чанар хүртээмж нэмэгдлээ.	100%
47		4. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах	2017 - 2020		Халдварт өвчний голомтын тоо буурсан, 24 нэр төрлийн өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтад давхардсан тоогоор 32.4 сая малыг хамруулж, халдварт өвчний өвчлөлийг бууруулах	Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны "Дархлаажуулалтын төлөвлөгөө батлах тухай" А/43 дугаар тушаалаар Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоолын дагуу улсаас санхүүжүүлэх 7 нэрийн вакцинд 11,0 сая, орон нутгаас санхүүжүүлэх 9 нэрийн вакцинд 11,7 сая, иргэн, хуулийн этгээдээс санхүүжүүлэх 3 нэрийн вакцинд 5,0 сая, нийт 19 нэрийн өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд давхардсан тоогоор 24,7 сая толгой мал, амьтанг хамруулахаар ажиллаж байна. Мал, амьтны халдварт өвчнөөс сэргийлэх вакциныг Биокомбинат УТҮГ үйлдвэрлэн, орон нутагт 90,6%-ийг хүргүүлээд байна. 2020 оны 2 дугаар улирлын урьдчилсан мэдээгээр 16,7 сая толгой мал, амьтан дархлаажуулалтад хамруулаад байна. 2019 оны эхний хагас жилийн байдлаар 21 аймаг, нийслэлийн давхардсан тоогоор 545 суманд халдварт өвчний 1103 голомт бүртгэгдэж, нийт 18122 мал, амьтан өвчилсөн байдаг. 2020 оны хагас жилийн мэдээг нэгтгэж байна.	70%

					нөхцөлийг бүрдүүлэх		
48		5. Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах	2017 - 2020	Улсын болон орон нутгийн төсвийн 891.0 сая төгрөг төсөвлөснөөс 651.0 сая төгрөг зарцуулсан байна.	Шүлхий өвчнөөр тайван статусыг хадгалж, давхардсан тоогоор нийт 10.0 сая малыг, бог малын мялзан төст өвчнөөр тайван статусыг хадгалж, нийт 7.0 сая төл малыг, хонь, ямааны цэцэг өвчнөөр тайван статусыг хадгалж, давхардсан тоогоор нийт 8.0 сая малыг тус тус дархлаажуулалтад хамруулан, 85-аас доошгүй хувьд хамгаалах дархлаа тогтоох	Яаралтай дархлаажуулалтын төлөвлөгөөг МЭЕГ-ын даргын 2020 оны А/34 дүгээр тушаалаар баталснаар 3 нэрийн өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад нийт 26.1 сая толгой мал хамруулна. Үүнд: Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтад нийт 11 аймаг, нийслэлийн нийт 91 сум, дүүргийн 12,3 сая толгой мэдрэмтгий мал сүргийг хамруулсан бол 2019 оны эхний хагасд 14,3 сая толгойг хамруулсан. Шүлхийн вакцины дархлаа шалгах тандалт судалгаанд нийт 9 аймаг, нийслэлийн 330 хот айлын 4.950 малаас цусны ийлдсийн дээжийг бэлтгэн лабораторийн шинжилгээ хийгдэж байна. Бог малын мялзангаас сэргийлэх дархлаажуулалтад 3,9 сая, хонины цэцгээс сэргийлэх дархлаажуулалтад 3,0 сая төлийг 2020 оны 08-09 дүгээр сард хамруулна. Бог малын мялзангаас сэргийлэх вакцины дархлаа шалгах тандалтыг вакцинжуулалтын дараа буюу 10-11-р сард гүйцэтгэхээр төлөвлөж байна. 2019 онд Шүлхий өвчний гаралт 6, бог малын мялзан өвчин 1, хонины цэцэг өвчин 1 голомт тус тус бүртгэгдэж байсан бол 2020 онд эдгээр өвчний голомт бүртгэгдээгүй, тайван байна.	40%

49		6. Зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах	2017 - 2020		21 аймаг, нийслэлийн нийт мал сүргийн 85-аас доошгүй хувьд хамгаалах дархлаа тогтох, жил бүр 103.3 мянган	Мал, амьтнаас хүнд дамжин халдварладаг зооноз боом, галзуу, бруцеллёз зэргээс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын төлөвлөгөөг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны А/43 дугаар тушаалаар баталсан. Тус төлөвлөгөөний хүрээнд боом өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад нийт 4,3 сая, галзуу өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад нийт 2,9 сая толгой мал, амьтан хамруулахаар төлөвлөж, 2 улирлын урьдчилсан мэдээгээр боомын дархлаажуулалт 46,5%-тай, галзуугийн дархлаажуулалт 26,4%-тай байна. Бруцеллёзоос сэргийлэх дархлаажуулалтын төлөвлөгөөний дагуу 8 дугаар сард 15,4 сая толгой охин төл хамруулахаар төлөвлөн вакцин, шингэлэгчийг үйлдвэрлээд байна. 2019 оны эхний хагас жилийн байдлаар галзуу өвчин 18 аймагт давхардсан тоогоор 151 сум, толгой малыг дүүрэгт 191 гаралтаар 259 мал, амьтан өвчилсөн бол 2020 оны хагас жилийн урьдчилсан мэдээгээр 16 аймгийн 103 суманд бүртгэгдэж, эрүүл аймаг, голомтын тоо 31.8 хувиар буурсан байна. Боом өвчин 2019 оны хагас сум, бүсийг жилд 3 аймагт 4 удаагийн гаралт бүртгэгдсэн бол 2020 оны хагас жилд баталгаажуулах 3 аймагт бүртгэгдсэн байна. Хээлтүүлэгч малд бруцеллёзын тандалт хийх гэрээг УМЭАЦТЛ-той гэрээ байгуулан, 6 сард эхлүүлэхээр ажиллаж байна.	70%
50		7. Мал эмнэлгийн лабораторийг засварлах, хорио цээрийн хяналтын цэгийг байгуулах, мэргэжлийн үйлчилгээ, боловсон хүчнийг чадавхжуулах	2017 - 2019		Баруун, зүүн, төвийн бүсийн лабораторийн чадавхи нэмэгдсэнээр гоц халдварт, халдварт өвчнийг цаг алдалгүй шуурхай оношилж, өвчин тархах эрсдлээс сэргийлэх, 400-аас доошгүй эмч мэргэжилтнийг сургалт семинарт	Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораториудыг MNS ISO/IEC 17025:2018 “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага” стандартын итгэмжлэлд хамруулах төлөвлөгөөг МЭЕГ-ын даргын 2020 оны А/96 дугаар тушаалаар батлуулан аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораториудад хүргүүлсэн. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораторийн эрхлэгчид болон УМЭАЦТЛ-ийн чанарын менежерүүд хамтран 2020 оны мал эмнэлгийн сүлжээ лабораторийн хүрээнд лабораторийн итгэмжлэлийн жишиг баримт бичиг болох чанарын гарын авлага, холбогдох журмуудыг боловсруулж байна. Бруцеллёз өвчнөөс эрүүлжүүлэх шинжилгээнд шаардагдах хэрэглэгдэхүүн, багаж хэрэгсэл нийлүүлэгчийг сонгон шалгаруулах МЭТШ/2020/03-011, Гоц халдварт шүлхий өвчний оношлуур, урвалж нийлүүлэгч сонгох МЭТШ/2020/03-012, Бог малын мялзан, гахайн африкийн мялзан өвчний оношилгоонд шаардлагатай оношлуур, хэрэглэгдэхүүн худалдан авах МЭТШ/2020/03-013, Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчний оношлуур, эм урвалж, хэрэглэгдэхүүн нийлүүлэгч сонгох МЭТШ/2020/03-014 дугаартай бараа худалдан авах гэрээ байгуулсан. Лабораторийн эмч нарыг давтан сургах, боловсон хүчний чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор “Мал эмнэлгийн ерөнхий газрын сургалт хөгжлийн 2020 оны төлөвлөгөө”-г МЭЕГ-ын даргаар	70%

				хамруулах, 100 гаруй мэргэжилтнийг давтан сургах, боловсон хүчний чадавхийг нэмэгдүүлэх	батлуулсан. “Монгол улсад бэтэг өвчний тандалтын тогтолцоо байгуулах, лабораторийн чадавхыг нэмэгдүүлэх” сэдэвт сургалтад нийт 48 шинжээч хамруулсан. НҮБ-ын ХХААБ, Мерси Кор ОУ-ын байгууллагатай хамтран Бог малын мялзан өвчний оношилгооны сургалтанд Баруун 5 аймгийн 45 малын эмч хамруулна. Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэг байгуулах тухай 2016 оны 240 дүгээр тогтоолыг Засгийн газрын 2020 оны 196 дугаар тогтоолоор мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын зарим байршлыг шинэчлэн тогтоож, өмнөх тогтоолыг хүчингүй болгов. Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгийн байр 3 ширхэг, 9 хяналтын цэгт тус бүрд 1 SAMSUNG маркын таблет, улсын байцагчид зуны дүрэмт хувцас нийт 9, хяналтын цэгийн 36 улсын байцагчид өвлийн дүрэмт хувцас олгосон.	
51		8. Мал болон малын гаралтай түүхий эдийн гарал үүслийг тодорхойлох, хянах тогтолцоог оновчтой болгон хөгжүүлэх	2017 - 2020	-	ХХААХҮЯ, Швейцарын хөгжлийн агентлаг, Мал эмнэлгийн ерөнхий газар хамтран Мал эмнэлгийн нэгдсэн системийн хүрээнд 2020 онд 21 аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар, 332 сум, 6 дүүргийн мал эмнэлгийн тасаг, 1125 мал эмнэлгийн хувийн үйлчилгээний нэгж, Мэргэжлийн хяналт байцаагч болон Цагдаагийн албан хаагч нарт мал эмнэлгийн нэгдсэн системд нэвтрэх эрх нээж өгсөн нь Монгол улсын хүн амын хүнсний аюулгүй байдал хангах, хөдөө аж ахуйн гаралтай бүх бүтээгдэхүүний гарал үүслийг хянах, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний шилжилт хөдөлгөөнийг хяналтад авах боломж бүрдүүлж, мал эмнэлгийн цахим гэрчилгээг 109189 иргэн, аж ахуйн нэгжид, мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний экспорт, импортын Олон улсын гэрчилгээг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын зөвшөөрлөөр 1421 иргэн, аж ахуйн нэгжид олгосон. 2020 онд улсын болон орон нутаг, төслийн хөрөнгө оруулалтаар аймаг, нийслэл, сум, дүүргийн мал эмнэлгийн үйлчилгээний 1125 нэгжид 1 тэрбум гаруй төгрөгийн бодит хөрөнгө оруулалт оруулаад байна. 2020 онд “Дижитал медик” ХХК хамтран Мал эмнэлгийн нэгдсэн системийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор малын өвчлөлийн мэдээллийн систем, мал амьтны эм, вакцины үйлдвэрлэл, мониторингийн мэдээллийн систем, лабораторийн удирдлагын мэдээллийн системийг хөгжүүлэхэд нийт 136.650.000 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Мал эмнэлгийн цахим гэрчилгээний ажлыг эрчимжүүлж, хяналт тавьж ажиллах тухай Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын албан даалгавар болон 2020-ны өдрийн 01/717 тоот албан бичгийг аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газруудад хүргүүлж, хяналт тавих ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. Мал эмнэлгийн	70%

					гэрчилгээний системийг хамтран ашиглах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа С.Баатаржав, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, Ерөнхий малын эмч Д.Түмэндэмбэрэл нарын хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд ажлын төлөвлөгөө батлуулав.	
52	2.33.Малын тоог чанарт шилжүүлж ашиг шим, хүртээмжийг сайжруулах, генетикийн нөөцийг хамгаалах, үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, шинэ үүлдэр, омгийг бий болгох, орон нутгийн мал үржлийн нэгжүүдийг чадавхжуулна.	1. Малын үржлийн ажлын стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, үржлийн шилмэл малыг бүртгэж, баталгаажуулдаг болох, бэлчээрийн монгол малыг тухайн орон нутагт нь зохицсон, төрөлжсөн үүлдрийн малыг ашиг шимийн чиглэлээр өсгөн үржүүлэх	2017 - 2020	Бэлчээрийн монгол малыг тухайн орон нутагт нь зохицсон цөм сүргийн малаар, эрчимжсэн аж ахуйд төрөлжсөн үүлдрийн малын ашиг шимийн чиглэлээр өсгөн үржүүлэх ажлыг зохион байгуулах	Бэлчээрийн монгол малыг тухайн орон нутагт нь зохицсон цөм сүргийн малаар, эрчимжсэн аж ахуйд төрөлжсөн үүлдрийн малын ашиг шимийн чиглэлээр өсгөн үржүүлэх ажлын хүрээнд Таван төрлийн малын үржлийн ажлын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-15 дугаар тушаалаар баталгаажуулан 2020-2030 онд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх чиглэлийг гаргав. Малын үржлийн ажлын стратеги төлөвлөгөөг хэвлэх санхүүжилтийг ХХААХҮ-ийн сайдын А-196 дугаар тушаалаар батлуулж, бүх шатны мэргэжлийн байгууллагад хүргүүлэхэд бэлэн болоод байна. Таван төрлийн малын үржлийн ажлын стратеги төлөвлөгөөг боловсруулснаар 52 үүлдэр, омгийн малын цөм сүргийн байршил, тархцын зураглалыг гаргаж, үүлдэр, омгийн малын ашиг шимийн чиглэл, үржүүлэх бүс нутгийн боломжит судалгааг гаргав. 2020 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр Баянхонгор аймгийн Баянбулаг суманд үржүүлж буй нутгийн шилмэл 8.0 мянган хонь, Булган аймгийн Бүрэгхангай суманд үржүүлж буй мах-ноосны чиглэлийн 15.0 мянган хонь, Өмнөговь аймгийн Цогт-Овоо суманд үржүүлж буй ноолуурын чиглэлийн 6.0 мянган ямаа, Төв аймгийн Батсүмбэр суманд үржүүлж буй сүү-махны хосолмол ашиг шимт 23.0 мянган үхэр, нийт 52.0 мянган малыг үзлэг ангилалтад хамруулж, үржлийн цөм сүрэг бүрдүүлж, тухайн бүс нутагт нь цэврээр нь өсгөн үржүүлэх чиглэлийг орон нутагт өгөв.	70%
53		2. Орон нутагт мал үржүүлэг, технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах нэгжүүдэд бодлогын болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх	2017 - 2020	Малын үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийг чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх	Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, чадавхийг сайжруулах зорилгоор "Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил" төсөл Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Архангай, Өвөрхангай, Дундговь зэрэг 6 аймгийн 18 суманд хэрэгжиж байна. Төсөл хэрэгжиж буй аймаг, сумдад үйл ажиллагаа явуулж байгаа Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжүүдэд шаардлагатай зоо багаж худалдан авахад зориулж 108.5 сая , өндөр ашиг шимт донор мал худалдан авахад зориулж 541.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг төслөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэж, ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А-80 дугаар тушаалаар "Цөм сүрэг худалдан авах, мал үржүүлэг, технологийн багаж, тоног төхөөрөмж, мал ангилалтын зөөврийн хашаа худалдан авах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах" тендерийн үнэлгээний	70%

					хороо 2 тендерийг 2020 оны 06 дугаар сарын 22-ны өдөр нээхээр ажиллаж байна. Төсөл хэрэгжиж буй 6 аймагт Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийг чадавхжуулахад орон нутгийн оролцооны хөрөнгө болгож аймаг бүр 36.0 сая төгрөг, нийт 216,0 сая төгрөгийн санхүүжилтээр нэгжид шаардлагатай багаж, хэрэгсэл, донор мал худалдан авах тендерийг зарлаад байна. Орон нутагт зохион байгуулах тендерийн явцыг хавсралтаар оруулав. Малын генетик нөөцийн тухай хуулийн хүрээнд Мал үржүүлэг, технологийн нэгж шинээр байгуулах хүсэлтэй иргэн, хуулийн этгээдэд мэргэжил арга зүйн зөвлөмжийг тогтмол өгч, нэгжид ажиллаж буй мал зүйч мэргэжилтэнг давтан сургах мэргэшүүлэх ажлыг сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулав. Орон нутгийн мэргэжлийн байгууллагыг дэмжих ажлын хүрээнд орон нутгийн төсөв болон төслийн санхүүжилтээр баруун 5 аймагт мал эзэмлэгч бахь 180, бар код уншигч, хэвлэгч тус бүр 19, Архангай аймгийн 19 сумын бүртгэлийн мэргэжилтэнд компьютер олгов.	
54	3. Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил, үйлчилгээний нэгж, мэргэжилтний хяналтанд авах, гойд ашиг шимт малын дуудлага худалдаа зохион байгуулах арга хэмжээг бүс нутгийн болон улсын хэмжээнд хэрэгжүүлэх	2017 - 2020	29 үүлдэр, 3 үүлдрийн хэсэг, 4 үржлийн хэсэг, 8 омог, 1 хэвшлийн малын удам үндэслэгчийн үнэт чанарыг үнэлэх мэдээллийн системийг бий болгох	Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил, үйлчилгээний нэгж, мэргэжилтний хяналтад авах, гойд ашиг шимт малын дуудлага худалдаа зохион байгуулахад шаардлагатай эрх зүйн зохицуулалт бий болгох зорилгоор “Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлэх, ашиглах технологийн журам”, “Гойд ашиг шимт мал шалгаруулах, дуудлага худалдаа зохион байгуулах журам”-ын төслийг боловсруулан холбогдох мэргэжлийн байгууллагуудаас саналыг авч тусган ХХААХҮЯ-ны Хуулийн хэлтсээр хянуулахад бэлэн болоод байна. 2020 оны хагас жилийн байдлаар улсын хэмжээнд Мал үржүүлэг, технологийн 131 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүний 77 нэгжид 5.0 мянган толгой хуц, ухна ялган төвлөрүүлж мэргэжлийн байгууллагын хяналтад аваад байна. Мэргэжлийн бус иргэн, малчинд улсын хэмжээнд 200.0 мянган толгой богийн хээлтүүлэгчийг хээлтүүлгийн бус үед сүргээс ялган төвлөрүүлээд байна. Хаврын үзлэг ангилалтад хамрагдсан баталгаажсан үүлдэр, омгийн малын хээлтүүлэгчийг удам зүйн үнэлгээнд оруулах зорилтын хүрээнд Малын удам зүйн үнэлгээний програмд ноолуурын чиглэлийн 9 үүлдэр, 3 омог, 1 үржлийн хэсгийн ямаа, мах-өөхний чиглэлийн бүдүүн, бүдүүвтэр ноост 11 үүлдэр, 3 үүлдрийн хэсэг, 3 үржлийн хэсэг, 3 омгийн хонины ашиг шимийн үзүүлэлтийг оруулж удам зүйн үнэлгээг хийж байна. Цаашид тус програмд нарийн, нарийвтар ноост 3 үүлдэр, арьсны чиглэлийн 1 үүлдрийн хонины үнэлгээг хийх нэмэлт сайжруулалт хийхээр ажлын даалгаварт тусган ажиллаж байна.	70%	

55		4. Шинэ үүлдэр, омгийн малын үржил, селекцийн ажилд хянан магадлагаа хийж баталгаажуулах, бүртгэх, тооллого явуулах, цөм сүрэг бүрдүүлэх, үржлийн малд үзлэг, ангилалт хийх ажлын цар хүрээг өргөтгөх, сүргийн зохист бүтцийг бүрдүүлэхэд чиглэгдсэн үржил селекцийн ажлыг эрчимжүүлэх	2017 - 2020		Улсын хэмжээнд 350.0 мянган толгой малд үзлэг ангилалт явуулах, стандартын шаардлага хангасан үржлийн мал бүхий цөм сүргийг бүрдүүлэх	Булган аймгийн Бүрэгхангай суманд үржүүлж буй мах-ноосны чиглэлийн нутгийн шилмэл 15.0 мянган хонь, Төв аймгийн Батсүмбэр суманд үржүүлж буй сүү-махны чиглэлийн хосолмол ашиг шимт 23.0 мянган үхрийн үржил, селекцийн ажилд хянан магадлагаа хийсэн ажлын тайланг Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Мал аж ахуй биотехнологийн сургуулийн эрдмийн зөвлөлийн хурал, Малын генетик нөөцийн Үндэсний зөвлөлдөх хорооны хуралдаанаар тус тус хэлэлцүүлэв. Үхрийн цөм сүргийн тоо 4.8 мянга, хонины цөм сүргийн тоо 5.1 мянгад хүрсэн нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А-145 дугаар тушаалаар баталсан “Үржлийн малд хянан магадлагаа хийх, баталгаажуулах, үүлдэрлэг байдлыг тодорхойлох, хяналт тавих журам”-ын шаардлагыг бүрэн хангасан тул Малын генетик нөөцийн үндэсний зөвлөлдөх хорооны 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн Төв аймгийн Батсүмбэр суманд үржүүлж буй сүү-махны чиглэлийн хосолмол ашиг шимт үхрийг "Үүлдрийн хэсэг", Булган аймгийн Бүрэгхангай суманд үржүүлж буй мах-ноосны чиглэлийн хонийг "Үржлийн хэсэг"-ээр тус тус батлуулахаар дүгнэлт гаргаж ХХААХҮ-ийн сайдын тушаалын төсөлд санал авч байна. Баянхонгор аймгийн Баянбулаг суманд үржүүлж буй нутгийн шилмэл 8.0 мянган хонь, Өмнөговь аймгийн Цогт-Овоо суманд үржүүлж буй ноолуурын чиглэлийн 6.0 мянган ямаанд орон нутгийн төсвийн хөрөнгөөр үзлэг ангилалт явуулж, хянан магадлагааг журмын дагуу зохион байгуулав. ХХААХҮ-ийн сайдын тушаалаар улсын төсвийн 430.0 сая төгрөгийн санхүүжилтээр 21 аймгийн 99 сумын 41123 адуу, 16803 үхэр, 15540 тэмээ, 97050 хонь, 34500 ямаа, 21500 сарлаг нийт 226516 толгой малд үзлэг ангилалт хийхээр төлөвлөж, 31824 бод, 92235 бог малыг хамруулж технологит ажлыг 100 хувь гүйцэтгээд байна. Малд үзлэг ангилалт хийх арга зүйг 21 аймаг, нийслэлийн Мал үржлийн албанд онлайнаар өгч, ажлын удирдамж, Мал үржүүлэг технологийн нэгж болон цөм сүрэг бүхий өрхийн малчидтай хийх гэрээний загварыг боловсруулж хүргүүлэв.	70%
56		5. Малын үржлийн үнэт чанар, удам зүйг үнэлэх системийг бий болгон Монгол Улсын үржлийн шилмэл малыг бүртгэж, мал бүхий	2017 - 2020		4 үржлийн хэсэг, 8 омог, 1 хэвшлийн малын удам зүйн үнэт чанарыг үнэлэх ажлыг хийх	Малын удам зүйн үнэлгээний программд ямааны 9 үүлдэр, 3 омог, 1 үржлийн хэсэг, хонины 11 үүлдэр, 3 үүлдрийн хэсэг, 3 үржлийн хэсэг, 3 омог болон үхрийн 3 үүлдрийн ашиг шимийн үзүүлэлтийг оруулан удам зүйн үнэлгээг хийж байна. Цаашид адууны 3 үүлдэр, 3 омог болон тэмээний 4 үүлдэр, 1 үржлийн хэсгийн мэдээлэл оруулж үнэлгээ хийх модуль нэмэх шаардлагатай байгаа тул Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А-80 дугаар тушаалаар "Малын удам зүйн үнэлгээний программ, цахим	70%

		иргэн, хуулийн этгээдийн малын чанараа сайжруулах идэвхи, сонирхлыг төрүүлэх, хөрөнгө оруулалтыг татах				хаяг, уламжлалт мэдлэгийн бүртгэлийн хөгжүүлэлт хийх" тендерийн үнэлгээний хороо байгуулагдсан. Малыг удам зүйн үнэлгээний программд нарийн, нарийвтар ноост хонь, адуу, тэмээнд удам зүйн үнэлгээ хийх нэмэлт цэс оруулах, тухайн программын хэрэглээний явцад гарсан алдаа, дутагдал болон орон нутгаас ирүүлсэн саналыг үндэслэн зарим сайжруулалт, өөрчлөлтийг нэмж оруулахаар ажлын даалгаврыг боловсруулав. Баталгаажсан 52 үүлдэр, омгийн малд удам зүйн үнэлгээ хийх, үржлийн үнэт чанараар үнэлэх заавар, чиглэлийг орон нутгийн мэргэжлийн байгууллагад хүргүүлэн өдөр тутмын программын гэмтэл, бүртгэлтэй холбоотой алдааг засварлан ажиллаж байна. Улсын хэмжээнд гойд ашиг шимт малын бүртгэл хөтлөх зорилгоор Үржлийн шилмэл малын бүртгэлийн дэвтрийн загварыг боловсруулж байна.	
57		6. Малыг удмын сангийн үндэсний цогцолборын эхний ээлжийг ашиглалтад оруулж, малын генийн санг баяжуулах, биотехнологийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, үр үйлдвэрлэл, зохиомол хээлтүүлгийн үйлчилгээг өргөтгөх	2017 - 2020	Улсын төсөв: 13.0 сая төгрөг.	Монгол малын генийн санг баяжуулж дотоодод үйлдвэрлэх гойд ашиг шимт малын гүн хөлдөөсөн үрийн хэмжээг 50.0 мянгад хүргэх, малын нөхөн үржихүйн биотехнологийн ололтыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэн хөгжүүлэх	Монгол малын генийн санг импортын гүн хөлдөөсөн үрээр баяжуулах зорилгоор өндөр ашиг шимт Эдельбай, Меринос, Брешион дучер, Романов зэрэг 4 үүлдрийн 6 хуцаас стандартын шаардлага хангасан 4390, сарлагийн бухаас 260, нийт 4650 тун үр 2019 онд авч хадгалсан. 2020 онд "Малын генетик нөөц-20000" аяныг өрнүүлж, 20000 тун үр үйлдвэрлэж, малчид, фермерийн 20000 толгой малд биотехнологийн дэвшилтэд аргыг ашиглан зохиомол хээлтүүлэг хийнэ. Орон нутгийн 23 мал үржүүлгийн техникчтэй уулзалт, семинар зохион байгуулж, хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар зохиомол хээлтүүлэгт хосолмол ашиг шимт бухын 2376, сүүний үхрийн 792, махны үхрийн 531, нийт 3699 тун гүн хөлдөөсөн үрийг малын үндэсний генийн сангаас захиалгын дагуу нийлүүлж, үржүүлгийн техникч нар нийт 1840 толгой үнээнд зохиомол хээлтүүлэг хийсэн. Шингэн азот үр үйлдвэрлэлд 480, үржүүлгийн техникч нарт 115, малын үндэсний генийн сангийн хэрэгцээнд 690, нийт 1285 л азот үйлдвэрлэн үйлчилгээнд ашиглав. Үр үйлдвэрлэлийн технологит хугацаанд махны чиглэлийн Гересфорд үүлдрийн 4, Сэлэнгэ үүлдрийн 3, Сүүний чиглэлийн Хар тарлан үүлдрийн 2, нийт 9 толгой бухаас стандартын шаардлага хангасан 7000 тун үрийг стандартын дагуу авч, хяналтад байлгаж, сорьцод нянгийн бохирдлын шинжилгээ хийлгэхээр Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторид хүргүүлэв. Өмнөх оны төвшинтэй харьцуулахад 60% буюу 2610 тун үр илүү үйлдвэрлэсэн байна. Бод малын зохиомол хээлтүүлгийн үржүүлгийн техникч бэлтгэх 80 цагийн (онол, дадлага) сургалтыг "Нутаг академи" ТББ, Нийслэлийн ХХААГ-тай хамтран 2020.06.07-17-ны өдрүүдэд СХД-ийн 21-р хороо, Нарийны фермд зохион байгуулж, 8 аймгийн 30 хүн хамрагдлаа. Малыг нөхөн	70%

					үржихүйн биотехнологийн ололтыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Дархан-Уул аймгийн ЗДТГ, ХХААГ, Нийслэлийн ХХААГ, ХААИС-ийн МААБТС, МААЭШХ, “Нутаг академи” зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулж, хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна.	
58	2.34. Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчлэн байгуулах үйл ажиллагаанд зээлийн дэмжлэг үзүүлж, өвс тэжээлийн аюулгүй нөөцийг нэмэгдүүлнэ.	1. Газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүсэд тэжээлийн үйлдвэр байгуулах, малын таримал тэжээлийн үр үржүүлгийн үйл ажиллагааг дэмжих	2017 - 2020	Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчилсэн байдлаар нэгийг шинээр байгуулах, тэжээлийн ургамлын үрийн шинэчлэл хийж тариалалтыг нэмэгдүүлэх	Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчилсэн байдлаар нэгийг шинээр байгуулах ажлын хүрээнд Дундговь аймгийн Сайнцагаан суманд сард 1150 литр биологийн идэвхит нэмэгдэл тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг 2019 онд шинээр барьж, 2020 оны эхний улирлаас ашиглалтад оруулж, орон нутгийн тэжээлийн нэмэлт хэрэгцээг 100 хувь хангах боломж бүрдсэн.	100%
59	2.35. Хөдөөгийн хүн ам болон мал аж ахуйн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор бэлчээрт худаг, хөв цөөрөм барьж байгуулан ашиглалт,	2. Өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх техник, тоног төхөөрөмжийг сайжруулж, өвс, тэжээлийн агуулахыг орон нутагт бий болгох	2017 - 2020	Өвс, тэжээлийн нөөцийн агуулахгүй сумдын байршлыг харгалзан шинээр 5 агуулах барих	2020 онд Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил /Нэмэлт санхүүжилт/ төслийн хүрээнд Архангай, Өвөрхангай, Дундговь, Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн ХХААГ-тай хамтран ажиллаж, төслийн хүрээнд өвс, тэжээлийн нөөцийн агуулахгүй сумдад өвс тэжээлийн агуулах 11 шинээр барих, өвс тэжээлийн агуулах 10 засварлах, орон нутагт ажлын байр 7 шинээр барих, 4 засварлах ажлыг төлөвлөн, орон нутагт худалдан авалтыг зохион байгуулж, хяналт тавин ажиллаж байна.	70%
60	2.35. Хөдөөгийн хүн ам болон мал аж ахуйн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор бэлчээрт худаг, хөв цөөрөм барьж байгуулан ашиглалт,	1. Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор инженерийн хийцтэй болон энгийн уурхайн худаг гаргах, цас, борооны ус тогтоох хөв	2017 - 2020	Шинээр 750 худаг, 4-өөс доошгүй хөв, цөөрөм барьж байгуулснаар нийт мал сүргийн усан хангамж 30 орчим	Улсын төсөв, орон нутаг, гадаадын төсөл хөтөлбөр, малчдын санаачилгаар инженерийн хийцтэй худаг 2017 онд 288, 2018 онд 457, 2019 онд 414 гаргасан нь 1.5 сая мал сүрэг, 799.5 мянган га бэлчээр, 2.6 мянган малчин өрхийг усаар хангах боломжийг бүрдүүлэв. БОАЖЯ-наас 2019-2020 онд улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Увс аймгийн Хяргас сумын Билүүгийн голд бэлчээр усан хангамж, тариалангийн усжуулалтын зориулалттай 180.0 мянган м3 багтаамжтай хөв цөөрмийн барилгын ажил 50 хувьтай явагдаж байна. 2020 онд “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт” төслийн санхүүжилтээр Архангай, Баян-Өлгий,	70%

	хяналтыг сайжруулна.	цөөрөм барьж байгуулах			хувиар нэмэгдэх	Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дундговь, Завхан, Сүхбаатар, Увс, Ховд, Хэнтий аймаг, Отрын бүс нутагт инженерийн хийцтэй 61 худгийг 1.5 сая төгрөгөөр барьж байгуулах ажлын тендер зохион байгуулаад байна. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжлийн нэмэлт санхүүжилт төслийн хөрөнгөөр Архангай, Өвөрхангай, Дундговь, Сүхбаатар, Хэнтий, Дорнод аймгуудад 157 шинэ худаг гаргах ажлын гэрээг Засаг дарга нартай гэрээ байгуулан орон нутагт тендер шалгаруулалт явагдаж байна. Бусад төслийн хөрөнгөөр Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дундговь, Завхан, Сүхбаатар, Увс, Ховд, Хэнтий аймаг, Отрын бүс нутагт инженерийн хийцтэй 61 худгийг 1.5 тэрбум төгрөгөөр барьж байгуулах ажлын үнэлгэний хорооны гишүүд 8 багцад үнэлгээ хийж, зөвлөмжийг ТНБД-д хүргүүлэв. Өдрийн сонины 2018.5.18-ны өдрийн дугаарт Говь-Алтай, Ховд, Дундговь аймагт шинээр гаргах худгийн нээлттэй тендерийн урилга хэвлэгдсэн. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжлийн нэмэлт санхүүжилт төслийн хөрөнгөөр Архангай, Хэнтий, Өвөрхангай, Дорнод аймагт шинээр гаргах худгийн ажлын тендерт шалгарч, гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүд өрөмдлөгийн ажлыг эхлүүлээд байна. Дундговь аймагт “Эхний эхэн” ХХК, “Тод дриллинг” ХХК, “Гранд холдинг” ХХК-ууд тендерт шалгарч гэрээ байгуулаад байна. Сүхбаатар аймагт тендер шалгаруулалтыг дахин явуулахаар болсон.	
61		2. Нар, салхины сэргээгдэх эрчим хүчийг ашиглан газрын гүнээс ус татах тоног төхөөрөмжийг хуучин инженерийн хийцтэй худгуудыг засварлан суурилуулах, худаг гаргах үйл ажиллагаанд шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх	2017 - 2020	Орон нутаг:52.8 Төсөл хөтөлбөр: 123.8 Бусад: 64.5	Инженерийн хийцтэй 25-аас доошгүй худагт нар, салхины эрчим хүчээр ажиллах ус өргүүр суурилуулах	2020 онд Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжлийн нэмэлт санхүүжилт төслийн 123.2 сая төгрөг, орон нутгаас 52.8 сая төгрөгийн хөрөнгөөр Өвөрхангай аймгийн 8 суманд шинээр гаргасан 8 худагт нарны эрчим хүчээр ажиллах ус өргүүр суурилуулах ажлын тендерийг орон нутагт зарлахад бэлэн болоод байна. Усны төлбөрийн орлогоос 64.5 сая төгрөгийн хөрөнгөөр Өмнөговь аймгийн Баяндалай, Цогт-Овоо суманд 2 худаг шинээр гарган цагийн тохируулгатай нарны эрчим хүчээр ажиллах ус өргүүрийг тус аймгийн “Ундарга-Өмнөговь” ХХК хийж гүйцэтгэсэн байна. 2020 оны эхний хагас жилийн байдлаар инженерийн хийцтэй гүний нийт 10 худагт нарны эрчим хүчээр ажиллах ус өргүүр суурилуулах ажил хийгдэж байна.	40%
62	2.36. Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах,	1. Бэлчээрийн харилцааг зохицуулах Бэлчээр хамгаалах тухай	2017 - 2020		Хууль батлагдсаны дараах сурталчилгаа	Хууль тогтоомжийн тухай хууль, холбогдох аргачлалын дагуу “Бэлчээрийн тухай” хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, дагалдах хуулийн төслийг тус тус боловсруулж, сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Хуулийн үзэл баримтлал,	40%

	<p>төлөв байдлыг тогтоох, хянах, сэргээн сайжруулах, доройтол, талхагдал, цөлжилтийг бууруулах, бэлчээрт хөнөөл учруулж байгаа мэрэгч амьтан, шавжтай тэмцэхэд малчдын оролцоог нэмэгдүүлж, байгаль орчинд халгүй, дэвшилтэт аргыг ашиглана.</p>	хуулийн төслийг боловсруулах			<p>болон холбогдох дүрэм, журмыг боловсруулж мөрдүүлэх</p>	<p>хуулийн төсөлд хөндлөнгийн үнэлгээг НҮБ-ын ХХААБ, Бодлого судлалын төв хамтран гүйцэтгэж 11 аймагт хэлэлцүүлэг зохион байгуулсан. УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны 2018 оны 8 дугаар тогтоолоор Засгийн газарт "...Бэлчээрийн тухай хуулийн төслийг боловсруулан өргөн мэдүүлэх..." чиглэл өгсний дагуу явц, үүссэн нөхцөл байдлын талаар сайд Ч.Улаан Засгийн газрын хуралдаанд танилцуулга хийж, 2019 оны хуралдааны 18 дугаар тэмдэглэлд "Бэлчээрийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг 2019 оны 4 дүгээр сард багтаан батлахыг ХЗДХ-ийн сайд Ц.Нямдорж, ХХААХҮ-ийн сайд Ч.Улаан, БХБ-ын сайд Х.Баделхан нарт, хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг сайд Ч.Улаанд тус тус даалгасан. ХХААХҮЯ болон БХБЯ-ны төлөөлөл Бэлчээрийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөлд гарын үсэг зурж, ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 01/1514 тоотой ХЗДХ-ийн сайдад хуулийн үзэл баримтлалын төслийг хүргүүлсэн ч 2019 оны 1-1/1882 тоот албан бичгээр тус төслийг хамтран батлах боломжгүй гэж буцаасан. УИХ-ын Тамгын газар, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны санаачилгаар "Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх нь" сэдэвт үндэсний хэлэлцүүлгийг 2019.05.07-ны өдөр зохион байгуулж, 20 аймаг 316 сумын малчид, орон нутгийн удирдлагын төлөөлөл 780 хүн оролцож, 80 гаруй төлөөлөгч үг хэлж, байр сууриа илэрхийлэн, 728 оролцогч бичгээр санал өгч, зөвлөмжийн төслийг төлөөлөгчдийн олонхын саналаар баталж, УИХ, Засгийн газарт хүргүүлсэн боловч хуулийн төслийг хэлэлцээгүй байна.</p>	
63		<p>2. Бэлчээрийн газар зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгох, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг орон нутгийн төр захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах</p>	2017 - 2020	Улсын төсөв: 1400.0 сая	<p>Зүүн бүсийн аймгуудын талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	<p>2020 онд зүүн аймгуудын бэлчээрт хөнөөл учруулж буй үлийн цагаан оготной тэмцэх ажлыг микробиологи болон энгийн механик аргаар улсын төсвийн 1.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр нийт 771.6 мянган га бэлчээрт зохион байгуулж, мал аж ахуйн үйлдвэрлэлд ашиглах боломжийг бүрдүүлсэн. Үүнд: Дорнод аймгийн 13 сумын 235.0 мян га талбайд 421.0 сая төгрөг, Сүхбаатар аймгийн 12 сумын 322.6 мян га талбайд 604.1 сая төгрөг, Хэнтий аймгийн 13 сумын 214.0 мян га талбайд 359.5 сая төгрөгийн хөрөнгөөр ажлыг зохион байгуулсан. Мөн доройтолд орсон нийт 350.0 мянган га бэлчээрийг сэлгэн өнжөөж, малын хөлөөс чөлөөлөн сайжруулж байгаа нь өмнөх оны түвшинтэй харьцуулахад 125.0 га талбайгаар илүү байна. "Ногоон алт-Малын эрүүл мэнд" төслөөс 21 аймгийн 186 суманд 1362 бэлчээр ашиглагчдын хэсэг байгуулж, 2019 оны жилийн эцсийн байдлаар 11 аймгийн 830 бэлчээр ашиглагчдын хэсэг сумын Засаг даргатай бэлчээр ашиглах гэрээг 15 жилийн хугацаатай байгуулж бэлчээрийн</p>	100%

					ашиглалт, хамгаалалтыг малын хөлөөс тодорхой хугацаанд чөлөөлөн, сайжруулж байна. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хүрээнд Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн 9 суманд нийт 66 бэлчээр ашиглагчдын малчдын бүлэг байгуулж, малчдын бүлгийн бэлчээрийн менежментийн 3 жилийн төлөвлөгөөний дагуу 2020 онд Хэнтий аймгийн Батширээт сум 23343.28 га, Өмнөдэлгэр сум 101533.64 га, Норовлин сум 48000 га, Дорнод аймгийн Сэргэлэн сум 17273.85 га, Халхгол сум 52074.77 га бэлчээрийн тайлбайг малын хөлөөс чөлөөлж, өнжөөхөөр төлөвлөсөн.	
64	3. Байгаль, экологийн онцлогтой уялдуулан бэлчээрийн газарт бүсчлэл тогтоож, бүс тус бүрийн төлөв байдлыг үнэлэх, хянах ажлыг зохион байгуулах	2017 - 2020		Зүүн бүсийн аймгуудын бэлчээрийн төлөв байдлын үнэлгээг хийх	Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын Ачит нуур, Баян нурууны отрын бүс нутгийн бэлчээрийн газар зүйн байршил, хөрс, ургамалжилтын судалгааг тус тус хийж бэлчээрийн төлөв байдлыг үнэлгээг “Вектор мэл” ХХК 2019 оны 08 дугаар сард гүйцэтгэсэн. Отрын бүс нутгийн бэлчээрийн ашиглалтын онцлогт үндэслэн төлөв байдлыг хянах мониторингийн цэг байгуулан тэмдэглүүлж, суурь мэдээлэл цуглуулснаар цаашид ашиглалт, хамгаалалтыг зөв зохистой явуулах зөвлөмж гаргаад байна. Дорнод, Сүхбаатар аймгийн Хялганат хээрийн бэлчээрийн тэжээлийн зэрлэг ургамлын биологийн идэвхт нэгдлийн судалгааг 2019 онд Монгол Улсын их сургууль хийж гүйцэтгэсэн. Хялганат хээрийн бэлчээрт зонхилох 10 төрлийн ургамлын тэжээллэг чанар (уураг, өөх тос, нүүрс ус, эслэг) болон мал идэх идэмжийг харьцуулан судалж, ядарсан мал амтархан идэж хурдан тэнхэрдэг Сиверсийн шарилжид агуулагдах биологийн идэвхт хоёрдогч метаболитийн хөдлөл зүйн судалгааг хийж гүйцэтгэсэн. 2020 онд Дорнод, Сүхбаатар аймгийн отрын нөөц бэлчээрийн судалгааг Аймаг дундын отрын бэлчээр ашиглагчдын захиргаатай хамтран аймаг, сумын ЗДТГ-тай хамтран гүйцэтгэж байна. Үүний хүрээнд тухайн бэлчээрийн төлөв байдлын судалгааг гүйцэтгэж байна.	70%
65	4. Улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээний нөөц бэлчээрийг шинээр бий болгох, ашиглалтыг сайжруулах	2017 - 2020	Улсын төсөв: 113.0 сая төгрөг.	Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бэлчээрийг 50.0 мян.га-аар нэмэгдүүлэх	Завхан аймаг дахь Бага хайрхан, Хэнтий аймаг дахь Хэрлэнбаян-Улаан, Ховд аймаг дахь Баян нуруу, Увс аймаг дахь Ачит нуур, Говьсүмбэр аймаг дахь Малах, Говь-Алтай аймаг дахь Аргалант, Булган аймаг дахь Чилэнгийн аймаг дундын отрын бүс нутгийн бэлчээрийн төлөв байдлын судалгааг 2017-2019 онд мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймаг дундын отрын бүс нутгуудыг журамд заасан хугацаанд ашиглах, малын хөлөөс чөлөөлөх, малын сэг зэм устгах, ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг сумдын мал эмнэлгийн тасгуудтай хамтран зохион байгуулсан. Бэлчээрт хөнөөл учруулж буй үлийн цагаан оготныг хаврын улиралд	70%

					энгийн механик аргаар устгах ажлыг Хэрлэнбаян-Улаан, Чилэн, Малах, Хөхдэл отрын бүс нутгуудад нийт 64.375 мян.га талбайд зохион байгууллаа. Ховд аймгийн ИТХ 2019 онд Дарви суманд 75000 га, Мөнххайрхан суманд 27300 га, нийт 102.3 мянган га бэлчээрийг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч сум дундын отрын бүс нутгаар ашиглаж байна. ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-153 дугаар тушаалаар Сүхбаатар, Дорнод, Дундговь, Өмнөговь, Өвөрхангай, Архангай, Хөвсгөл, Ховд аймгийн орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц бэлчээрийн судалгаа хийх ажлын хэсгийг байгуулж, Сүхбаатар, Дорнод аймагт судалгааг дуусгаж, Дундговь, Өмнөговь, Өвөрхангай, Архангай аймагт отрын нөөц бэлчээрийн судалгааг эхлээд байна.		
66		5. Бэлчээрт хөнөөл учруулж буй үлийн цагаан оготно, царцаатай байгаль орчинд халгүй, дэвшилтэт арга технологи ашиглан тэмцэх арга хэмжээг өргөжүүлэх, малчдын оролцоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	2017 - 2020	Улсын төсөв: 4.6 Орон нутгийн төсөв: 971.0	Үлийн цагаан оготно тархсан 16 аймгийн 860.0 мян.га, царцаа тархсан 4 аймгийн 140.0 мян.га талбайд тэмцэх ажлыг зохион байгуулах, бэлчээрийн даац, багтаамжийг 1000.0 мян.га-аар нэмэгдүүлэх	Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд бэлчээрт хөнөөл учруулж буй үлийн цагаан оготно, царцаатай байгаль орчинд халгүй, дэвшилтэт арга технологи ашиглан тэмцэх арга хэмжээг өргөжүүлэх, малчдын оролцоог нэмэгдүүлэх ажлыг жил бүр зохион байгуулж байна. ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-89 дүгээр тушаалын хүрээнд бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээг 1.3 сая га талбайд улсын төсвийн 5.0 тэрбум төгрөгөөр тэмцэхээр төлөвлөж, ажлыг зохион байгуулж байна. Үлийн цагаан оготной Аймаг дундын отрын бүс нутгийн 66.3 мян га, 17 аймгийн 159 сумын 1.016 сая га бэлчээрт энгийн механик аргаар тэмцэхэд улсын төсвийн 1.8 тэрбум төгрөг, 8 аймгийн 34 сумын 285.0 мянга га бэлчээрт микро биологийн аргаар тэмцэхэд 2.8 тэрбум төгрөгийг зарцуулж, орон нутгаас тайланг хүлээн авч байна. 3 аймгийн 66.0 мянган га талбайд царцаатай тэмцэх ажлын тодотгох сулгаанд орон нутгийн төсвөөс 971.0 сая төгрөг зарцуулан хийж, тэмцэх ажлын бэлтгэл хангав. Үлийн цагаан оготнын бэлчээрт учруулах хөнөөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажилд 2019 онд улсын төсвийн 3.1 тэрбум, орон нутгийн төсвийн 570.0 сая, нийт 3.7 тэрбум төгрөг зарцуулж 1.3 сая га бэлчээрийн талбайг хамруулсан бол 2020 оны эхний хагас жилийн байдлаар 4.6 тэрбум төгрөгөөр 1.3 сая га талбайд тэмцэж байна. Өмнөх оны төвшинтэй харьцуулахад 0.9 тэр бум төгрөг илүү зарцуулсан байгаа нь микробиологийн аргаар тэмцэж байгаа талбайн хэмжээ их байна.	70%
67	2.37.Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангахад	1. Малын генетик нөөцийн тухай, Бэлчээр хамгаалах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн	2017 - 2020			"Малын генетик нөөцийн тухай хуулийг УИХ-аас 2017 оны 82 дугаар тогтоолоор, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг УИХ-аас 2017 онд "Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль"-ийг соёрхон баталсан, Засгийн газрын 2020 оны 34 дүгээр тогтоолоор "Монгол малчин" үндэсний хөтөлбөрийг соёрхон баталж, тогтоол гарсантай	70%

	чиглэгдсэн Малын генетик нөөцийн тухай, Бэлчээр хамгаалах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Мал аж ахуйн хөгжлийг дэмжих тухай хуулийг тус тус боловсруулан батлуулж, эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ.	тухай, Мал аж ахуйн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслүүдийг тус тус боловсруулах				холбогдуулан “Малчдыг дэмжих зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2016 оны 90 дүгээр тогтоол, “Мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих дэд хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2016 оны 114 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсон. “Бэлчээрийн тухай” хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг холбогдох аргачлалын дагуу холбогдох судалгаа, хэлэлцүүлгийг зохион байгуулж, УИХ, Засгийн газарт хүргүүлсэн. Малын генетик нөөцийн тухай хуулийг дагалдан гарах бичиг баримтаас 2018 онд 4 журам, 14 заавар, 2019 онд 8 журам, 3 стандарт, 4 заавар, нийт 33 эрхзүйн актыг баталсан. Бэлчээр хамгаалах тухай, ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А-37 дугаар тушаал "Мал аж ахуйн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай"-ын хүрээнд Мал аж ахуйн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хууль болон хуулийн төсөл боловсруулах аргачлалын дагуу боловсруулав.	
68	2.38.Мал аж ахуй эрхлэх уламжлалт хэв маяг, мэдлэгийг хадгалах, баяжуулах, малын тоо, төрөл, сүргийн бүтцийн зохист харьцааг баримтлах, эрчимжсэн аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.	1. Мал аж ахуй эрхэлж ирсэн олон зуун жилийн уламжлалт мэдлэгийг бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх, сурталчлах арга хэмжээг хэрэгжүүлэх	2017 - 2020		МАН эрхэлж ирсэн уламжлалт мэдлэгийг бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлж, сурталчлах	Малын удам зүйн үнэлгээний программыг түшиглэн уламжлалт мэдлэгийн сангийн нэмэлт модулыг бий болгон мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх 29 уламжлалт мэдлэг бүртгээд байна. Тухайн сангаас мэдээллийг https://muz.gov.mn/ цахим хуудаст байршуулан олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчлах ажлыг хэрэгжүүлж байна. Цаашид уламжлалт мэдлэг бүртгэх аргачлалын төслийг боловсруулж санал авахад бэлтгэж байна. Мал аж ахуй эрхэлж ирсэн олон зуун жилийн уламжлалт мэдлэгийг түгээх, сурталчлах зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтран "Малчин өрх бүр үйлдвэрлэгч", "Малчин өрхөд үйлдвэрлэх сүү, цагаан идээ" зэрэг малчдад зориулсан гарын авлагыг 2400 ширхэгийг хэвлэн орон нутагт хүргүүлэв. Мөн ХХААХҮЯ-ны дэргэдэх "Мал аж ахуйн салбарыг болзошгүй эрсдэлээс хамгаалах, эрсдэлийг бууруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих шуурхай штаб"-ын ажлын төлөвлөгөөнд тусгасны дагуу "Мал сүргийг арчилж тордож, тэжээх уламжлалт арга" товхимолыг малчид, мал бүхий иргэдэд түгээсэн.	100%
69	төрөлжүүлэн хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2. Үхэр сүргийн таваарлаг байдал, тоог өсгөх, сүрэгт эзлэх хээлтүүлэгч, хээлтэгчийн тоог зохистой түвшинд барих, тоо нь цөөрч	2017 - 2020		Нийт мал сүрэгт үхрийн эзлэх хувийг 8.0 хувьд хүргэх	Үхэр сүргийн таваарлаг байдал, тоог өсгөх, сүрэгт эзлэх хээлтүүлэгч, хээлтэгчийн тоог зохистой түвшинд барих, тоо нь цөөрч болзошгүй үүлдэр, омгийн мал үржүүлж буй иргэн, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх зорилгоор Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжил /Нэмэлт санхүүжилт/ төслийн хөрөнгөөр Махны чиглэлийн Хар, улаан Ангус, Геррефорд, сүүний чиглэлийн Хар тарлан, мах-сүүний чиглэлийн хосолмол ашиг шимт Симменталь үүлдрийн үхрийн	70%

		<p>мөхөлд хүрч болзошгүй үүлдэр, омгийн мал үржүүлж буй иргэн, ААНБ-д мэргэжил арга зүйн болон хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх</p>			<p>хээлтэгч, хээлтүүлэгчийг ОХУ, Казакстанаас импортлох ажлын тендер зарлаад байна. Мөн Төв аймгийн Батсүмбэр суманд үржүүлж буй сүү-махны чиглэлийн хосолмол ашиг шимт үхрийн үржил селекцийн ажлын үр дүнг хянан магадлаж, хот орчмын хүн амын сүүний хэрэгцээг хангах боломжтой гэж дүгнэсэн тул бие даасан "Үүлдрийн хэсэг"-ээр баталгаажуулав. Зүүн бүсийн аймгийн хүн амын махны хэрэгцээг хангах боломжтой махны чиглэлийн "Дорнод Монголын улаан үүлдэр", хот орчмын бүсийн хүн амын сүүний хэрэгцээг хангах боломжтой сүү-махны чиглэлийн "Буган халиун" үүлдрийн хэсгийн үхэр сүргийн тоо толгойг нэмэгдүүлэх зорилгоор 2020-2030 онд хэрэгжүүлэх үржил селекцийн ажлын хөтөлбөрийг баталж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах чиглэлийг холбогдох аймаг, сумдын Засаг дарга нарт өгөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр "Дорнод Монголын улаан үүлдэр"-ийн үхрийн тоо толгойг 47.5 мянгад хүргэж, сүрэгт үнээний эзлэх хувийн жинг 46.0 хувь буюу 21.8 мянгад хүрсэн байна. Буган халиун үүлдрийн хэсгийн үхэр үржүүлж буй саалийн эрчимжсэн аж ахуй болон жижиг, дунд фермерийн аж ахуйн сүү үйлдвэрлэлийн хэмжээ 2025 онд 20.8 хувиар, 2030 онд 10 хувиар тус тус нэмэгдэнэ гэж тооцов. Нийт мал сүрэгт үхрийн эзлэх хувь 2019 онд 6.6% байсан бол 2020 оны эхний хагас жилийн байдлаар 6.7% болж, өмнөх оны түвшинтэй харьцуулахад 0.1%-иар нэмэгдсэн байна. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийн асуудлаар 2020 оны эхний хагас жилд 179 иргэн аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй биечлэн уулзаж, 168 иргэн аж ахуйн нэгжийн төлөөлөлд утсаар заавар зөвлөгөө өгч, 5 аж ахуйн фермийн үйл ажиллагаатай танилцав.</p>	
70		<p>3. "Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих" хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх</p>	2017 - 2020	<p>Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах</p>	<p>ЭМАА хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн 2020 оны төлөвлөгөөг боловсруулан холбогдох байгууллагаас санал авч нэгтгэн МААХБЗГ-ын даргаар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулж байна. Монгол улсын Засгийн газар Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын Экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр газар тариалангийн бүс нутагт 600 үнээ бүхий сүүний эрчимжсэн 5 цогцолбор ферм байгуулах төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж, төслийн баримт бичгийг 2020 оны 2 сард зарлан, 5 аж ахуйн нэгжийг эхний ээлжид сонгон шалгаруулж, манай талаас хамаарах ажлуудыг дэс дараатай зохион байгуулж байна. Сүүний үхрийн кластерийн системийг Төв аймгийн Баяндэлгэр, Эрдэнэ, Баянчандмань, Борнуур, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Хан-Уул дүүргийн Өлзийт хороололд тус тус байгуулж байна. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил /Нэмэлт санхүүжилт/ төслийн хүрээнд Архангай, Өвөрхангай, Дундговь, Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн ХХААГ-тай хамтран</p>	70%

					ажиллаж, төслийн хүрээнд инженерийн хийцтэй худаг 158 шинээр барьж байгуулах, бог малын угаалгын ванн 87 шинээр барих, малчдад сургалт мэдээллийн төв 9 тохижуулах, өвс тэжээлийн агуулах 11 шинээр барих, өвс тэжээлийн агуулах 10 засварлах, орон нутагт ажлын байр 7 шинээр барих, 4 засварлах ажлыг төлөвлөн, орон нутагт худалдан авалтыг зохион байгуулж, хяналт тавин ажиллаж байна. Малын генетик нөөцийн Үндэсний зөвлөлдөх хорооны 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар “Зөгийн аж ахуйд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-ийн төслийг хэлэлцүүлж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар батлуулах дүгнэлт гаргуулав.	
71	4. Нийслэл хот болон томоохон хот суурингийн ойролцоо сүү, махны чиглэлийн арвин ашиг шимтэй үхрийн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх, хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах	2017 - 2020		Сүү, махны чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуй эрхэлж буй 10-аас доошгүй ААН, иргэдэд зээлийн дэмжлэг үзүүлэх	Зөгийн аж ахуйг тогтвортой хөгжүүлэхэд зөгийчдийн мэдлэгийг дээшлүүлж, гадаад харилцаа, хамтын ажиллагаа өргөжүүлэх хүрээнд Монголын талаас 6 хүний бүрэлдэхүүнтэй баг Канад улсын Монреаль хотод зохион байгуулсан “APIMONDIA-46” их хуралд 2019 оны 9 дүгээр сарын 8-аас 09-р сарын 12-ны өдөр оролцож, үзэж сонирхсон мэдсэн туршлагаараа зөгийчдөд сурталчилж байна. 2019 онд ЖДҮХС-гаас тахианы 8 аж ахуйн нэгжид 690 сая, гахайн 4 аж ахуйн нэгжид 179.5 сая, зөгийн 1 аж ахуйн нэгжид 281 сая, загасны 1 аж ахуйн нэгжид 30 сая төгрөг, нийт 14 иргэн, аж ахуйн нэгжид 1.180,5 сая төгрөгийн зээл олгосон ажлын хэрэгжилт, үр дүнг тооцож, хяналт тавин ажиллаж байна. 2020 онд “Түмэн шувуут” ХХК өөрийн хөрөнгөөр шувууны сангасаар тариалангийн зориулалт бүхий бордооны үйлдвэр байгуулж, ашиглалтад бүрэн орууллаа. “Зургаан хошуу” ХХК үржлийн цөм сүргийн гахайг Дани улсаас оруулж ирэх гэрээ хэлцэл хийж арилжааны банкнаас зээл авахад нь яамнаас тодорхойлолт гаргаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.	70%
72	5. Гахай, тахиа, шувуу, зөгий, загасны аж ахуйг хөгжүүлэхэд мэргэжил арга зүйн болон зээлийн дэмжлэг үзүүлж, импортын бүтээгдэхүүний тоо хэмжээг бууруулах	2017 - 2020		Гахай, тахиа, шувуу, зөгий, загасны аж ахуй эрхэлж буй 5-аас доошгүй ААН, иргэдэд зээлийн дэмжлэг үзүүлэх	Зөгийн аж ахуйг тогтвортой хөгжүүлэхэд зөгийчдийн мэдлэгийг дээшлүүлж, гадаад харилцаа, хамтын ажиллагаа өргөжүүлэх хүрээнд Монголын талаас 6 хүний бүрэлдэхүүнтэй баг Канад улсын Монреаль хотод зохион байгуулсан “APIMONDIA-46” их хуралд 2019 оны 9 дүгээр сарын 8-аас 09-р сарын 12-ны өдөр оролцож, үзэж сонирхсон мэдсэн туршлагаараа зөгийчдөд сурталчилгаа хийж байна. 2019 онд ЖДҮХС-гаас тахианы 8 аж ахуйн нэгжид 690 сая, гахайн 4 аж ахуйн нэгжид 179.5 сая, зөгийн 1 аж ахуйн нэгжид 281 сая, загасны 1 аж ахуйн нэгжид 30 сая төгрөг, нийт 14 иргэн, аж ахуйн нэгжид 1.180,5 сая төгрөгийн зээл олгосон ажлын хэрэгжилт, үр дүнг тооцож, хяналт тавин хамтран ажиллаж байна. 2020 онд Түмэн шувуут ХХК өөрийн хөрөнгөөр шувууны сангасаар хөдөө аж ахуйн тариалангийн	40%

					зориулалт бүхий бордооны үйлдвэр байгуулж, ашиглалтад бүрэн орууллаа. “Зургаан хошуу” ХХК үржлийн цөм сүргийн гахайг Дани улсаас оруулж ирэх гэрээ хэлцлээ хийж арилжааны банкнаас зээл авахад нь яамнаас тодорхойлолт гаргаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. ЖДҮХС-гаас ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдэд олгох зээл 2020 оны эхний хагас жилийн байдлаар олгогдож эхлээгүй байна.	
73	2.39.Эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг тогтоон үр тариа, төмс, гол нэрийн хүнсний ногоог 100 хувь, таримал тэжээлийн 50 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангана.	1. Төвийн бүсэд тариалангийн газрын боломжит орон зайн ашиглалтыг сайжруулж, баруун, зүүн бүсэд атаршсан газрыг эдийн засгийн эргэлтэд оруулан, бүртгэл хяналтыг сайжруулан нэгдсэн мэдээллийн сантай болох	2017 - 2020	Баруун бүсийг 70.0 мян.га, зүүн бүсийг 190.0 мян.га, төвийн бүсийг 600.0 мян.га, хангайн бүсийг 100.0 мян.га, нийт 960.0 мян.га талбайд хүргэх	Газар тариалангийн бүртгэл мэдээллийн нэгдсэн цахим сан байгуулах ажлыг зохион байгуулж байна. Тус ажлын хүрээнд бүртгэл мэдээллийн цахим сан байгуулах тендерийн үнэлгээний хороог байгуулж тендерийн баримт бичгийг боловсруулан ХААДсан дээр хүргүүлэн ажиллаж байна.	40%
74		2. Газар тариалангийн гаралтай бүтээгдэхүүнд төрөөс олгох татаас, хөрөнгө оруулалт, мөнгөн урамшууллын тогтолцоог боловсронгуй болгож, бүтээгдэхүүний борлуулалтыг биржийн арилжаанд шилжүүлэх	2017 - 2020	Гурил үйлдвэрлэлд 350.0 мян.тонн буудай нийлүүлэх, тонн тутамд олгох урамшууллыг 100.0 мянган төгрөгт хүргэх	2020 оны төсөвд урамшуулалд зориулан 12.9 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд Засгийн газрын 2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэлийн дагуу 2019 оны ургацаас гурил үйлдвэрлэлд нийлүүлсэн хүнсний улаанбуудайнд тонн тутамд олгох урамшуулалын хэмжээг 100.0 мянган төгрөг болгон нэмэгдүүлэх, түүнд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг төсөвт тусган шийдвэрлэхээр даалгасны дагуу нэмж 10.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлсэнээр 2019 оны ургацаас гурил үйлдвэрлэлд нийлүүлэгдсэн 247.8 мянган тонн хүнсний буудайн тонн тутамд чанарын ангилалд хамруулан ялгавартайгаар урамшуулал олгосон бөгөөд гүйцэтгэлээр нийтдээ 804 аж ахуйн нэгж, иргэний гурил үйлдвэрлэлд нийлүүлсэн 247.8 мянган тонн хүнсний буудайнд 23.9 тэрбум төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон болно.	100%
75		3. Төрөөс олгох татаас, хөрөнгө оруулалт, мөнгөн урамшууллын тогтолцоог	2017 - 2020	Төмсний хэрэгцээг 100 хувь, ногооны хэрэгцээг	Тариалангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны “Газар тариалангийн тогтвортой хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 138 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны “Коронавируст халдвар /Covid-19/ -ын цар тахлын үед эдийн засгийг идэвхижүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн	40%

		боловсронгуй болгож, жилд төмс тариалах 15.0 мян.га, хүнсний ногооны 8.5 мян.га талбайд тариалалт хийхээр тооцож урамшуулал олгох		100 хувь хангах	хамгааллын зарим арга арга хэмжээний тухай” 167 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Сангийн сайдын 2019 оны 290/А-504 дугаар тушаалаар баталсан “Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх” журмын 3.4 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвийн 160.0 сая төгрөгийн 11 нэр төрлийн 5082 кг үр, НҮБ-ын ХАА-н байгууллагаас буцалтгүй тусламжаар олгосон 100 сая төгрөгт 10 нэр төрлийн 3372.6 кг үрийг 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн ногоочид, хуулийн этгээдэд буцалтгүй тусламжаар олгов.	
76		4. Эх орны төмсний шинэ сортын суперэлит үр үйлдвэрлэх, вирусгүй бичил булцуун үрээр дотоодын хэрэгцээг хангахад дэмжлэг үзүүлэх	2017 - 2020	Вирусгүй бичил булцууг 125 мянган ширхэг, элит үр 400 тонныг үйлдвэрлэж, жил бүр үр шинэчлэлийн системийг тогтворжуулах	2020 оны 06 сарын 08-ны байдлаар 125.0 мянган ширхэг вирусгүй бичил булцуугаар супер элит үр, 50 тн супер элит үрээр элит үр үйлдвэрлэх тариалалтыг 20 га -д хийв. Гидропоник орчинд вирусгүй бичил булцуу 180.0 мянган ширхэг хураан авах тариалалтыг агротехнологийн хугацаанд хийсэн. Вирусгүй бичил булцуугаар үржүүлж үйлдвэрлэсэн 45 тн Гала сортын супер-элит төмсний үрээр үр шинэчлэлтийг /2018 оны ургацаас/ орон нутагт ХХААХҮ-н сайдын А-136 дугаар тушаалаар хуваарилан 16 аймгийн ХХАА-н газарт үр шинэчлэлд зориулан 18 га талбайд тариалалт хийж 430 тн үрийн ургац хураан авлаа. 2020 онд 172 га талбайд элит үрээр тариалалт хийх боломж бүрдүүлээ.	100%
77		5. Хүнсний ногооны үр үйлдвэрлэлийг төвийн бүсэд Дархан-уул аймгийн УГТЭШХ-г, баруун бүсэд Увс аймагт, зүүн бүсэд Дорнод, Хэнтий аймгийн үр үйлдвэрлэгчдийг түшиглэн хөгжүүлэх, нэр төрлийг нэмэгдүүлэхэд дэмжих	2017 - 2020	Ил талбайн ногооны үр 10 нэр төрлийг үйлдвэрлэж, хэрэгцээг бүрэн хангах	Увс аймгийн ногооны үр үйлдвэрлэгч тусгай зөвшөөрөл бүхий 40 иргэнтэй 3 нэр төрлийн 7000 кг үр, 2 нэр төрлийг шинээр үйлдвэрлэх гэрээг МХҮТФХ ТББ хийсэн. Улсын төсвийн 108 сая төгрөгт шар лууван 2500 кг, шар манжин 700 кг, хүрэн манжин 330 кг-ийг, ХУБ-ын ХХААБ-ын 62 сая төгрөгт буцалтгүй тусламжийн хүрээнд шар лууван 1300 кг, шар манжин 500 кг, хүрэн манжин 330 кг -ийг худалдан авалтаар авч үр үйлдвэрлэгчийн борлуулалтыг дэмжсэн.	40%
78		6. Хүнсний ногооны нэр төрлийг нэмэгдүүлэх, сортуудыг турших,	2017 - 2020	Хүнсний ногооны нэр төрлийг 25 шинэ	Хүнсний ногооны 20 сортыг Монгол ногоо төслийн хүрээнд Увс аймгийн Улаангом сумын ногоочид, үр үйлдвэрлэгчдэд, Төв аймгийн Борнуур сум, Дархан-уул аймгийн Орхон, Сэлэнгэ аймгийн Мандал сумын нэвтрүүлэх төвийн талбай, ногоочдод, Дархан-уул аймгийн	70%

		нутагшуулах, усалгаажуулах, механикжуулах замаар үйлдвэрлэлийг дэмжих			сортоор нэмэгдүүлж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх	Дархан суманд УГТХ-нг түшиглэн туршиж байна. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх төсөл"-ийн хүрээнд төмс, хүнсний ногооны 75 га талбайд дунд оврын бороожуулагчийг суурилуулаад байна.	
79		7. Газар тариалангийн механикжсан ажлыг төлбөртэй гүйцэтгэж өгдөг аж ахуйн нэгж, хоршоонд техник, технологийн шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх, төмс хүнсний ногоо үйлдвэрлэлийн техникийн шинэчлэл хийх	2017 - 2020		Тариалангийн үйлдвэрлэлийн механикжилтийн түвшинг үр тарианы үйлдвэрлэлд 100 хувь, төмсний үйлдвэрлэлд 70 хувь, хүнсний ногооны үйлдвэрлэлд 60 хувьд хүргэх	Хүнсний ногооны 20 сортыг Монгол ногоо төслийн хүрээнд Увс аймгийн Улаангом сумын ногоочид, үр үйлдвэрлэгчдэд, Төв аймгийн Борнуур сум, Дархан-уул аймгийн Орхон, Сэлэнгэ аймгийн Мандал сумын нэвтрүүлэх төвийн талбай, ногоочдод, Дархан-уул аймгийн Дархан суманд УГТХ-нг түшиглэн туршиж байна. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх төсөл"-ийн хүрээнд төмс, хүнсний ногооны 75 га талбайд дунд оврын бороожуулагчийг суурилуулаад байна.	100%
80	2.40.Жимс жимсгэний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, чацарганы үйлдвэрлэлийн нэгдсэн сүлжээ байгуулан, хүн амыг амин дэм бүхий жимс жимсгэнээр ханган, экспортын орлогыг нэмэгдүүлнэ.	1. "Жимс жимсгэнэ" хөтөлбөр хэрэгжүүлж, Монголд ургах боломжтой жимс жимсгэний сортуудыг турших, нутагшуулах, үржүүлэх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх, чацарганы тариалалт, хураалт, хадгалалт, боловсруулалт, борлуулалтын чанар	2017 - 2020		Жимс жимсгэний тариалалтыг 8000 га-д хүргэх	Сүхбаатар, Говь-алтай аймагт суулгац үржүүлгийн төв байгуулах тендер шалгаруулалт зохион байгуулж байна. АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт" төслийн хүрээнд ХААИС-ийн харьяа Борнуур дахь туршилт судалгааны төвд "Жимс жимсгэний сортуудын туршилт судалгаа хийх, жимс жимсгэний генофонд байгуулах" 15.0мянган ам.долларын гэрээг ХААИС-тай байгуулав. Улсын төсвийн 147.4 сая төгрөгийн улсын төсвийн санхүүжилтээр суулгац үржүүлэх дэвшилтэт технологийн мананжуулагч бүхий 120 м2 талбай бүхий 10 иж бүрдэл нийлэг хальсан хүлэмж нийлүүлж ХХААХҮ-ийн Сайдын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А-78 дугаар тушаал гарган суулгац үржүүлэх иргэн аж ахуйн нэгжид 30 хувийн урьдчилгаатай 4 жилийн хүүгүй зээлээр олгож эхлэв. Үүний үр дүнд суулгац үйлдвэрлэл 200.0 мянган ширхэгээр нэмэгдэх боломж бүрдүүлэв. 2020 оны хавар Хөдөө аж ахуйг дэмжих сангаас чацарганы 10.4 мянган ширхэг суулгацыг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр олгож тариалалтыг 10.0 га талбайгаар нэмэгдүүлэв. АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй "Хөдөө аж ахуй,	70%

		стандарт, судалгаа шинжилгээнд суурилсан сүлжээг үүсгэж, өрсөлдөх чадварыг сайжруулан "Монгол чацаргана" бренд бий болгох, экспортод тогтвортой гаргах			хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт" төслийн хүрээнд "Чацаргана жимс жимсгэний талбайн хамгаалалтын ойн зурвас байгуулах стандарт боловсруулах", "Жимс жимсгэний талбайд сортын хянан баталгаа хийх арга зүй техникийн шаардлага" стандарт боловсруулж батлуулах гэрээг 2 байгууллагатай байгуулж ажлыг эхлүүлэв. Европын холбооны санхүүжилтээр хэрэгжиж буй "Монголын худалдааг дэмжих" TRAM төслийн хүрээнд "Чацарганын кластер байгуулах" төсөл хэрэгжүүлж чацарганын кластерт оролцогчдыг бүртгэлжүүлэн хамтын санамж бичиг байгуулан, удирдах зөвлөлийг сонгож хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган ажиллаж байна. 2020 оны 1 дүгээр сард Герман улсад зохиогдсон Green week хүнсний бүтээгдэхүүний олон улсын үзэсгэлэнд тус төслөөс 11.0 мянган еврогийн санхүүжилт зардал гарган стенд түрээсэлж чацаргана боловсруулагч 4 компаний бүтээгдэхүүнийг оролцуулан сурталчлав.	
81	2.41. Газрын үржил шим, үр өгөөж, таримал ургамлын үр үржүүлгийн аж ахуйг цогцолбор байдлаар хөгжүүлж, үрийн сорт чанарыг сайжруулах замаар га-аас авах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ.	1. Таримлын элит үр үржүүлгийн төв, сорт, сорилтын салбаруудыг тариалангийн бүсийн онцлогт тохируулан байгуулж, техник технологийн шинэчлэл хийх	2017 - 2020		Сорт сорилтын салбарыг сэргээх чиглэлээр таримал ургамлын сорт сорих зөвлөх үйлчилгээний тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулж байна. Энэхүү зөвлөх үйлчилгээгээр сорт, сорилтын зориулалттай техникийг ашиглан тариалангийн 4 бүсэд тухайн бүсийн онцлогт тохируулан 3 төрлийн таримлын 20 сортыг сорих ажлыг зохион байгуулан ажиллаа.	100%
82	2.41. Газрын үржил шим, үр өгөөж, таримал ургамлын үр үржүүлгийн аж ахуйг цогцолбор байдлаар хөгжүүлж, үрийн сорт чанарыг сайжруулах замаар га-аас авах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ.	2. Ганд тэсвэртэй, ургац өндөртэй үр тариа, тос, тэжээл, буурцагт таримлын нутагшсан сортын үрийг үржүүлж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх	2017 - 2020	Тас, тэжээлийн таримлын гурван сортыг нэмж үржүүлж нутагшуулах	2020 оны тариалалтад зориулан ганд тэсвэртэй үр тариа, тэжээлийн таримлын үрийн нөөц бүрдүүлэх зорилгоор сэлгээний таримал болох арвай, овъёосны үр тус бүр 200 тонн, рапсын үр 350 тонныг нийлүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж ХААДС-тай гэрээ байгуулан хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгжүүдэд дамжуулан зээлдүүлэх аргаар нийлүүлж сэлгээний таримлын тариалалтыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Урьдчилсан байдлаар 180 тонн тосны ургамлын үр импортоор нийлүүлж гэрээ байгуулан олгож байна. Энэ онд тэжээлийн таримлын үрийн нөөц бүрдүүлэх, тариалах талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор тэжээлийн вандуйн нутагшсан сортын үрийг "Элит үр" ХХК-ийн дэмжлэгтэйгээр жил бүр 20 га-д тариалж үржүүлж байгаагийн зэрэгцээ ОХУ-ын Алтайн хязгаараас тэжээлийн хошуу будааны 160 тонныг Пролог ХХК оруулан ирж үржүүлгийн зориулалтаар 140 га-д тариалаад байна. Тэжээлийн болон бусад үр тарианы үрийг тариалан бүхий аж ахуйн нэгжүүдийн санхүүжилтээр нийлүүлж үржүүлэн жил	100%

						бүр 350-500 тонн тэжээлийн хошуу будаа, вандуйны үрийг дотоодын зах зээлд нийлүүлэх боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна. Улсын төсвийн 5.0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр ганд тэсвэртэй 5000 тн элит үрийн улаанбуудайг ОХУ-аас импортлон үр үржүүлэгчдэд зээлээр олгох ажлыг зохион байгуулан ажиллаа.	
117		4. Гадагш урсах валютын урсгалыг сааруулах өндөр үр ашиг бүхий дэвшилтэт технологи бий болгон нэвтрүүлж, нутагшуулсан үйлдвэрт санхүүгийн дэмжлэг үзүүлэх, Хөнгөн үйлдвэрийн технологийн түвшний үнэлгээ хийх эрх зүйн үндэслэлийг шинэчлэн боловсруулах	2017		Экспортод эцсийн бүтээгдэхүүн ийхээ 30-аас дээш хувийг гаргасан, өндөр үр ашиг бүхий дэвшилтэт технологи бий болгон, нэвтрүүлж, нутагшуулсан үйлдвэрт санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломж бүрдэх	"Үйлдвэрлэлийг дэмжих тухай" хууль 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчингүй болсон тул Үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх чиглэлийн бодлого, хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг үнэлэх, тулгамдаж буй хэрэгцээ шаардлагыг тандан судлах, бодлогын уялдаа холбоог судлах зорилгоор Хөнгөн үйлдвэрийн салбарын хууль эрх зүйн орчинг шинэчлэх арга хэмжээг төлөвлөн 2020 оны төлөвлөгөөнд тусгуулан батлуулсан. Мөн хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагааны холбогдох хэлэлцүүлгүүд болон судалгааны ажилд шаардлагатай зардлыг /49 сая төгрөг/ яамны 2020 оны төсөвт тусгуулан батлуулсан. Хөнгөн үйлдвэрийн салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журмын биелэлтийг гарган, салбарын хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагын үндэслэлийг тодорхойлсон судалгааг газрын мэргэжилтнүүдтэй хамтран гүйцэтгэж удирдлагад танилцуулсан. Шинэ төрлийн Корона (Covid -19) халдвар олон улсад тархаж цар тахлын хэмжээнд хүрсэн онцгой нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоор хэлэлцүүлэг зохион байгуулах ажил хойшлогдоод байна. Үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох журмын төслийг боловсруулж, холбогдох яамдаас санал авч СЯ-нд хүргүүлсэн. Тайлбар: СЯ-наас зохицуулах хууль нь хүчингүй болсон тул батлах боломжгүй гэсэн хариу өгөөд байна.	70%
118	2.51.Ноос, ноолуур, арьс ширэн түүхий эдийн бэлтгэл тээвэрлэлт, үндэсний үйлдвэрт тогтвортой нийлүүлэх тогтолцоог бүрдүүлж, түүхий	1. Түүхий эдийн бэлтгэл, тээвэрлэлтийг боловсронгуй болгож, үндэсний үйлдвэрт тогтвортой нийлүүлэх тогтолцоог бүрдүүлэх	2017 - 2020	Гадаадын төслөөс нийт 227.6 сая төгрөг	Орон нутгаас тээвэрлэх ноосны тээврийн зардлыг 30 хувиар, арьс ширэн түүхий эдийн нядалгааны үеийн механик гэмтлийг 50	Ноос, ноолуур, арьс ширэн түүхий эдийн бэлтгэл, тээвэрлэлтийг боловсронгуй болгох ажлын хүрээнд дараах ажлууд хийгдэв. Үүнд: "НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллагаас (UNIDO) Европын Холбооны санхүүжилтээр хэрэгжүүлж буй Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл"-ийн хүрээнд УБ хотын 9 дүүрэг, 21 аймаг, 330 сумдын салбар хариуцсан мэргэжилтнүүдийг цахим сургалтад хамруулж тэднийг мэдээллээр хангав. Төслөөс 127,2 сая төгрөгийн тоног төхөөрөмж ААН-д олгосон. Арьс ширийг эсгэлтгүйгээр хуулах төхөөрөмжийг олон улсын экспертийн боловсруулсан зураг зааврын дагуу дотооддоо угсарч суурилуулан ашигласнаар арьс ширний гэмтлийг бууруулах боломжтойг практикт харуулж чадсан. ХХААХҮЯ, МАШҮХ-ой хамтран Арьс ширэн түүхий эдийн гологдлыг бууруулах	70%

	эдийн санг бий болгоно.				хүртэл хувиар бууруулж, анхан шатны тордолтыг стандартын дагуу хийн, чанарыг хамгаалах боломж бүрдэх, арьс ширний үнэ цэнэ нэмэгдэж, хаягдал буурах	нарийвчилсан судалгаа/үнэлгээ хийж, зориулалтын хутга, багаж хэрэгсэл нэвтрүүлж практик сургалтуудыг мах, арьс шир боловсруулах нийт 7 үйлдвэр болон малчдын хоршоодод зохион байгуулсан. Судалгаанд хамрагдсан Дархан Минж, Дархан Нэхий, Мон Ирээдүй үйлдвэрүүдэд гэмтэл гологдол 70 орчим хувиар буурсан байна. АХБ-ны “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн Нэмэлт санхүүжилт төсөл”, “Хөдөө аж ахуй нэмүү өртгийн сүлжээг дэмжих” техник туслалцааны төслийн хүрээнд “Түүхий эдэд тордолт хийх, түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгоход шаардагдах технологийн сургалт” хийхээр 100,4 сая төгрөгийн төсөвтэй тендерт МАШҮХолбоо, Нийслэлийн ажил олгогч эздийн холбоо, Технож бизнес инкубатор төв ТББ-иуд нь шалгарч №191025/07-438 дугаартай гэрээг байгуулан Архангай, Баянхонгор, Завхан, Хөвсгөл, Хэнтий, Сүхбаатар, Нийслэлд мал нядалгааны цех, түүхий эд бэлтгэлийн төлөөлөгч, малчдад сургалт явуулж байна.	
119		2. Ноос, ноолуур, арьс ширэн түүхий эдийн сан байгуулж, эргэлтийн хөрөнгийн дэмжлэг үзүүлэх	2017 - 2020	нийт 56.1 тэрбум төгрөг/19 ААН/	Улсын хэмжээнд жилдээ шаардлагатай түүхий эдийг улиралд нь бэлтгэх эргэлтийн хөрөнгийн зээл олгох боломжтой болох	Олон улсад шинэ коронавирус (Covid 19) –ийн халдвар дэгдэж, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хилийн хязгаарлалт тавьсантай холбогдуулан ноолуурын үнийн уналтаас хамгаалах, үндэсний үйлдвэрүүдийг чанартай түүхий эдээр хангах, малчдын орлогыг тогтвортой байлгах, экспортыг дэмжих зорилгоор Засгийн газрын “Ноолуурын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2020 оны 101 дүгээр тогтоолоор Хөгжлийн банкны эх үүсвэрээр 300 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг ноолуур бэлтгэх зориулалтаар үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд нэг жилийн хугацаатай 3 хувийн хүүтэй олгохоор шийдвэрлэсэн. “Ноолуур бэлтгэлийн зээлийн хүүгийн хөнгөлөлтийн зардлыг санхүүжүүлэх тухай” Хөгжлийн банк, СЯ, ХХААХҮЯ хамтарсан гурвалсан гэрээг байгуулсан. Тус тогтоолын хүрээнд Хөгжлийн банк, Төрийн банк, Капитрон банкнаас 2020 оны 06 дугаар сарын 26-ны байдлаар нийт 19 аж ахуйн нэгж 56.1 тэрбум төгрөгийн зээл авсан байна.	70%
120	2.52.Олон улсын худалдааны болон хөрш орнуудын боомтын бүсэд үйлдвэрлэл, худалдаа хөгжүүлэхийг дэмжинэ.	1. Монголд үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг олон улсын худалдааны болон цахим худалдааны сүлжээнд хамруулах боломжийг судалж,	2017 - 2020		Монголын бараа бүтээгдэхүүнийг нийт 4 худалдааны сүлжээнд, 1 цахим сүлжээнд хамруулах	БНХАУ-д ноолуурын зах зээлийн өндөр хандалттай цахим худалдааны талбаруудыг ("China cashmere exchange" /https://cce.dazpin.com/, "Qinghe China cashmere index" /http://qhyrzs.com/data.html/, https://www.made-in-china.com/ г.м) судлан, тус улсад суугаа ЭСЯ болон ӨМӨЗО-ны Хөх хот, Эрээн хотуудад суугаа дипломат төлөөлөгчийн газруудтай хамтран танилцуулга бэлтгэн удирдлагуудад танилцуулав. Энэхүү цахим худалдааны сүлжээнд монголын ноолууран түүхий эд, бүтээгдэхүүнийг шууд борлуулах боломжийг бий болгохоор ӨМӨЗО-	70%

		бараа бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх			ны консулын газартай хамтран ажиллаж байна. 2. Монгол улсын Засгийн газраас БНХАУ-тай хөгжүүлж байгаа онлайн механизмын хүрээнд, “БНХАУ, МУ-ын хилийн боомтын “Ногоон гарц”-ыг хэрэгжүүлэх журам”-ын монголын талын төсөлд "ХАА-н гаралтай бүтээгдэхүүнийг БНХАУ-ын цахим худалдааны сүлжээнд борлуулах" тухай хэсгийг бүтээгдэхүүн тус бүрээр оруулж, ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцүүлэн БНХАУ руу илгээв. 3. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Баяннуур хотын "Бор тохой цахим худалдааны сүлжээ"-нд Монголын чацарганы ундаа болон зарим нэр төрлийн эцсийн бүтээгдэхүүний худалдаалах боломжтой болсон. Энэхүү ажлыг хэрэгжүүлэхэд Баяннуур аймгийн Ардын Засгийн газрын Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран, яамны зүгээс бодлогын дэмжлэг үзүүлэн ажиллав. 4. АНУ-ын ОУ-ын цахим худалдааны сүлжээ болох "www.ebay.com" болон "www.amazon.com"-д МУ-д үйлдвэрлэсэн чацарганын тос, баяжмал болон хонины нэхий, арьс ширэн эдлэл албан ёсоор худалдаалагдаж эхлэв. Энэхүү асуудалд бодлогын дэмжлэг үзүүлэн тус улсад суугаа ЭСЯ-д хандсан албан бичиг зэргийг хүргүүлж ажилласан. ЖДҮ эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг дотоодын болон олон улсын хэмжээнд сурталчлан таниулах, цахим платформ үүсгэх асуудлаар "Рах Mongolica" ХХК-тай ажлын уулзалт зохион байгуулж, цаашид хамтран ажиллахаар санал солилцов.	
121		2. Монголд үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг олон улсын болон хөрш орнуудын зах зээлд гаргах зорилгоор үзэсгэлэн худалдаа, экспо зохион байгуулах	2017 - 2020	Монгол Улс гурав дахь гадны улстай хамтарсан үзэсгэлэн, яармаг зохион байгуулах	ХХААХҮЯ, Экспорт олон улсын худалдааны төв, Дэлхийн банк, Олон Улсын Санхүүжилтийн корпораци хамтран Дэлхийн банкны төв байранд 5 дахь удаагаа Монголын соёлын өдрүүд арга хэмжээний хүрээнд “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэнг 2020.02.11-02.15 өдрүүдэд зохион байгуулж, Нью-Йорк хотод “Mongolian Gallery”-н нээлтийн арга хэмжээг зохион байгуулав. Монгол Улсаа болон байгууллагаа АНУ-д болон олон улсад буюу Дэлхийн банк группын 189 орны 5000 гаруй худалдааны төлөөлөгчдөд Монгол үндэстний өв соёл, үндэсний үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчиллаа. Энэхүү үзэсгэлэнгийн арга хэмжээний үеэр Монголын бизнес эрхлэгчдэд зориулан Дэлхийн банк, ОУ-ын Санхүүгийн Корпорацийн зүгээс Америкийн зах зээлд бараа бүтээгдэхүүний чанар стандартыг хэрхэн хангах, хэрхэн гадаад зах зээлтэй холбогдох, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг хэрхэн сайжруулах талаар сургалт явагдлаа. Үзэсгэлэнд эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, ноос ноолуур, арьс шир, эрүүл мэнд, хүнсний салбарын үйлдвэрлэл эрхлэгч 40 гаруй байгууллагын төлөөлөл оролцож 44,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Халдварт өвчинтэй холбоотойгоор зохион байгуулахаар төлөвлөсөн үзэсгэлэн арга хэмжээ тодорхойгүй хугацаагаар хойшлов	70%

122		3. Монгол брэнд бүтээгдэхүүнийг дэлхий нийтэд сурталчлах, таниулах	2017 - 2020	Монгол брэндийн борлуулалтын орлого суурь оноос 15 дахин өсөх	Дэлхийн банкны “Экспортыг дэмжих” төсөлтэй хамтран экспортлогч болон цаашид гадаадад бараа бүтээгдэхүүнээ экспортлох сонирхолтой аж ахуйн нэгжүүдийг судалгааг гаргав. - АНУ-ын Вашингтон хотноо Дэлхийн банкны үндсэн байранд "Монголд үйлдвэрлэв" үзэсгэлэн худалдааг 2020 оны 02 сарын 11 өдөр зохион байгуулав. Үзэсгэлэн худалдаанд Монголын 40 орчим үйлдвэр эрхлэгч бизнесменүүд арьс шир, ноос ноолууран бүтээгдэхүүн, гоо сайхан, бэлэг дурсгал, үндэсний хувцас эдлэлээ толилуулсан. Уг арга хэмжээг ХХААХҮЯ, Экспорт олон улсын худалдааны төв хамтран зохион байгуулсан. Энэхүү үзэсгэлэнгийн арга хэмжээний үеэр Монголын бизнес эрхлэгчдэд зориулан Дэлхийн банк, ОУ-ын Санхүүгийн Корпорацийн зүгээс Америкийн зах зээлд бараа бүтээгдэхүүний чанар стандартыг хэрхэн хангах, хэрхэн гадаад зах зээлтэй холбогдох, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг хэрхэн сайжруулах талаар сургалт явагдсан. Мөн Монгол Улс хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн, жижиг, дунд үйлдвэрийн салбарт шаардлагатай байгаа хөрөнгө оруулалтын саналаа танилцуулсан. - Монгол Улс, АНУ-ын худалдаа, эдийн засгийн харилцааг харилцан ашигтай байдлын үндсэн дээр өргөжүүлж, хөрөнгө оруулалтын боломжуудыг нэмэгдүүлж, хамтын ажиллагааны шинэ салбар, чиглэлүүдийг нэвтрүүлэх, техник туслалцаа авах, хүний нөөцийг чадавхжуулах, Монгол улсын хувьд 3500 нэр төрөл бүхий худалдааны хөнгөлөлтийг ашиглах, тус улсын дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, хоёр улсын бизнес эрхлэгчдийг харилцан солилцон бизнесийн орчинтой танилцуулах талаар хамтран ажиллах, Bay Atlantic University орж танилцан, салбарын хүний нөөцийг чадваржуулахад хамтран ажиллахаар тохиролцсон. Монгол брэнд бүтээгдэхүүнийг дэлхий нийтэд сурталчлах, таниулах зорилгоор Монгол брэндийн худалдааны төвийг Экспорт Олон улсын худалдааны төвтэй хамтран нээсэн. Нэхмэл сүлжмэл бүтээгдэхүүн, арьсан бүтээгдэхүүн, гоо сайхны бүтээгдэхүүн эхний ээлжинд экспортод гарч эхлээд байна.	100%
123	2.53.Хөнгөн, жижиг, дунд үйлдвэрийн салбарын боловсон хүчнийг бэлтгэх, сургах, давтан сургах тогтолцоог хөгжүүлж	1. Хөнгөн болон хүнсний үйлдвэрийн хүний нөөцийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтны хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг бусад	2017 - 2020	Хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх	ХХААХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргын А-430 дугаар тушаалаар байгуулагдсан “Мэргэжилтэй ажилтан үндэсний хөтөлбөр”-ийн төслийг боловсруулах ажлын хэсгийн Ажлын төлөвлөгөөний дагуу суурь судалгаа хийгдэж, хөтөлбөрийн төслийг боловсруулсан. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагуу яамны холбогдох газар, хэлтсүүдээс хөтөлбөрийн төсөлд тусгах саналыг авч нэгтгэсэн. Олон улсад шинэ коронавирус (Covid 19)–ийн халдвар дэгдэж, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хөл хорио тогтоосонтой холбоотойгоор “Мэргэжилтэй ажилтан үндэсний	40%

	“Мэргэжилтэй ажилтан” хөтөлбөр хэрэгжүүлнэ.	яамдтай уялдуулан хэрэгжүүлэх			хөтөлбөр”-ийн төслийг боловсруулах ажлын хэсгийг хуралдуулах боломжгүй байгаа тул ажлын хэсгийн гишүүдээс төсөлд санал авахаар цахимаар хүргүүлсэн. - Бүгд Найрамдах Турк улсын Засгийн газрын тэтгэлгээр арьс ширний үйлдвэрлэлийн салбарт шаардлагатай байгаа мэргэжлээр оюутан суралцуулахаар зарлаж, 23 хүн бүртгүүлээд байна. - Москва хотын А.Н.Косыгины нэрэмжит Хөнгөн үйлдвэрийн технологи, дизайн, урлагийн улсын их сургуулийн удирдлагуудтай уулзаж, арьс ширэн бүтээгдэхүүний загвар зохион бүтээлтийг сайжруулах, худалдаа бизнесийн хамтын ажиллагааг хөгжүүлэх болон мэргэжлийн загвар зохион бүтээгч багш мэргэжилтнүүдийг Монгол Улсад ажиллуулах талаар санал тавьсан байна.	
124		2. “Мэргэжилтэй ажилтан” хөтөлбөрийг боловсруулан батлуулах	2017 - 2020	Хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх	ХХААХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргын А-430 дугаар тушаалаар байгуулагдсан “Мэргэжилтэй ажилтан үндэсний хөтөлбөр”-ийн төслийг боловсруулах ажлын хэсгийн Ажлын төлөвлөгөөний дагуу суурь судалгаа хийгдэж, хөтөлбөрийн төслийг боловсруулж, санал авсан. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагуу яамны холбогдох газар, хэлтсүүдээс хөтөлбөрийн төсөлд тусгах саналыг авч нэгтгэсэн. Олон улсад шинэ коронавирус (Covid 19)–ийн халдвар дэгдэж, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хөл хорио тогтоосонтой холбоотойгоор “Мэргэжилтэй ажилтан үндэсний хөтөлбөр”-ийн төслийг боловсруулах ажлын хэсгийг хуралдуулах боломжгүй байгаа тул ажлын хэсгийн гишүүдээс төсөлд санал авахаар цахимаар хүргүүлсэн.	40%
125		3. Жижиг, дунд үйлдвэрийн салбарын ажиллах хүчнийг бэлтгэх, сургах, давтан сургах арга хэмжээг МСҮТ-үүдийг түшиглэн зохион байгуулах	2017 - 2020	Хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжих	Ковид-19-тэй холбоотойгоор жижиг, дунд үйлдвэрийн салбарын мэргэжилтнүүдийг чадваржуулах цахим сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулсан. Сургалтад аймаг, нийслэлийн дүүргийн 60 гаруй мэргэжилтэн оролцов. Цахим сургалтаар төрөөс жижиг, дунд үйлдвэрийн салбарт баримталж буй, бодлого, чиглэл цаашид хийх ажлын төлөвлөгөө болон бусад мэдээллийг танилцуулав.	70%
126	2.54.Хөнгөн үйлдвэрийн салбаруудыг хөгжүүлэх зорилгоор зөвлөгөө, мэдээлэл,	1. Хөнгөн үйлдвэрийн салбарт тэргүүний дэвшилтэт технологи дамжуулах, нэвтрүүлэх	2017 - 2018	Технологи дамжуулалт, зөвлөгөө мэдээллээр үйлчилсэн 1 гэрээт ажил хийгдэж,	Хөнгөн үйлдвэрийн салбаруудыг хөгжүүлэх зорилгоор зөвлөгөө, мэдээлэл, сургалт явуулах мэдээллийн болон инкубатор төвийг тухайн салбарын мэргэжлийн холбоодыг түшиглэн байгуулахыг дэмжих ажлын хүрээнд дараах ажлууд хийгдэв. Үүнд: 1. Зөвлөгөө, мэдээлэл, сургалт явуулах ажлын хүрээнд Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо, Нийслэлийн ажил олгогч эздийн холбоо, Технож бизнес инкубатор төв ТББ-иуд нь Азийн хөгжлийн банкны	100%

	сургалт явуулах мэдээллийн болон инкубатор төвийг тухайн салбарын мэргэжлийн холбоодыг түшиглэн байгуулахыг дэмжинэ.	чиглэлээр ажиллаж байгаа хувийн хэвшлийн байгууллагаар төрийн зарим үүргийг гүйцэтгүүлэх, санхүү болон эрх зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллах, АХБ, ЕСБХБ-ны төслийн хүрээнд хамтран ажиллах		технологи нутагшуулах нөхцөл бүрдэх	“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт төсөл”, “Хөдөө аж ахуй нэмүү өртгийн сүлжээг дэмжих” техник туслалцааны төслийн хүрээнд “Түүхий эдэд тордолт хийх, түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгоход шаардагдах технологийн сургалт” хийхээр 100,407,500 төгрөгийн төсөвтэй тендерт шалгарч №191025/07-438 дугаартай гэрээг байгуулан Архангай, Баянхонгор, Завхан, Хөвсгөл, Хэнтий, Сүхбаатар, Нийслэлд мал нядалгааны цех, түүхий эд бэлтгэлийн төлөөлөгч, малчдад сургалт явуулж байна. 2. Инкубатор төв байгуулах ажлын хүрээнд “НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллагаас (UNIDO) Европын Холбооны санхүүжилтээр хэрэгжүүлж буй Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн хүрээнд Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт үйлдвэрлэл бизнесийн АРМОНО корпораци дээр “Аж үйлдвэрлэлийн ирээдүй” E-learning сургалтын төв, Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн дээр Текстилийн Гүйцэтгэн боловсруулалтын Инкубатор төвүүдийг байгуулав. Эх сурвалж: https://facebook.com/mnbnmongoliinmedee/videos/266031551183620/ https://www.facebook.com/1013014818816562/photos/pcb.2868030046648354/2868028636648495/?type=3theater https://www.montsame.mn/mn/read/227440?fbclid=IwAR3MMLwGI6_9Zg7wAV99wi9Pq35-LT4Xu7311hLPf1mcndnGYyUDY6LGLkM	
127		2. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд үзүүлэх бизнес инкубацийн үйлчилгээг боловсронгуй болгох, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжин хөгжүүлэх	2017 - 2020	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд үзүүлэх бизнес инкубацийн үйлчилгээ шинэ түвшинд хүрч, шинээр гарааны бизнес эрхлэгчид болон инкубациас үйлчилгээ авсан иргэн, ААН-ийн тоо нэмэгдэх	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны хөгжлийн бодлого зохицуулалтын газар Хөгжлийн шийдэл ТББ-ын хэрэгжүүлж буй БЭСТ хөтөлбөртэй хамтран “Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх нь” сэдэвт сургалтыг Нийслэлийн 9 дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн албан хаагч, сургагч багш нарыг чадавхжуулах зорилгоор 2020 оны 06 сарын 19-ны өдөр зохион байгуулав. Арга хэмжээний зорилго нь жижиг, дунд бизнес эрхлэгч нарт зөвлөгөө, мэдээлэл өгч нийслэлийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвүүдийн мэргэжилтэн, албан хаагчдыг чадваржуулах, хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөтөлбөрийн харилцагчдын тоог нэмэгдүүлэх юм. Нийслэлийн бүх дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн 20 орчим сургагч багш, албан хаагч хамрагдав.	70%

128	2.55.Гадаад орны өндөр болон дэвшилтэт технологи бүхий үйлдвэрийг франчайзаар оруулж нутагшуулан, хөнгөн, жижиг дунд үйлдвэрийн салбарт “Хөгжлийн загвар” үйлдвэр байгуулахыг дэмжинэ.	1. Экспортын бүтээгдэхүүний өсөлтийг нэмэгдүүлэх “Хөгжлийн загвар” үйлдвэр байгуулахыг дэмжих	2017 - 2020		Тэргүүний технологи нутагших, загвар үйлдвэр байгуулагдах бизнесийн эрх зүйн таатай орчин бүрдэх	Экспортын бүтээгдэхүүний өсөлтийг нэмэгдүүлэх “Хөгжлийн загвар” үйлдвэр байгуулахыг чиглэлд дараах үйлдвэрүүдэд бодлогын дэмжлэг үзүүлэн ажилласан. Үүнд: - Хөгжлийн банзны зээлийн санхүүжилтээр “Монпеллетс” ХХК нь хонины ноосоор био бордоо үйлдвэрлэх дэлхийн хоёр дахь үйлдвэрийг ашиглалтад оруулж, жилд 2000 орчим тонн ноосыг чанарын ялгалт хийхгүйгээр малчдаас худалдан авч, үрлэн бордоо үйлдвэрлэн, Герман улсад нийлүүлж байна. - “Промон трейд” ХХК нь Европ стандартыг бүрэн хангасан “Протэйн монголиа” үйлдвэрийг ашиглалтад оруулж, хоногт 100 тн малын гаралтай хаягдал түүхий эд яс, сэг зэмийг Итали технологиор боловсруулж өндөр чанартай тахиа, гахай, загасны тэжээлийн нэмэлт уураг буюу премикс болон малын гаралтай тос зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. - Налайхын барилгын материалын ҮТП-д “Пийс стийл групп” ХХК нь жилд 19200 тн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр байгуулан, хаягдал ширэм болон ган дахин боловсруулах усан онгоцны жин тэнцвэржүүлэгч үйлдвэрлэн Хятадын зах зээлд экспортолж байна. - Ноос ноолуур угаах, самнах чиглэлээр 20 гаруй жил үйл ажиллагаа явуулж, анхан шатны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүний 70 хувийг Европын зах зээлд экспортолдог “Ханбогд кашимер” ХХК үйл ажиллагаагаа өргөжүүлэн, сүлжмэлийн үйлдвэрээ ашиглалтад оруулж, бүтээгдэхүүнээ Европ, Америкийн зах зээлд экспортлохоор брэнд хөгжүүлэлт дээр Италийн зөвлөх компанитай, загвар зохион бүтээлтэд Германы дизайнеруудтай хамтран ажиллаж шинэлэг загварын ноолууран хувцсыг үйлдвэрлэж эхлээд байна. - “Таван богд” групп “Галлериа Улаанбаатар” төв нэртэйгээр 10152 м2 талбай бүхий 3 давхар цогцолборыг байгуулж, Монгол ноолуураар дэлхийг гоёх “Говь”, “Гоёо” брэндийн нийлсэн 2500 м2 талбай бүхий дэлхийн хамгийн том ноолуурын дэлгүүрийг нээсэн. Эх орны брэнд “Эвсэг” үйлдвэр нь нэрийн дэлгүүрээ өргөтгөж, 1720 м2 талбайтай, төрөлжсөн 5 тасагтай дэлхийн хамгийн том дэлгүүр болсон. Бүтээгдэхүүний 80 хувь нь Итали, Швейцар, Герман, Англи, ОХУ, Япон, Казахстанд экспортод гаргаж байна.	70%
129	2.56.Хөнгөн үйлдвэрийн чиглэлээр дэлхийн тэргүүлэх, дэвшилтэт техник, технологийн	1. Үйлдвэрлэл өндөр хөгжсөн улсын үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах, нэвтрүүлэх, үзэсгэлэн яармагт	2017 - 2020		Парисын яармаг, Германы ногоон долоо хоног болон БНХАУ, Япон, Тайвань,	ХБНГУ-д 2020 оны 01 сарын 17-ноос 26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Германы Ногоон долоо хоног" ХАА-н ОУ-ын үзэсгэлэн, худалдааны арга хэмжээнд "Монгол Улсыг сурталчлах танхим"-ыг нээж, ноос ноолуур, арьс шир, чацаргана, зөгийн бал болон бусад хүнсний бүтээгдэхүүн, газар тариалангийн био бордоо үйлдвэрлэлийн нийт 16 ААН-ийг хөнгөлөттэй нөхцлөөр оролцуулах ажлыг зохион байгуулав. Энэхүү арга хэмжээнд оролцсон ААН-үүд нийт 42 000 ам.долларын борлуулалт хийж, 85 улс, орны 180 000 орчим худалдан	70%

	үзэсгэлэнг Монгол Улсад тогтмол зохион байгуулж, гадаад оронд зохион байгуулагдаж байгаа үйлдвэрийн тоног төхөөрөмж, бараа, бүтээгдэхүүний үзэсгэлэнд үйлдвэрлэгчдийг дэмжиж хамруулна.	оролцоход дэмжлэг үзүүлэх			Солонгос, Италид зохиогдож буй үзэсгэлэн яармагт үйлдвэрлэгчдийг хамруулан оролцуулах, туршлага судлуулах, худалдаа, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр хийхэд туслалцаа үзүүлэх	авагч, бизнес эрхлэгчдэд бараа бүтээгдэхүүнээ танилцуулав. 2. Монголын үндэсний брэнд бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчдээ дэмжих, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, эх орноо султалчлах зорилгоор АНУ-д 5 дахь жилдээ зохион байгуулсан "Монголд Үйлдвэрлэв" цогц арга хэмжээг 2020 оны 02 дугаар сарын 10-14-ны өдрүүдэд зохион байгуулж, ХХААХҮЯ болон ЖДҮСан хамтран дэмжлэг үзүүлэн ажиллав. 3. Япон Улсын Токио хотноо зохион байгуулахаар төлөвлөж байсан ОУ-ын хувцас үйлдвэрлэлийн "Токио фэшен уорлд - 2020" /Tokyo Fashion world/ арга хэмжээнд "Хаан ширхэгт" гэрчлэх тэмдэг бүхий ноолууран бүтээгдэхүүнийг таниулан сурталчлах зорилгоор АХБ-тай хамтран үзэсгэлэнгийн танхимийг нээн ажиллуулах бэлтгэл ажлыг бүрэн хангав. Арга хэмжээнд МУ-ын ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нийт 16 ААН-ийг хөнгөлөттэй нөхцлөөр оролцуулж, салбарын хөрөнгө оруулалтын форумын арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж байсан. Энэхүү арга хэмжээ 2020 оны 09 дүгээр хүртэл хойшилсон тул үргэлжлүүлэн зохион байгуулагч талтай харилцан ажиллаж байна. 4. БНЭУ-ын "АМУЛ" сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хоршоололтой хамтран ажиллах, кластерийн үйлдвэрлэлийг хөгжүүлсэн туршлагатай танилцах ажлын хүрээнд, МУ-ын сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, хоршоологчдын төлөөлөл бүхий 30 хүний бүрэлдэхүүнтэй туршлага судлах албан томилолтыг, АХБ-ны санхүүжилтээр 2020 оны 3 дугаар сард зохион байгуулах бэлтгэл ажлыг бүрэн хангав. Энэхүү томилолт тодорхойгүй хугацаагаар хойшлоод байна	
130		2. "Монголд үйлдвэрлэв" үзэсгэлэн, худалдааг тогтмолжуулж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх	2017 - 2020		Үзэсгэлэнд оролцсон бараа бүтээгдэхүүний борлуулалтын дүн өмнөх оноос 25 хувиар өсөх	ХХААХҮЯ, Экспорт олон улсын худалдааны төв, Дэлхийн банк, Олон Улсын Санхүүжилтийн корпораци хамтран Дэлхийн банкны төв байранд 5 дахь удаагаа Монголын соёлын өдрүүд арга хэмжээний хүрээнд "Монголд үйлдвэрлэв" үзэсгэлэнг 2020.02.11-02.15 өдрүүдэд зохион байгуулж, Нью-Йорк хотод "Mongolian Gallery"-н нээлтийн арга хэмжээг зохион байгуулав. Монгол Улсаа болон байгууллагаа АНУ-д болон олон улсад буюу Дэлхийн банк группын 189 орны 5000 гаруй худалдааны төлөөлөгчдөд Монгол үндэстний өв соёл, үндэсний үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчиллаа. Энэхүү үзэсгэлэнгийн арга хэмжээний үеэр Монголын бизнес эрхлэгчдэд зориулан Дэлхийн банк, ОУ-ын Санхүүгийн Корпорацийн зүгээс Америкийн зах зээлд бараа бүтээгдэхүүний чанар стандартыг хэрхэн хангах, хэрхэн гадаад зах зээлтэй холбогдох, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг хэрхэн сайжруулах талаар сургалт явагдлаа. Үзэсгэлэнд эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, ноос ноолуур,	70%

					арьс шир, эрүүл мэнд, хүнсний салбарын үйлдвэрлэл эрхлэгч 40 гаруй байгууллагын төлөөлөл оролцож 44,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Халдварт өвчинтэй холбоотой зохион байгуулахаар төлөвлөсөн үзэсгэлэн арга хэмжээ тодорхойгүй хугацаагаар хойшлов.	
131		3. Үндэсний уламжлалт болон орон нутгийн онцлог бүхий хоол, үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор дэмжих, таниулах, сурталчлах	2017 - 2020	Дотоодын болон олон улсын түвшний үзэсгэлэн, уралдаанд 1-2 удаа оролцох	Үндэсний уламжлалт болон орон нутгийн онцлог бүхий хоол, үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор дэмжих, таниулах, сурталчлах ажлыг сүүлийн хагас жилд зохион байгуулахаар төлөвлөсөн.	0%
132	2.57.Хөнгөн үйлдвэрийн парк байгуулж, салбарын үйлдвэрүүдийн хамтын ажиллагааг дэмжин, кластерыг бүртгэлжүүлэн бодлогоор дэмжинэ.	1. Арьс, ширний үйлдвэрийн парк байгуулж, үйлдвэрүүдийг кластераар хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, загвар үйлдвэр байгуулахыг дэмжих	2017 - 2020	Шинжлэх ухаан технологи, инновацийн төв, паркийн төмөр зам, логистик төв, агуулахуудын хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлж, бүтээн байгуулалт хийгдэх	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 356 дугаар тогтоолоор батлагдсан Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас авах зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн жагсаалтад “Дархан арьс ширний цогцолбор”-ын дэд бүтцийн төсөлд 56.3 сая ам.долларыг зээлээр санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Зээлийн гэрээ байгуулах тухай 2020 оны 01/1332 дугаар албан бичгийг Сангийн яаманд хүргүүлэв. 2. ХХААХҮЯ-ны Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөрийн 4.6-д тусгагдсан “Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалтын зээлийн хүүгийн татаас” 15 тэрбум төгрөгийг олгох ажлын хүрээнд: - “Дархан үйлдвэр технологийн парк”-ийн нэгж “Дархан арьс ширний цогцолбор” ХХК-тай зээлийн хүүгийн татаасыг санхүүжүүлж гэрээ байгуулж, хэрэгжүүлэх замаар тус цогцолборын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авах”-ыг даалгасан Засгийн газрын тогтоол батлагдав МУЗГ-ын 2020 оны 178 дугаар тогтоол). - Уг төслийг хэрэгжүүлэгчтэй “Гэрээ байгуулах эрх олгох тухай” ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-185 тоот тушаал батлагдав. - Төсөл хэрэгжүүлэгчтэй 200515/07/165 тоот бодлогын гэрээ байгуулав - Цахилгаан түгээх, дамжуулах дэд станцын барилга, дулааны шугам хоолой татах, ноос угаах, самнах үйлдвэр, арьс шир боловсруулах үйлдвэр, цэвэрлэх байгууламжийн барилгын ажлууд хийгдэж байна. 2020 онд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн эхний 3 блокны ноос боловсруулах үйлдвэрийн барилгын ажил 86%, дэд станцын угсралт 90%, барилга байгууламж нь 50%, бохир ус цэвэрлэх байгууламжийн ажлын цутгалт 30% хувьтай байна. Богийн арьс шир боловсруулах үйлдвэрийн газар шорооны ажил эхлээд байна. http://mofa.gov.mn/exp/article/entry/2086	70%

133		2. Арьс, ширний үйлдвэрийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалт бий болгох болон хаягдал усыг цэвэршүүлэх, ариутгах, дахин ашиглах орчин үеийн дэвшилтэт технологитой цэвэрлэх байгууламжийг байгуулах ажлыг зохион байгуулах	2017 - 2018		Уг ажлын хүрээнд: 1. Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн технологийн бохир усыг дахин ашиглах стандарт МУ-д байхгүй тул Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан "Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн цэвэршүүлсэн технологийн бохир усыг үйлдвэрт дахин ашиглах стандартыг боловсруулж батлуулахыг Стандарт, хэмжилзүйн газарт даалгасан" МУЗГ-ын 2020 оны 178 дугаар тогтоол батлуулсан (Appendix 1). 2. Дархан арьс ширний цогцолборын Бохир ус цэвэрлэх байгууламжийн ТЭЗҮ бичиг баримтыг цэвэрлэх байгууламжийн технологиор дэлхийд тэргүүлэгч олон жилийн туршлага бүхий Итали улсын Deltacque компани хийж гүйцэтгэсэн. Олон улсын стандартын шаардлага хангасан цэвэрлэх байгууламжтай болж Deltacque-ийн боловсруулсан олон улсад зөвшөөрөгдсөн технологи нэвтрүүлснээр арьс шир үйлдвэрлэгчдэд олгодог олон улсын хамгийн том сертификат болох Leather Working Group-ийн сертификатыг авах боломжтой болов. Бохир ус цэвэрлэх байгууламжийн ажлын явцыг хавсралт зургаар харуулав (Appendix 2). 3. Арьс ширний үйлдвэрийн хашаанд үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрүүдийн хаягдал усыг цэвэршүүлэх, ариутгах, дахин ашиглах орчин үеийн дэвшилтэт технологитой болгох ажлын хүрээнд Арьс ширний салбарын эксперт Висванатан Мунусамиги Монгол Улсад ажиллаж Улаанбаатар ба Дархан хотуудад урьдчилсан цэвэрлэх байгууламж, арьс шир боловсруулах үйлдвэрүүдэд үнэлгээ хийж, зөвлөмж өгсөн (Appendix 3). Зөвлөмжийн дагуу зарим арьс шир боловсруулах үйлдвэрүүд Leather Working Group-ийн сертификатыг авах нөхцөлүүдийг ханган сертификат авахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	70%
134	2.58.Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах бараа, түүхий эдийн нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, үйл ажиллагааг боловсронгуй болгоно.	1. Хөдөө аж ахуй болон үйлдвэрлэл, үйлчилгээний хоршоодын бэлтгэсэн малын гаралтай түүхий эдийг хөдөө аж ахуйн биржээр арилжих ажлыг эрчимжүүлэх	2017 - 2020	10 хоршоог биржийн арилжаанд оролцуулах	Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.58 дахь заалтын хэрэгжилтийн хүрээнд Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах бараа, түүхий эдийн нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-409 дүгээр тушаал батлагдан биржээр арилжаалах бараа, түүхий эдийн жагсаалтад мах, арьс ширийг нэмж оруулснаар экспортод гаргах махыг Биржээр арилжих нөхцөл бүрдсэн.	40%
135		2. Хөдөө аж ахуйн биржийн системийг онлайн горимд шилжүүлэн	2017 - 2020	Олон улсын шаардлагад нийцсэн технологийн	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголын хөдөө аж ахуй хоршоологчдын үндэсний холбоо болон "Хөдөө аж ахуйн бирж" ТӨХХК түүхий эд бэлтгэлийн "Загвар хоршоо" төсөл дээр хамтран ажиллаж биржийн байнгын бус гишүүн хоршоод болон бусад түүхий	70%

		хөгжүүлж, олон улсын шаардлагад нийцсэн технологийн шинэчлэл хийх			шинэчлэл хийх	эд бэлтгэн нийлүүлэгч загвар хоршоог байгуулж, биржээр түүхий эд арилжих схемьг боловсруулж танилцуулсан. Хөдөө аж ахуй бирж" ТӨХХК нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Монголын хөдөө аж ахуй хоршоологчдын үндэсний холбоо хамтарч "Лавай" худалдааны төвд "Цагаан сар-2020" үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. Үүнд биржийн итгэмжлэгдсэн хоршоод хамрагдан гарал үүсэл нь баталгаажсан, эрүүл ахуйн шаардлага хангасан бараа түүхий эдийг нийслэлийн иргэдэд дундын дамжлагагүйгээр худалдаалсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын өгсөн үүрэг, даалгаврын хүрээнд 3 аж ахуй нэгжийг банктай холбон, санхүүгийн эх үүсвэрийг шийдүүлэн нөөцийн мах бэлтгэлийн үйл ажиллагаанд татан оролцуулсан.	
136	2.92.Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн ус болон хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлнэ.	2. Хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах чиглэлээр судалгаа хийх	2017 - 2018			Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн ус болон хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд дараах ажлууд хийгдсэн. Үүнд: 1. Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн технологийн бохир усыг дахин ашиглах стандарт байхгүй тул Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан "Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн цэвэршүүлсэн технологийн бохир усыг үйлдвэрт дахин ашиглах стандартыг боловсруулж батлуулахыг Стандарт, хэмжилзүйн газарт даалгасан" МУЗГ-ын 2020 оны 178 дугаар тогтоол батлуулсан. 2. Нийслэлийн засаг даргын 2020 оны 5 дугаар сарын 15-ны А/661 дугаар захирамжаар байгуулагдсан Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжид нийлүүлэх бохир усны стандартын шаардлагыг хангуулах, цэвэрлэх байгууламжуудын хог хаягдал, лагийг зориулалтын бус газарт хаях, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөө үзүүлэх, үнэр гаргаж байгааг таслан зогсоох, энэ чиглэлээр байгууллагад анхааруулга, зөвлөгөө өгч ажиллах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах талаар зохион байгуулалтын болон цаашид авах арга хэмжээний санал боловсруулах ажлын хэсэгт ажиллаж дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд: - Арьс ширний урьдчилан цэвэрлэх байгууламж дээр ажлын хэсэг хуралдаж тус байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтын асуудлуудыг судлаж шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх талаар ажиллав (2020.06.03). - Хан-Уул дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй арьс шир боловсруулах, ноос, ноолуур угаах, өлөн боловсруулах, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, архи, спирт, пивоны үйлдвэрүүд, машин угаалгын	40%

					газруудын цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг шалгаж ажиллав (2020.06.12).	
ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГО						
137	3.1.7.Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулж хэрэгжүүлэн эх, нялхсын эндэгдлийг бууруулна.	2. Нялх, балчир хүүхдийн хоол, ундны бүтээгдэхүүний тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх	2017 - 2018		Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллан 2017 оны 5-р сард УИХ-аар хэлэлцүүлэн батлуулсан.	100%
138	3.2.36.Салбарын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх өндөр технологийн судалгаа ба хөгжил, инновацийн болон зөвлөх, нэвтрүүлэх үйлчилгээний үйл ажиллагааны суурь бүтцийг хөгжүүлэх, эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ.	3. Судалгаа, хөгжлийн инкубатор төв, загвар аж ахуй, агро парк байгуулахад бодлогоор дэмжлэг үзүүлэх	2017 - 2020	10-15 загвар аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэх	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Европын Холбооны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Монгол Улсад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих (SECiMC2)” төслийн хүрээнд хөнгөн аж үйлдвэрийн салбарт хүний нөөцийг чадавхжуулах, олон улсын туршлага нэвтрүүлэх “Аж үйлдвэрлэлийн ирээдүй (Industry of the Future)” цахим-танхим хосолсон сургалтын төвийг 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Армоно корпорацийн байранд тус байгууллагын 50 жилийн ойг тохиолдуулан, мөн “Сүлжмэлийн гүйцэтгэн боловсруулалтын инкубатор” сургалтын төвийг Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн (ХҮСХХ)-д тус тус нээж төслийн хүрээнд боловсруулсан 11 багц сургалтын материалыг хамтрагч байгууллагуудад хүлээлгэн өгч албажуулсан. Тус төвүүдийн нээлтийн ажиллагаанд ХХААХҮ-ийн сайд Ч.Улаан, Европын Холбооноос Монгол Улсад суугаа элчин сайд Траяан Христea болон хөнгөн аж үйлдвэрлэлийн салбарын мэргэжлийн холбоод, судалгаа шинжилгээний байгууллагууд, сургуулиуд, үйлдвэрлэгчдийн төлөөллүүд оролцлоо. “Аж үйлдвэрлэлийн ирээдүй” сургалтын төвд хөнгөн аж үйлдвэрийн салбарын мэргэжилтнүүд цахим-танхим хосолсон олон улсын сургалтуудад хамрагдах, хэлэлцүүлэг өрнүүлэх, Армоно корпорацийн судалгаа, сорил, туршилтийн төвд дадлага хийх боломжтой болно.	70%
139		4. Зөвлөх нэвтрүүлэх үйлчилгээний	2017 - 2020		Хөдөө аж ахуйн нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээний тухай хуулийн төслийн Үзэл баримтлалын төслийг эцэслэн боловсруулж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар батлуулсан. Батлагдсан 4	Үнэлэх боломжгүй

		хуулийн төслийг боловсруулж, батлуулах				хувь үзэл баримтлалыг Хууль зүй дотоод хэргийн сайдаар батлуулахаар 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01/08 тоот албан бичгээр хүргүүлсэн. Хууль зүй дотоод хэргийн сайдаас 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 1-1/473 тоот албан бичгээр дараах саналыг ирүүлсэн болно. Үүнд: "Хөдөө аж ахуйн, нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан харилцааг холбогдох хуулиар зохицуулж байгаа тул давхардуулан хуулийн төсөл боловсруулах шаардлагагүй гэж үзэж байна." гэжээ. Хууль зүй дотоод хэргийн сайд дээрх хариуг ирүүлж, үзэл баримтлалын төслийг батлаагүй учир энэ хуулийн төсөл, үзэл баримтлалын төслийг цааш боловсруулах боломжгүй болсон байна.	
140	3.2.37.Нээлттэй лабораторид суурилсан био, нанотехнологийг хөгжүүлж, оюуны багтаамж өндөртэй,	3. Инновацийн зуучлал, мэдээлэл, маркетингийн тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр үндэсний болон олон улсын чуулган, зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, тодорхой шийдэл, үр дүнд хүрэх	2017 - 2020		Салбарын судалгаа ба хөгжлийн чиглэлээр олон улсын чуулган 1, салбарын хэмжээний зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг 2-оос доошгүй удаа зохион байгуулах	Дэлхий нийтийг хамарсан цар тахал Covid-19 тархаж, Монгол Улс өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан олноор цуглах хурал, цуглаан зохион байгуулахыг хориглосон. Үүнтэй холбоотойгоор "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын шинжлэх ухаан, технологи, инноваци"-2020 Үндэсний чуулганыг 2020 оны 11 дүгээр сард зохион байгуулахаар 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан болно.	40%
141	экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлнэ.	4. Био, нано технологийг хөгжүүлж оюуны багтаамж, экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн инновацийн төслүүдийг хэрэгжүүлж, гарааны компани	2017 - 2020		5 инновацийн төсөл, 2-3 гарааны компани байгуулахад дэмжлэг үзүүлэх	Шинжлэх ухаан, технологийн Үндэсний зөвлөлөөс гарсан шийдвэрийн дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт 2020 оноос хэрэгжүүлэх Шинжлэх ухаан, технологийн 11 төсөл хэрэгжүүлэхээр БСШУС-ын сайдын 2020 оны А/123 дугаар тушаал батлагдсан. Энэхүү 11 төслийг хэрэгжүүлэх гурван талт гэрээ байгуулах ажлыг БСШУСЯ, ШУТС-тай хамтран зохион байгуулж байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт 2021 оноос хэрэгжүүлэх Шинжлэх ухаан, технологийн төслийн хүрээнд шийдвэрлүүлэх шаардлагатай асуудлуудыг Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн 2020 оны 03 дугаар 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэж, саналыг шийдвэрийн хамтаар 2020 оны 01/940 тоот албан бичгээр БСШУСЯ-д хүргүүлэв. Мөн түүнчлэн салбарт нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой инновацийн төслийн саналуудыг 2020 оны 03/1069 тоот	70%

		байгуулахад дэмжлэг үзүүлэх			албан бичгээр БСШУСЯ-д хүргүүлсэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх ач холбогдол бүхий, инновацийн чиг баримжаатай судалгаа хөгжлийн ажлыг дэмжих зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын нэрэмжит грант олгох шалгаруулалтыг зохион байгуулж байна. Грантад ирүүлэх бүтээлүүдийг сайдын 2017 оны А-36 дугаар тушаалаар баталсан "Салбарын судалгаа, хөгжлийн ажилд грант олгох журам"-ын дагуу 2020 оны 04 дүгээр сард хүлээн авсан. Дээрх бүтээлүүдийг ХХААХҮЯ-ны Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны захиалгаар Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилтээр тус салбарт 2017-2019 онд хэрэгжүүлж дууссан 12 төслийн үр дүнд өгсөн шинжээчдийн дүгнэлтийг үндэслэн, тус төслүүдийн үр дүнг хүлээн авах асуудлыг хэлэлцэж, нийт 10 төслийн үр дүнг хүлээн авах, 2 төслийн үр дүнг хүлээн авах боломжгүй гэж шийдвэрлэсэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын нэрэмжит "Грант"-д дэвшсэн 8 бүтээлийг хэлэлцэн, 5 бүтээлд грант олгохоор шийдвэрлэж, сайдад танилцууллаа.		
Дөрөв. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
142	4.1.4.Ой, түүний дагалт баялаг, байгалийн бусад нөөц баялгийн ашиглалтын нөөцийг бий болгож, зохистой ашиглах, эко цэвэр түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	1. Ойг доройтлоос хамгаалж, ойн төлөв байдлыг сайжруулах, ойн замын сүлжээг өргөжүүлж, ойн нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах	2017 - 2020		Модон түүхий эдийн ашиглалтын түвшинг 80 хувьд хүргэж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх	Ойг доройтлоос хамгаалж, ойн төлөв байдлыг сайжруулах, ойн замын сүлжээг өргөжүүлж, ойн нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлын хүрээнд "Ойн төв замыг ойн сангийн нөөцийн ашиглалтаар шийдвэрлэх загвар төсөл боловсруулах" болон "Мод модон түүхий эдийн бэлтгэлийн тогтолцооны цогц судалгаа"-ны ажлыг төлөвлөн, санхүүжилтийг 2020 оны төсөвт батлуулсан. Ажлуудын даалгаврыг боловсруулан газрын даргаар хянуулан баталгаажуулж, ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн А-67 дугаар тушаалаар байгуулагдсан судалгааны ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороонд 2020 оны 3 дугаар сарын 26-ны өдөр хүргүүлсэн. Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны хурлыг 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр хуралдуулан, дээрх судалгааны ажлуудын тендерийн ажлын даалгавар, тендерийн баримт бичгийг эцэслэн хэлэлцэж, баталгаажуулахад бэлэн болгоод байна. Тендерүүдийг 04 дүгээр сарын 03-ны өдөр зарлахаар товлосон боловч төсвийн хэмнэлттэй зарцуулалтын талаар СХОГ-аас өгсөн чиглэлийн дагуу жилийн хоёрдугаар хагаст гүйцэтгэхээр түр зогсоогоод байна.	40%

143	4.1.6. Хот, суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.	3. Хог хаягдлыг дахин боловсруулж, эрчим хүч, түүхий эд үйлдвэрлэх эко цогцолбор байгуулах	2017 - 2020		Хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг 20 хувьд хүргэж, байгальд булж зайлуулах хог хаягдлын хэмжээг бууруулах	Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас "Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр"-ийг боловсруулсан. Тус хөтөлбөрт Хог хаягдлыг дахин боловсруулж, эрчим хүч, түүхий эд үйлдвэрлэх эко цогцолбор байгуулах талаар тусгасан. Эко-Парк байгуулах төслийн хүрээнд паркийн ТЭЗҮ-ийг Улаанбаатар хотын Хөгжлийн корпорациар батлуулж, 2 үйлдвэр паркийн нэгжээр элсэн үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлсэн. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоотой хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллаж байна.	70%
144	4.2.8. Байгаль орчинг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, ашиглалтын үр өгөөжийг сайжруулна.	2. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаарх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх, үндэсний чадавхийг бэхжүүлэх	2017 - 2020		Хуулийн хэрэгжилтийг хангаж, генетик нөөц, түүнийг ашиглах, үр өгөөжийг хүртээх ойлголтыг төлөвшүүлэхэд чиглэсэн үндэсний чадавхи бэхжүүлэх	Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас боловсруулж буй "Генетик нөөцийн тухай" хуулийн төслийн хэлэлцүүлгийн үеэр Малын генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг 2017.12.14-ний өдрийн УИХ-ын 82 дугаар тогтоолоор баталсан "Малын генетик нөөцийн тухай" хуульд нийцүүлэхээр шийдвэрлэсний дагуу уламжлалт мэдлэгийн бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бий болгон ажиллаж байна. Хуулийн хүрээнд Малын удам зүйн үнэлгээний программыг түшиглэн уламжлалт мэдлэгийн сан бүрдүүлэхээр нэмэлт модулийг хийж мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх 28 уламжлалт мэдлэг бүртгэв. Уламжлалт мэдлэгээр бүртгэгдсэн мэдээллийг https://muz.gov.mn/ цахим хуудаст цувралаар нийтлэн олон нийтэд түгээн дэлгэрүүлж, хуулийн хэрэгжилтийг ханган, үндэсний чадавхыг бэхжүүлж байна.	100%
145	4.3.3. Гамшгаас хамгаалах эрх зүйн орчин, менежментийн тогтолцоог боловсронгуй болгож, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, эртнээс	8. Цаг агаарын гэнэтийн аюулт үзэгдлээс сэрэмжлүүлэх орон нутгийн дэд тогтолцоог дэмжин хөгжүүлэх (говь, хээрийн бүсийн аймгуудад аюулаас сэрэмжлүүлэн анхааруулах 16 цогцолбор байгуулах)	2017 - 2020		Өмнөговь аймагт 3, Дорноговь, Сүхбаатар, Дорнод аймгуудад тус бүр 1 цогцолбор байгуулах	Цаг агаарын гэнэтийн аюулт үзэгдлээс сэрэмжлүүлэх орон нутгийн цогцолборыг Дундговь аймагт туршин үр дүнд хүрсэн тул Өмнөговь, Сүхбаатар, Дорнод, Дорноговь, Дундговь аймгийн 16 суманд цаг агаарын аюулаас сэрэмжлүүлэх цогцолбор байгуулахаар БОАЖЯ-наас боловсруулсан Засгийн газрын тогтоолын төсөлд тус яамнаас 2019 оны 01/2706 дугаар албан бичгээр дэмжин хүргүүлэв.	Үнэлэх боломжгүй
146	сэрэмжлүүлэх үйл ажиллагааг	9. Хөдөө орон нутагт уур амьсгалын	2017 - 2020		Иргэдийн орлого	АХБ-ны Ядуурлыг бууруулах Японы сангийн 3.0 сая ам.долларын санхүүжилтээр "Зуд болон ой, хээрийн түймэртэй тэмцэх олон	70%

	шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, бүх нийтийн оролцоог сайжруулан, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлнэ.	өөрчлөлтөд дасан зохицох, байгалийн гамшгийн эрсдэлийг даван туулах чадавхийг бэхжүүлж, амьжиргааг сайжруулахад чиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх			нэмэгдэж, амьжиргаа сайжрах	нийтийн чадавхыг бэхжүүлэх төсөл” Дорнод, Сүхбаатар, Говь-Алтай, Хөвсгөл аймгийн 12 суманд 2017-2019 онд хэрэгжив. Үүнд: 12 сумын 53 багт бэлчээр хамгаалах бүлэг 139 бүлэг байгуулагдлаа. Гамшгийн эрсдэлийн удирдлагын чиглэлээр 80 удаагийн сургалтад 4398 хүн хамруулав. Бэлчээр хамгаалах бүлгийн гишүүд 185 өвөлжөө, хаваржаа, 19 өвс, тэжээлийн агуулах, 53 энгийн механик худаг барьж засварлав. Говь-Алтай аймгийн 3 суманд 11 гүн өрмийн худаг гаргав. 9 суманд 378 өрхийг хээрийн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх зурвасаар хамгаалав. Сумдын мэргэжлийн ангиудад 255 ширхэг гал үлээгч аппарат, 60 ширхэг гал унтраагуур, 800 ширхэг хувийн хамгаалалтын хувцас олгосноор нийт 563 өрхийн амьжиргааг хамгаалав. НҮБ-ын ХХААБ-ын Ази Номхон Далайн салбараас “Тогтвортой хөгжлийн зорилгуудад хүрэхэд чиглэсэн Ази тивийн хөдөө аж ахуйн салбарын гамшиг, уур амьсгалын эрсдэлийг даван туулах чадавхыг бэхжүүлэх төсөл”, уур амьсгалын өөрчлөлтийн эрчийг сааруулах, хүлэмжийн хийг багасгах зорилготой “Уур амьсгалд ухаалаг хандлагыг МАА-н үйлдвэрлэлд туршин нэвтрүүлэх” 165.0 мянган ам.долларын өртөгтэй төслийг 2019 оны 3 сараас хэрэгжүүлж эхлэв. 2019 онд ОУ-ын хүмүүнлэгийн тусламжаар баруун 5 аймгийн 19 сумын 1937 өрхөд 472.7 сая төгрөгийн, 2020 онд орон нутагт уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, байгалийн гамшгийн эрсдэлийг даван туулах чадавхыг бэхжүүлж, амьжиргааг сайжруулахад 16 аймгийн 130 сумын 2028 өрхөд 933.3 сая төгрөгийн бэлэн мөнгө, малын эрдэс тэжээлийн багцын дэмжлэг үзүүлж нийт 2778 өрхийн амьжиргааг хамгаалав.	
ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО							
147	5.4.10.Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд бүрэн шилжүүлэх, цагдан хорих байрны нөхцөлийг хүний жам ёсны эрхэд нийцүүлэх, ял эдлүүлэх	10. Шүүхийн шийдвэрийг биелүүлэх байгууллагаас эрчимжсэн мал аж ахуй болон газар тариалангийн аж ахуйг үе шаттай хөгжүүлэх	2017 - 2020		Экологийн цэвэр бүтээгдэхүүнээр байгууллагын хэрэгцээг бүрэн хангах	Шүүхийн шийдвэрийг биелүүлэх байгууллагаас эрчимжсэн мал аж ахуй болон газар тариалангийн аж ахуйг үе шаттай хөгжүүлэх талаар хамтран ажиллаж байна. Тухайн байгууллагын мал аж ахуй хариуцсан мэргэжилтнүүдтэй байнгын холбоотой ажиллаж, 2020 оны 3-р сард 2 мэргэжилтэн ирж мэргэжил арга зүйн зөвлөгөө авсан. Мөн гарын авлага зөвлөмж, ном олгосон. 5-р сард уулзалт зохион байгуулж малын сүргийн эргэлт зохиох талаар сургалтыг хамтран зохион байгуулав. Хорих байгууллагуудад төмс, зарим төрлийн хүнсний ногооны үр олгосны зэрэгцээ, хүнсний ногоог арчлах, тарих чиглэлээр зөвлөмж хүргүүлэн хамтран ажиллаж байна.	70%

	ажиллагаанд цахим болон теле хяналтын системийг нэвтрүүлэх, ялтныг хөдөлмөрт бүрэн хамруулах, иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн зарим ажиллагааг онлайн хэлбэрт шилжүүлэх замаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шинэтгэнэ.					
148	5.6.8.Гадаадын зах зээлд экспортлох боломжтой тэргүүлэх ач холбогдол бүхий бараа бүтээгдэхүүний судалгаа, маркетингийг төрөөс дэмжих “Монгол экспорт” хөтөлбөрийг хэрэгжүүлж, Монгол-Экспо үзэсгэлэн яармаг арга хэмжээг зохион байгуулан,	3. Хөдөө аж ахуйг хөгжүүлэх, түүний дотор махны экспортыг нэмэгдүүлэх талаар мах экспортлогч орнуудтай хамтран ажиллах, тэдгээрээс туршлага судлах, холбогдох гэрээ хэлэлцээр байгуулах	2017 - 2020	Махны экспортын хэмжээ нэмэгдэх, экспортлогч улс орны тоо нэмэгдэх	Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга тэргүүтэй төлөөлөгчид Вьетнам, Лаос улсад 2019.02.25-наас 3 дугаар сарын 01-ний өдрүүдэд ажиллаж Вьетнам улсын эрсдэлийн үнэлгээний баг манай улсад ойрын хугацаанд ажиллахаар тохиролцов. Монгол, Вьетнамын Засгийн газар хоорондын комиссын 16 дугаар хуралдаанаар тохиролцсоны дагуу Монгол Улсаас тус улсад гүн хөлдөөсөн хонь, ямаа, адуу болон үхрийн мах экспортлох талаар яриа хэлэлцээр хийж, мал эмнэлэг, эрүүл ахуйн гэрчилгээний загвар хүргүүлсэн. Мөн Монгол, Лаос хоёр улсын Мал эмнэлгийн ерөнхий газар хооронд хамтран ажиллах хэлэлцээр байгууллаа. Энэ хэлэлцээрийн дагуу манай улсаас Лаос Улсад гүн хөлдөөсөн мах, махан бүтээгдэхүүн экспортлох нөхцөл, боломж бүрдлээ. БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох хүсэлт гаргасан аж ахуйн нэгжүүдэд хянан магадлагааг 2019 оны 12 дугаар сарын 12-ны 21-ний өдрүүдэд тус улсын Гаалийн ерөнхий газрын холбогдох 6 ажилтнуудтай хамтран арга хэмжээг хэрэгжүүлсэн. Ажиллах хугацаанд БНХАУ-ын төлөөлөгчид болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мал эмнэлгийн Ерөнхий газар, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, УБ хотын гаалийн газар зэрэг	70%

	гадаад зах зээлд гарах нөхцөлийг сайжруулж, үндэсний аж ахуйн нэгж гадаадад хөрөнгө оруулах, дэлхийн санхүү, хөрөнгийн зах зээлд нэвтрэх таатай нөхцөлийг бүрдүүлнэ.				төрийн байгууллагаас мэдээ, мэдээллийг авч, махны үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд хянан магадлагааг хийж ажилласан. БНХАУ-ын ГЕГ-аас 2020 оны 4 дүгээр сард албан ёсны хариу ирүүлсэн. Уг албан бичигт Хятадын талаас хянан магадлагаанд оролцсон аж ахуйн нэгжүүдэд холбогдох зөвлөмжид тусгасан асуудлыг сайжруулж, эргэн мэдэгдэх тухай чиглэлийг өгсөн тул тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	
149	5.6.12.“Зөгийн үүр” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, гадаадад сурч, ажиллаж өндөр мэдлэг, боловсрол, технологи, ур чадвар эзэмшсэн залуучуудыг эх орондоо тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлнэ.	7. Гадаадад эзэмшсэн мэдлэг, боловсрол, ур чадвар, туршлагаа ашиглан эх орондоо хөдөлмөр эрхлэх, жижиг, дунд болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх боломжийг нэмэгдүүлэх	2017 - 2020	Залуучуудыг эх орондоо ажиллахад дэмжлэг үзүүлэх таатай орчин бүрдэх	Халдварт өвчний улмаас зохион байгуулахаар төлөвлөсөн арга хэмжээ тодорхойгүй хугацаагаар хойшлов.	Үнэлэх боломжгүй
ЗУРГАА. АЙМАГ, ОРОН НУТГИЙН ТАЛААР ТУСГАЙЛАН ОРУУЛАХ ЗААЛТУУД						
150	6.1.6.Өргөн хэрэглээний 8 нэрийн бараа бүтээгдэхүүнийг аймагтаа үйлдвэрлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.	1. Өргөн хэрэглээний 8 нэрийн бараа бүтээгдэхүүнийг аймагтаа үйлдвэрлэх хөтөлбөр хэрэгжүүлэх	2017 - 2020	Бараа бүтээгдэхүүний 80 хувийг үйлдвэрлэх	Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан.	Үнэлэх боломжгүй
151	6.1.7.Газар тариалангийн бүс нутгийг түшиглэн малын тэжээлийн	1. Газар тариалангийн бүс нутгийг түшиглэн малын тэжээлийн үйлдвэрлэлийг	2017 - 2020	Аймгийн хэмжээнд нийт бүтээгдэхүүний 60-70	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-242 дугаар тушаалаар Мал хамгаалах сангийн хөрөнгөнд байсан 4 ш тэжээлийн үрлүүр, 1 ш малын тэжээлийн үйлдвэр 3 тн-с дээш, 4 иж бүрдэл малын тэжээлийн үйлдвэрийг Архангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт шилжүүлж 4 сумыг тэжээлийн үйлдвэртэй болгож	70%

	үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	хөгжүүлэх /Эрдэнэбулган, Төвшрүүлэх, Хайрхан, Өлзийт сумдад тэжээлийн үйлдвэр байгуулах/			хувийг хангах	аймгийнхаа тэжээлийн хэрэгцээний 60 хувийг дотооддоо үйлдвэрлэх боломжийг бүрдүүлж, цаашид тухайн сум орон нутагт тэжээлийн нөөцийг тодорхой хувиар нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.	
152	6.2.4.Өлгий хот болон Дэлүүн, Булган, Ногооннуур, Улаанхус, Цэнгэл, Толбо зэрэг томоохон сумдад арьс шир боловсруулах үйлдвэр байгуулна.	3. Үйлдвэр байгуулах, ашиглалтад оруулах, үр ашигтай үйл ажиллагаа явуулахад бодлогоор дэмжлэг үзүүлэх	2017 - 2020	нийт 1,070.0 сая төг	Улаанхус, Цэнгэл сумдад үйлдвэр барих	“Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн хүрээнд тус аймагт 2017 онд малын тэжээл боловсруулах үйлдвэрт 200,0 сая.төг, 2018 онд боловсруулсан арьс ширэн болон эсгий гутлын үйлдвэрт 195,0 сая.төг, эсгийний үйлдвэрийг өргөжүүлэхэд 50,0 сая.төг, хатгамал эдлэлийн үйлдвэрийг өргөжүүлэхэд 90,0 сая.төг буюу ЖДҮХС-аас нийт 535 сая төгрөгийн санхүүжилт олгогдон, 2019 онд хоногт 500-600 оймс нэхэх хүчин чадалтай “Алтан оймс” ХХК зэрэг 5 үйлдвэр ашиглалтад бүрэн орж, шинээр 148 ажлын байр бий болсон. ХХААХҮЯ-ны дэргэдэх ХАА-н сангаас арьс шир боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийг 5 жилийн хүүгүй лизингээр авахаар “Понпа” ХХК нь арьс шир элдэх 8 ширхэг төхөөрөмж авч ажилаа эхлүүлээд байна. Хуванцар хог хаягдал боловсруулах үйлдвэр аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан бөгөөд одоогоор Азийн хөгжлийн банкны дэмжлэгээр төслийг хэрэгжүүлэхээр ТЭЗҮ, судалгааны ажил хийгдэж байна. 2020 онд ЖДҮХС-гаас олгох хөнгөлөлттэй зээлийн үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулахаар ажиллаж байна. Шинээр үйлдвэрлэл байгуулах, үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх хүсэлтэй аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл өгч, төсөл хүлээн авч иж бүрдэл шалгах шатанд байна.	70%
153	6.3.7.Ноос, ноолуур болон мал аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулна.	1. Үйлдвэрийг байгуулж ашиглалтад оруулах	2017 - 2020			ЖДҮХС-гаас савхин гутал үйлдвэрлэх 1 иргэн, 1 ААН-д нийт 75,0 сая, арьс, шир боловсруулах 1 ААН-д 20,0 сая, оёдлын 4 иргэн, 1 ААН-д нийт 100 сая.төг-ийн хөнгөлөлттэй зээлийг тус тус олгосноор, шинээр 17 ажлын байр бий болж, орон нутагт 4 иргэн, ААН үйлдвэрлэлээ өргөжүүлэн, шинээр 4 жижиг, үйлдвэр бий болсон. Ноолуур хөтөлбөрийн хүрээнд 6 суманд хоршоод түүхий эдийн анхан шатны болон ангилан ялгалт, тордолт хийх төвийг байгуулан үйл ажиллагаа явуулж, 2018 онд дотоодын зах зээлд 800 кг, гадаадын зах зээлд /Итали, Англи, Франц/ 2180 кг угаасан ноолуурыг бэлтгэн нийлүүлсэн бол, 2019 онд нийт 11,7 тн ноолуурыг ангилан, угааж, самнаж, преслэн Франц улсруу гарган, гадаад зах зээлд нийлүүлсэн. Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрийн хүрээнд 10 суманд арьс шир боловсруулах цех байгуулагдсанаас 7 цех хэвийн үйл ажиллагаа явуулж, 2019 онд нийт 54 сая.төг-ийн борлуулалт хийсэн байна. Үслэг эдлэл боловсруулах	70%

					бага оврын 300,0 сая төгрөгийн өртөгтэй үйлдвэрийг Өлзийт, Богд, Жинст, Баянлиг, Баянговь, Шинэжинст сумдад хүлээлгэн өгөөд байна. Хөнгөн үйлдвэрийн салбарын ЖДҮ-лэл эрхлэгчдийг дэмжих хүрээнд улсын төсвийн 1,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар ахуйн үйлчилгээний цогцолбор төв ашиглалтад оруулсан. Тус төвд үйл ажиллагаа явуулахаар хүсэлт гаргасан хөнгөн үйлдвэрлэлийн салбарын 20 гаруй ЖДҮ-лэл эрхлэгч байгаагаас одоогоор оёдол-7, гутал-2, үсчин-1, гоо сайхны-1, маникюр-1 нийт 12 иргэн, шинээр 28 ажлын байр гарган үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-131 дугаар тушаалаар 2020 онд ЖДҮХС-гаас хөнгөлөлттэй зээл олгох салбар чиглэлийг баталсан. Орон нутагт 04 дүгээр сарын 20-ноос 05 дугаар сарын 19-ны өдрүүдэд төсөл хүлээн авах ажлыг зохион байгуулж, 5 сумын 44 аж ахуй нэгжээс 3,9 тэрбум төгрөг хүссэн төслийг хүлээн аван, сонгон шалгаруулах шатандаа ажиллаж байна.	
154	6.3.8. Жил бүр 20-оос доошгүй инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргаж, 50-аас багагүй газарт усны хайгуулын ажил хийнэ.	1. Хайгуул хийсний үр дүнд инженерийн хийцтэй гүн өрмийн 80 худаг гаргах, хайгуулын ажлыг 200 цэгт хийх	2017 - 2020	Усны хайгуулын ажлыг 50 цэгт хийх, шинээр 20 инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргах	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэмэлт санхүүжилт төслийн санхүүжилтээр Баянхонгор аймагт “Энх-сүлд” ХХК, Өмнөговь, Дорноговь аймагт “Эрдэнэдрилинг” ХХК, Дорнод аймагт “Ус-Амьдрал” ХХК-тай нийт 81 бэлчээрт 102.1 сая төгрөгийн хөрөнгөөр уст цэг тогтоох газар доорх усны геофизикийн хайгуулын ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. Баянхонгор аймагт “Энх-сүлд” ХХК, Дорнод аймагт “Ус-Амьдрал” ХХК ний хээрийн ажил бүрэн дуусаж Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А-77 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг орон нутагт хүлээлгэн өгсөн акт, тэмдэглэлийг үндэслэн хүлээн авч ажлын хэсэг хүлээн авч, гэрээг дүгнэв. Баянхонгор аймгийн Баянговь, Баацагаан, Бууцагаан, Богд сумдын бэлчээрийн 20 газарт газар доорх усны хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэсэн “Энх-сүлд” ХХК-ний гэрээний хэрэгжилтийг дүгнэж санхүүжилтийг олгуулахаар төслийн нэгжид хүргүүлэв. Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт” төслийн санхүүжилтээр Баянхонгор аймгийн Богд, Шинэжинст, Баянговь, Жинст, Баацагаан сумдад инженерийн хийцтэй 5 худаг гаргах ажлыг гүйцэтгэхээр “Чорьж бүрд” ХХК-тай гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна.	70%
155	6.4.2. Булган аймгийн газар тариалан эрхлэгчдийг дэмжих зорилгоор Хутаг-Өндөр суманд 15000 тн багтаамжтай үр тариа хадгалах	1. Газар тариалан эрхлэгчдийг дэмжих зорилгоор Хутаг-Өндөр суманд 15000 тн багтаамжтай үр тариа хадгалах	2017 - 2020		2014 онд БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр уг элеваторг байгуулахаар ТЭЗҮ-ийг боловсруулсан. Элеватор байгуулах тендер шалгаруулалтад БНХАУ-ын Синоконст компани шалгарч гэрээ байгуулан хөрөнгө оруулалтыг Хятад улсын Экзим банкнаас санхүүжүүлэхээр гэрээнд тусгасан байсан боловч Монгол Улсын ҮАБЗ төслийг хэрэгжүүлэхээс татгалзсанаар энэ ажил	40%

	Өндөр суманд 15000 тн багтаамжтай үр тариа хадгалах элеваторын барилгыг барих	элеваторын барилгыг барих			цуцлагдсан. ТЭЗҮ-ээр энэ бүс нутагт элеватор байгуулж тариалангийг үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлага чухал болохыг заасан. Ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.	
156	Өндөр суманд 15000 тн багтаамжтай үр тариа хадгалах элеваторын барилгыг барих, аймгийн төв, Хутаг-Өндөр сумдад төмс, хүнсний ногоо хадгалах механикжсан зоорь барина.	2. Аймгийн төв, Хутаг-Өндөр сумдад төмс, хүнсний ногоо хадгалах 5000 тн багтаамжтай механикжсан зоорь барих	2017 - 2020		БНПУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх "хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх" төслийн хүрээнд тус зоорийг байгуулахаар төлөвлөж байсан. Төслийн 2-р багц болох хүнсний ногооны зоорь байгуулах хэсэгт энэ зорилтыг багтаасан. 2017-2019 онуудад зөвхөн БНПУ-ын аж ахуйн нэгжүүд оролцох хязгаарлагдмал нөхцөлтэй тендер шалгаруулалтыг 3 удаа зохион байгуулсан боловч Польшийн аж ахуйн нэгжүүдийн тендер нь захиалагчийн баталсан техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй үндэслэлээр цуцлагдсан. Монгол Улс Польш улсын хоорондын нөхцөлт зээлийн хэлэлцээрийн хугацааг сунгаагүй байгаа учраас хэрэгжилт хүлээгдэж байна. Төслийг хэрэгжүүлэх асуудлаар Гадаад харилцааны яам, Сангийн яам, ХХААХҮЯ хамтран ажиллаж байна.	40%
157	6.4.3.Мах боловсруулах дунд зэргийн хүчин чадал бүхий үйлдвэрийг Булган, Дашинчилэн сумдад байгуулна.	1. Мах боловсруулах дунд зэргийн хүчин чадал бүхий үйлдвэрийг Булган, Дашинчилэн сумдад байгуулах	2017 - 2020		Булган суманд "Бүрэн луу" ХХК нь мал бэлтгэх, мах хадгалах хөргүүртэй агуулахыг өөрийн хөрөнгөөр үргэлжүүлэн гүйцэтгэж, 1,2 га талбай бүхий газарт хашаа барих, цахилгаан татах, худаг, бохирын цооног гаргаж ажилласан. Үүний зэрэгцээ 8 х 12 харьцаа бүхий барилгын өргөтгөлийг барьж, ашиглалтад өгөхөд бэлэн болгосон байна. Дашинчилэн суманд "Булган хөгжил" корпораци болон Турк улсын хамтарсан хөрөнгө оруулалтаар мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэр байгуулахаар 5 га газрын зөвшөөрөлийг 2019 оны 4-р улиралд Иргэдийн хурлаар шийдвэрлүүлж авсан. Турк улсаас үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмжийг нийлүүлэх, угсрах ажлыг тус улсын ажилчид гүйцэтгэхээр төлөвлөж байна. Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан хүлээгдэж байна.	70%
158	6.7.3.Арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэрийг байгальд ээлтэй цогцолбор хэлбэрээр хөгжүүлнэ.	1. Арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэрийг байгальд ээлтэй цогцолбор хэлбэрээр хөгжүүлэх	2017 - 2020	Боловсруулах үйлдвэрийн цогцолборын эхний ээлж ашиглалтад орох	Дархан-Уул аймгийн Хонгор сумын 1-р багийн нутаг дэвсгэр, 180 га газарт байгуулах Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалтад нийт 254 сая ам.доллар шаардлагатай бөгөөд МУЗГ-ын 2019 оны 356 дугаар тогтоолоор дэд бүтцийн төсөлд 56.3 сая ам.долларыг Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Зээлийн гэрээ байгуулах тухай 2020 оны 01/1332 дугаар албан бичгийг Сангийн яаманд хүргүүлж, зээлийн хүүгийн татаас 15 тэрбум төгрөгийг олгох ажлын хүрээнд бодлогын гэрээ байгуулав. Цахилгаан түгээх, дамжуулах дэд станцын барилга, дулааны шугам хоолой татах, ноос угаах, самнах үйлдвэрийн барилгын ажлууд хийгдэж байна. Бохир ус цэвэрлэх байгууламжийн ТЭЗҮ-г Итали улсын Deltacque компаниар хийж гүйцэтгүүлэн, 420 м2	70%

					цэвэрлэх байгууламжийн мембран угсралтын ажил бүрэн дуусаж, чийгийн хамгаалалттай азвустан хөөсөн хавтангаар суурийн дулаалгын ажлыг эхлүүлэн, арматур, бетон угсралтын тооцоог гаргасан. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн өгсөн чиглэлийн дагуу цогцолборт үйл ажиллагаа явуулах, хамтран гүйцэтгэгчээр орох компаниудтай Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны гэрээ байгуулан, бүтээн байгуулалтын ажил болон үйлдвэрүүдийн байршил төлөвлөлтийг хийж байна. 2020 онд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн эхний 3 блокны ноос боловсруулах үйлдвэрийн барилгын ажил 86%, дэд станцын угсралт 90%, барилга байгууламж нь 50%, бохир ус цэвэрлэх байгууламжийн ажлын цутгалт 30% хувьтай байна. Богийн арьс шир боловсруулах үйлдвэрийн газар шорооны ажил эхлээд байна.	
159	6.11.3.Аймагтаа хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулахыг дэмжинэ.	1. Тэлмэн суманд хөдөө аж ахуйн үйлдвэрийн цогцолбор байгуулах ажлын хүрээнд суурьшлын бүсийн зураг төсвийг боловсруулах	2017 - 2020		"Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийн хүрээнд Завхан аймагт 150.0 сая төгрөгийн өөрийн хөрөнгө оруулалтаар хоногт 0.5 тн жимс жимсгэнэ боловсруулах хүчин чадалтай бага оврын үйлдвэр байгуулж, шинээр 5 ажлын байр бий болгосон. ЖДҮХСангийн 100.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр Алдархаан суманд баригдсан сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр, АДРА ОУБ-ын 155.0 мянган ам долларын хөрөнгө оруулалтаар Идэр суманд баригдсан бяслагны үйлдвэрийн барилгын ажил тус тус бүрэн дуусаж, олон улсад дэгдсэн шинэ коронавирус (Covid 19)-ийн халдвартай холбогдуулан өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин, хилийн зарим боомтыг түр хааснаас тоног төхөөрөмж суурилуулах ажил түр зогсоод байна. ЖДҮХСангаас ноос боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Булгансорхишиг ХХК-д 120.0 сая, арьс, шир боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Эрхэттунамал ХХК-д 200.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг тус тус олгож, ноос самнах болон эсгийний үйлдвэрүүд 2020 оны 04 дүгээр сараас үйл ажиллагаа эхэлж, шинээр 32 ажлын байр бий болгосон. ЖДҮХСангаас 7 аж ахуйн нэгжид нийт 998.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 2019 онд олгосон байна. Улиастай суманд Баяжихсүрэг ХХК 100.0 сая төгрөгийн өөрийн хөрөнгө оруулалтаар хоногт 100 бог, 20 бод нядлах хүчин чадалтай мал нядалгааны цех ашиглалтад ороод байна. Тосонцэнгэл суманд Баян ньуу фүүд сентури ХХК 2.0 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгө оруулалтаар хоногт 500 бог, 200 бод нядлах хүчин чадалтай мах боловсруулах үйлдвэрийг 2020 оны 06 дугаар сард ашиглалтад оруулахад бэлэн болоод байна. Батдэлгэр ХХК нь нийт 875.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 775.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар, 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг ЖДҮХСангаас	70%

					санхүүжүүлэхээр төслөө ирүүлээд байгаа бөгөөд тус үйлдвэрийнхээ тоног төхөөрөмжийг суурилуулалт 70 хувьтай байна.	
160	6.12.7.Зоорьтой хүнсний зах байгуулж, төмс, хүнсний ногооны хангамжийг эрс сайжруулна.	1. Зоорьтой хүнсний зах байгуулж, төмс, хүнсний ногооны хангамжийг эрс сайжруулах	2017 - 2020	Хүн амын төмс хүнсний ногооны хангамжийг жилийн турш жигд тогтвортой хангах	Улаанбаатар хотод төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, махны хадгалалт борлуулалтын төв байгуулах ТЭЗҮ, зураг төслийг боловсруулсан. Нийслэлээс СХД-ийн 20-р хороо, сонсголонгийн гүүрний орчим 9,6 га газрын асуудлыг шийдвэрлэсэн. ТЭЗҮ-д байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийлгэсэн. Төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтыг бүрдүүлэх талаар Монгол Улсын 2020 оны 138 дугаар тогтоолоор БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр Сангийн яаманд чиглэл өгсөн. ХХААХҮ-ийн яамнаас тогтоолыг хэрэгжүүлэхээр саналаа сангийн яаманд хүргүүлсэн. Монголбанктай хамтран төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын талаар арилжааны банкуудыг оролцуулсан хэлэлцүүлгийг 2020 оны 5 дугаар сард зохион байгуулсан.	70%
161	6.15.1.Ноолуур, ноос угаах самнах, ээрэх зэрэг хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулахыг дэмжинэ.	1. Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах төв байгуулах	2017 - 2020	ХАА-н боловсруулах үйлдвэрүүд байгуулагдах	- "Сүхбаатар хөгжил" ҮТП байгуулах ажлын хүрээнд Баруун-Урт сумын 2-р багийн ЖДҮ-ийн бүсэд орон нутгийн төсвөөс 1.5 тэрбум.төг-ийн хөрөнгө оруулалт, 8-р багийн хөдөө, аж ахуйн түүхий эд боловсруулах бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Орон нутаг хөгжүүлэх сангийн санхүүжилтээр хийлгэсэн. Паркийн дэд бүтцийг сайжруулахад 1 тэрбум.төг батлагдаж, зураг, төсөв батлуулан тендер худалдан авах ажиллагааг явуулах бэлтгэл ажлыг хангаад байна. - ЖДҮХС-аас 9 иргэн, ААН-д нийт 1,0 тэрбум.төг олгосон. Дарьганга сумын ЗДТГ орон нутаг хөгжүүлэх сангаас 30,0 сая.төг-өөр Хуурай сүүний үйлдвэрийн барилгын ажлыг хийж дуусгасан. - Баруун-Урт сумын "Гүн тойром" ХХК, Сүхбаатар сумын "Мөнх сүрэг" ЗБННөхөрлөл зэрэг ААН мал аж ахуйн гаралтай түүхий эдийн анхан шатны /арьс шир элдэх/ боловсруулалт хийх тоног төхөөрөмж авах хүсэлтээ ирүүлээд байна. - "Сүхбаатар Проимпекс" ХХК оёдлын үйлдвэрт 2018 онд ЖДҮХС-гаас 200,0 сая.төг-ийн санхүүжилт олгон, хатуу болон зөөлөн оёдлын 2 цехтэй, нийт 45 ажилчинтайгаар уул уурхайн даацын шуудай, хөдөлмөр хамгааллын хувцас, бүх төрлийн оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Хөнгөн үйлдвэрийн чиглэлээр 2019 онд "Тэнүүн билиг арвижих" ХХК нь 40000 шир/сар цаасан уут үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг 120.0 сая төг-ийн өөрийн санхүүжилтээр байгуулж, 3 хүнийг ажлын байраар хангасан. ЖДҮХС-аас Баруун-Урт сумын иргэн Октябрь модон эдлэлийн чиглэлээр 35.0 сая.төг, Мөнххаан сумын иргэн Т.Төмөртоогоо арьсан гутлын үйлдвэрлэлийн чиглэлээр 20.0 сая.төг-ийн зээлийг тус тус олгосон. - Түмэнцогт сумын Бундууш ХХК нь мах боловсруулах үйлдвэрийн чиглэлээр 190,0	70%

					сая.төг-ийн хөнгөлөлттэй зээл авч, үйл ажиллагаагаа явуулж байна. Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоол, ХХААХҮСайдын 2020 оны А-131 дугаар тушаалыг хэрэгжүүлэх хүрээнд ЖДҮХС-гаас хөнгөлөлттэй зээл олгох төсөл хүлээн авах ажлыг 04 дүгээр сарын 20-ноос 05 дугаар сарын 19-ны өдрүүдэд зохион байгуулж, 30 аж ахуй нэгжээс 3,1 тэрбум.төг-ийн санхүүжилт хүссэн төслийг хүлээн аван, сонгон шалгаруулах шатандаа ажиллаж байна.	
162	6.16.3.Сум бүрт төмс хүнсний ногооны зоорь барьж, ногоог жилийн туршид хадгалах, борлуулах боломжийг бүрдүүлнэ.	1. Сум бүрт төмс, хүнсний ногооны зоорь барих	2017 - 2019		Монгол Улсын хэмжээнд төмс, хүнсний ногоо хадгалах зориулалттай 212,2 мянган тонн багтаамжтай 10,0 мянга гаруй зоорь ашиглаж байна. Сэлэнгэ аймгийн Жавхлант суманд хүнсний ногооны 100 тонн багтаамжтай зоорь, Баян-Өлгий аймгийн Баяннуур суманд 200 тонн багтаамжтай зоорь, Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд 500 тонн багтаамжтай зоорь, Ховд аймгийн Жаргалант суманд 1000 тонн багтаамжтай зоорь байгуулсан. Хувийн өмчийн хөрөнгө оруулалтаар улсын хэмжээнд сүүлийн 4 жилд 10,9 мянган тонн багтаамжтай зоориудыг аймаг суманд байгуулсан байна.	100%
163		2. Улаанбаатар хотод Сэлэнгэ аймгийн ногоочдын төмс, хүнсний ногоо хадгалах нэгдсэн зоорь барих /1000 тн/	2017		Азийн хөгжлийн банкны тусламжаар хэрэгжүүлж байгаа хоршоолсон хэлбэрээр хүнсний ногоо эрхлэх замаар өрхийн амьжиргааны түвшинг сайжруулах төслөөр Улаанбаатар хотод 1000 тонн багтаамжтай зоорийн түрээсийн төлбөрийг шийдвэрлэж ногоочдын төмс хүнсний ногоог үнэгүй хадгалах үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн. монголын хөдөөг шинэчлэх фермерүүдийн холбооны сонгинохайрхан дүүрэгт байрладаг механикжсан зоорь юм.	100%
164	6.16.4.Сүхбаатар, Мандал, Сайхан суманд сүүний үйлдвэр, бусад сумдад сүү хөргөх төхөөрөмж бүхий цех байгуулна.	1. Сүхбаатар, Мандал, Сайхан сумдад сүүний үйлдвэр, бусад сумдад сүү хөргөх төхөөрөмж бүхий цех байгуулах	2017 - 2019		Сэлэнгэ аймгийн Мандал суманд "Ундрах түм" ХХК-иас санаачлан хоногт 0,5 тн сүү хүлээн авч боловсруулах жижиг цех байгуулахаар ажиллаж байна. Энэ оны 5-р сараас шингэн сүү хүлээн авна. Мөн Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Сайхан сумдад хоногт 5 тн шингэн сүү хүлээн авах "Сүүн зам" хөргөлтийн цех, хоногт 5 тн шингэн сүү хүлээн авах "Сүүн наян найм" хөргөлтийн цехүүдийг тус тус байгуулан сүү хүлээн авахад бэлэн болсон. Туршилтаар сүү хүлээн авч байна.	100%
165	6.17.2.Малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь өргөжүүлэх аж ахуйн нэгж, иргэдийг дэмжинэ.	1. Малын тэжээлийн тариалалтын бүс нутгийг тогтоож, тэжээлийн ургамлын үрийн нөөцтэй болгох, малын тэжээлийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлж,	2017 - 2020	Сумдад байгуулсан 5 үйлдвэрийн үйл ажиллагаа жигдрэх	Төв аймгийн Баянцогт, Лүн сумдад тус бүр багсармал тэжээлийн үйлдвэр, Баянчандмань суманд хүнсний ногооны хаягдал боловсруулах үйлдвэр, Сүмбэр суманд хорголжин тэжээлийн үйлдвэр, мөн суманд багсармал тэжээлийн үйлдвэрүүдийг 2017-2019 онд байгуулсан. Төв аймгийн Цээл суманд үйл ажиллагаа явуулж байгаа "Хүүлэй хааны хишиг" ХХК манай улсад нутагшсан бургалтай сортын царгасны үрийг 2017 онд 720 га-д үржүүлэх болон тариалах ажлыг зохион байгуулсан. 2018 онд царгасны 7000 кг үр хураан авсан ба Төв аймгийн Зуунмод сум, Батсүмбэр сум, Аргалант сум,	100%

		эрчимжсэн аж ахуйн тэжээлийн хэрэгцээг хангах, малын тэжээлийн үйлдвэрийг 5-с доошгүй сумдад байгуулах			Мөнгөнморьт сумдад тус бүр 40 га-д тариалалт хийж сумын аюулгүй нөөц, эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн тэжээлийн хэрэгцээний 30 хувийг хангаж ажилласан. "Хүүлэй хааны хишиг" ХХК нь 2019 онд Төв аймгийн Цээл суманд үр үржүүлгийн талбайгаа 214 га-аар нэмэгдүүлэн 15 мянган кг царгасны үрийг хурааж авч, тэжээлийн ургамал царгасын үрийн нөөцтэй болж, царгас тариалалтыг нэмэгдүүлж, эрчимжсэн аж ахуйн тэжээлийн хэрэгцээг хангахад чухал үүрэг гүйцэтгэсээр байна. Мөн 2020 онд нийт 700 га талбайд царгас тариалж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Төв аймгийн Лүн, Сүмбэр суманд 2017 онд байгуулагдсан багсармал тэжээлийн үйлдвэрүүд хэвийн ажиллаж, үйл ажиллагаа нь явагдаж байна.	
166	6.18.3.Малын гаралтай түүхий эд, жимс, жимсгэнэ, хүнсний ногоо боловсруулах жижиг, дунд үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	1. Дулааны аргаар мах боловсруулах үйлдвэр байгуулах	2018		Хөтөлбөрийн хүрээнд 2017 онд "Хүмэн нэгдэл" ХХК нь дулааны аргаар мах боловсруулах үйлдвэр байгуулах зорилгоор ЖДҮХСангаас 1,6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдан үйлдвэрийн бүтээн байгуулалтын явц 50 хувьтай явж байна. Үйлдвэрийн тоног төхөөрөмжөө оруулж ирсэн. Одоо газар доорх инженерийн шугам сүлжээний ажил хийгдэж байна. 2020 оны 6 сард ашиглалтанд бүрэн оруулна. Энэ үйлдвэр ашиглалтанд орсноор 70-80 ажлын байр шинээр бий болж нэг ээлжиндээ 40-50 бод, 120-150 бог бэлтгэж, жилдээ 1000 тн малын мах, 600 тн хагас болон бэлэн боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр бий болно. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ эхний ээлжинд дотоодын зах зээлд нийлүүлж, цаашид хүнсний аюулгүй байдлын HACCP, ISO тогтолцоог нэвтрүүлж баталгаажуулснаар ангилж савлан шинэ болон хөлдөөсөн мах, төрөл бүрийн хиам, махан бүтээгдэхүүн, махан нөөш, дотор махан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортлохыг зорьж байна.	70%
167		2. Сүүний үйлдвэр байгуулах	2019		Булган аймгийн Булган суманд "Бүрэн луу" ХХК-иас санаачлан хоногт 5 тн сүү хүлээн авч боловсруулах үйлдвэр байгуулахаар 2019 онд ХХААХҮЯ-ы Жижиг дундын үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн сонгон шалгаруулалтад шалгарч 674,0 сая төгрөгийн зээлийн дэмжлэг авсан. 2020 оны 2-р сард ашиглалтад бүрэн орсон. Одоогоор малчдаа сүү хүлээн авч эхлээд байна. Баянхонгор аймгийн Эрдэнэцогт суманд Хангайн бүсийн сумдын малчдыг түшиглэн сарлагийн сүү бэлтгэл-үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашигтай бренд бяслаг, гаргах үйлдвэрийг өргөжүүлэх төслийн баримт бичиг боловсруулж 2019 оны 12 сард ХХААХҮЯ-ы Жижиг дундын үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн сонгон шалгаруулалтад шалгарч 200,0 сая төгрөгний зээл авсан. 2020 онд үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр БНЭУ-аас тоног төхөөрөмж авахаар захиалга хийгдсэн. Энэ оны 5-р сараас малчдаас	100%

					сүү хүлээн авч эхэлнэ. НҮБ-ын ХХААБ-ын "Монгол улсад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" төслийн хүрээнд Ховд аймгийн Чандмань суманд хоногт 400 литр сүү хүлээн авах хүчин чадалтай бага оврын үйлдвэр төр хувийн хэвшлийн оролцоотой байгуулагдаж орон нутагт ажлын байр нэмэгдүүлж, малчдын орлогыг өсгөхөд эерэг нөлөө үзүүлэн ажиллаж байна.	
168		3. Хүнсний ногоог вакуумжуулсан аргаар боловсруулах үйлдвэр байгуулах	2018		Хүнсний ногоог дахин боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор орон нутагт хүнсний ногоо дахин боловсруулах цех, ажлын байр засварлах, үйлдвэрлэл эрхлэхэд тавигдах шаардлага болон тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны чиглэлээр сургалтууд хийгдсэн байна. 2019 оны байдлаар орон нутагт нийт 7 цех ашиглалтанд орсноор 30 гаруй ажлын байр бий болох боломж бүрдлээ. Эдгээр цехүүд 2019 онд 8,000 орчим ширхэг шилэнд нөөшилсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 200 кг ногоо хатааж зах зээлд борлуулсанаар нийт 26 сая төгрөгийн орлоготой ажиллажээ.	70%
169		4. Малын арьс шир, ноос боловсруулах үйлдвэр байгуулах	2018 - 2019		Улаангом хотод арьс шир боловсруулж, гутал үйлдвэрлэдэг 2 үйлдвэр 600 сая.төг, мах боловсруулах чиглэлээр 1 ААН ЖДҮДС-аас 28,5 сая.төг-ийн санхүүжилт авч, үйл ажиллагаагаа эхэлсэн. Ноос угаах чиглэлээр 500,0 сая.төг, модон эдлэлийн чиглэлээр 315,0 сая.төг-ийн батлан даалттай зээлд хамрагдсан. Ээлжиндээ 2000 кг бэлэн бүтээгдэхүүн боловсруулж, хоногт 40 бод, 150 бог нядлах хүчин чадалтай үйлдвэр байгуулахаар ЖДҮДС-аас 1,6 тэрбум.төг-ийн зээл авч, барилгын ажил 90%-ийн гүйцэтгэлтэй байна. ЖДҮХС-ийн хөнгөлөлттэй зээлд ноос ноолуур, арьс шир, оёдол, модон эдлэлийн чиглэлээр 11 иргэн, ААН хамрагдаж, 665,0 сая.төг-ийн санхүүжилт авч, үйл ажиллагаагаа өргөтгөсөн. Сагил, Түргэн сумдад шинээр хоршоо байгуулан сүү, арьс нэхий боловсруулах цехүүд ашиглалтад орсон. Хархираан хөгжил ХХК нь ЖДҮХС-аас 1,0 тэрбум.төг-ийн зээл авч, сүүний чиглэлийн 63 үнээний фермер, 1000 л/хон сүү боловсруулах хүчин чадалтай үйлдвэр байгуулан, бүтээгдэхүүнээ худалдаанд гаргаад байна. Чацаргана боловсруулах тоног төхөөрөмж, технологи сайжруулах, хөргөлттэй зоорь барих чиглэлээр 3 ААН 180,0 сая.төг-ийн хөнгөлөлттэй зээлд хамрагдан үйл ажиллагаагаа өргөтгөн, 12 ажлын байр шинээр нэмэгдүүлсэн. Арьс шир боловсруулах тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй нөхцлөөр авахаар 4 хоршоо, 1 компани материал бүрдүүлэн ирүүлээд байна. Үндэсний хөгжлийн газар болон GIZ ЭТИС хөтөлбөр хамтран хэрэгжүүлж байгаа "Шинэ технологийг дэмжих хөтөлбөр", "Ногоон технологийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд 1 ААН дэмжигдэн хонины	70%

					ноосон дулаалгын материал үйлдвэрлэж байна. “Увсад хөрөнгө оруулагчдын чуулга-2019”-н үеэр нийт 77,6 гаруй тэрбум.төг-ийн 18 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх санамж бичигт гарын үсэг зурсан бөгөөд мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, ноос угаах үйлдвэр, хүнсний ногооны төсөл зэргүүдэд нийт 29,5 тэрбум.төг-ийн төслийг төр, хувийн хэвшлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр болсон. Үүний дүнд 2020 онд Од вүүл кашмер ХХК Тариалан сумын нутагт ноос ноолуур угаах үйлдвэр барихаар газраа авч, бэлтгэл ажлыг хангаад байна.	
170		5. Чацарганыг кластержуулж хөгжүүлэх, боловсруулах үйлдвэрийн технологийг шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлэх	2017 - 2018		Европын холбооны санхүүжилтээр хэрэгжиж буй “Монголын худалдааг дэмжих” TRAM төслийн хүрээнд “Чацарганын кластер байгуулах” төсөл хэрэгжүүлж чацарганын кластерт оролцогчдыг бүртгэлжүүлэн хамтын санамж бичиг байгуулан, удирдах зөвлөлийг сонгож хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган ажиллаж байна. 2020 оны 1 дүгээр сард Герман улсад зохиогдсон Green week хүнсний бүтээгдэхүүний олон улсын үзэсгэлэнд тус төслөөс 11.0 мянган еврогийн санхүүжилт зардал гарган стенд түрээсэлж чацаргана боловсруулах 4 үйлдвэрийн бүтээгдэхүүнийг оролцуулж олон улсад сурталчлав. Чацаргана жимсний нитэг, үр, хальсны найрлага, биологийн идэвхт нэгдлийг сортоор тодорхойлох, тэдгээрийг боловсруулах технологи, амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүнд баяжуулагчаар ашиглан эрүүл мэндийг дэмжих үйлдэлтэй хүнсний технологийн шийдэл гаргах ШУТ-ын төслийг ШУТИС-д 2021 оноос хэрэгжүүлэхээр тус яамнаас шийдвэрлэв. АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд “Чацаргана боловсруулах үйлдвэрүүдэд хүнсний чанар аюулгүй байдлын олон улсын стандартыг нэвтрүүлэх” зөвлөх үйлчилгээний гэрээг Обзерв стар ХХК-тай байгуулан төсөлд оролцсон чацаргана боловсруулах 8 үйлдвэрт олон улсын чанарын удирдлагын тогтолцооны талаар цогц 18 төрлийн сургалт явуулж тус сургалтад идэвхтэй оролцож дотоодын баталгаажуулалтаар хангалттай үнэлгээ авсан “Еден” ХХК, “Увс Хүнс” ХК-д олон улсын баталгаажуулалтын байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэн ISO 9001 чанарын удирдлагын тогтолцооны гэрчилгээ авав.	70%
171	6.19.7.Малын гаралтай түүхий эд болон ноос ноолуур боловсруулах	1. Малын гаралтай түүхий эд болон ноос ноолуур боловсруулах үйлдвэр байгуулах	2017 - 2018		Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрийн хүрээнд 7 үйлдвэр баригдахаас төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 3 үйлдвэр баригдсан байна. Жаргалант суманд малын гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Саруул цамхаг” ХХК гүйцэтгэж 100 хүнийг түр ажлын байраар ханган ажлын гүйцэтгэл	70%

	үйлдвэр байгуулна.					70% хийгдэж, 2020 оны 08 дугаар сард ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Ингэснээр Ховд аймагт үйлдвэр технологийн парк байгуулагдаж дагалдах ноос ноолуур арьс шир гүн боловсруулах үйлдвэрүүд байгуулагдах боломж бүрдэж байна. Засгийн газрын 2015 оны 335-р тогтоолд Баруун бүсэд барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор Буянт сумын нутагт “Вестерн Холд” ХХК-н 360000 тн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг барьж ашиглалтад оруулахаар газар шорооны ажил хийгдэж, 250 хүнийг ажлын байраар ханган ажиллаж байна. “Чинээлэг заан” ХХК 2019 онд явган замын хавтангийн үйлдвэрлэлээ өргөтгөхөөр 50.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч, жилдээ 5000-10000 м2 явган замын хавтан үйлдвэрлэж, 9 хүнийг улирлын чанартай ажлын байраар хангаж байна. Барилгын хөнгөн блок үйлдвэрлэн аймгийн төв болон зэргэлдээ аймгуудад нийлүүлж байна.	
172	6.19.9.Малын гаралтай түүхий эдийн боловсруулалтын цэвэрлэх байгууламж барина.	1. Малын гаралтай түүхий эдийн боловсруулалтын цэвэрлэх байгууламж барих	2017			Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийн хүрээнд Ховд аймгийн Жаргалант суманд “Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн барилга байгууламж”-ыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Саруул цамхаг” ХХК гүйцэтгэж, 100 хүнийг түр ажлын байраар ханган, ажлын гүйцэтгэл 70% хийгдэж, 2020 оны 08 дугаар сард ашиглалтад оруулахаар ажиллаж байна.	70%
173	6.21.2.21:100 хөтөлбөрийн хүрээнд арьс шир боловсруулах, ноос ноолуур угаах үйлдвэрийг барихыг дэмжинэ.	1. Арьс, шир боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулах	2017 - 2020		Үйлдвэр ашиглалтад орох	Хэрлэн сумын 4-р багт арьс боловсруулах анхан шатны цех, Өмнөдэлгэр болон Мөрөн сумдад хонины нэхий элдэх анхан шатны цехүүдийг иргэд өөрийн хөрөнгөөр тус тус байгуулж, үйл ажиллагаагаа явуулж байна. Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр Хоршоог хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд Хэрлэн сумын 3-р багт 7 сая төгрөгийн үнэ бүхий хонины нэхий элдэх тоног төхөөрөмжийг нийлүүлэн ашиглалтад оруулахад бэлэн болж, сонгон шалгаруулалт зарлаад байна. Мөн Хэрлэн суманд Эвт түмэн ХХК 2013 оноос хойш ноос угаах үйлдвэрлэл эрхэлж байгаа бөгөөд 2019 оноос ноолуур угааж эхлээд байна. “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийн хүрээнд Хэрлэн суманд жилд гэрийн мод 50-60, зүймэл модон хавтан 2000ш, хаалга 300, авдар-300 хийх хүчин чадалтай мод, модон эдлэлийн үйлдвэр, 2000 тн малын тэжээлийн боловсруулах хүчин чадалтай үйлдвэр, 1000 бог, 500 бодын дайвар бүтээгдэхүүн боловсруулах хүчин чадалтай үйлдвэр, Баянхутаг суманд 40-60 тн хуурай сүү боловсруулах хүчин чадалтай үйлдвэр байгуулан үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. Мөн аймгийн ЖДҮДДСангийн хөнгөлөлттэй зээлд Хэрлэн сумын иргэн мод, модон бүтээгдэхүүний чиглэлээр дэмжигдэж	70%

						45,0 сая төгрөгийн зээлийн санхүүжилт авч, өргөтгөлийн ажил хийгдсэн.	
--	--	--	--	--	--	---	--